



**САНГИЙН ЯАМ**

**ЯДУУРЛЫН СУДАЛГААНЫ НЭГЖ**

**ЯДУУРЛЫН СУДАЛГАА, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ**

**ДЭМЖИХ МОН01/Ю01 ТӨСӨЛ**

**ЯДУУ ӨРХИЙН АМЬЖИРГААНД ҮЗҮҮЛЭХ  
АХУЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН НӨЛӨӨЛӨЛ  
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

(УЛААНБААТАР ХОТЫН 200 ӨРХИЙН ЖИШЭЭН ДЭЭР)

Улаанбаатар хот, 2005 он



---

## Талархал

Улаанбаатар хотын өрхийн ахуйн хэрэглээ, өрхийн амьжиргаанд үзүүлэх ахуйн хэрэглээний үнийн нөлөөлөл, эдгээрт нөлөөлж байгаа хүчин зүйлсийг судлах зорилго бүхий судалгааг Монгол улсын Засгийн газар, НҮБХХ-ын захиалга, санхүүжилтээр “Нийгмийн Хөгжлийн Төв” (ТББ)-ын судалгааны баг хийж гүйцэтгэлээ.

Энэхүү судалгаа нь Улаанбаатар хотын өрх, ялангуяа ядуу, эмзэг өрхийн ахуйн хэрэглээний зарим гол бүтээгдэхүүний үнийн нөлөөлөл, үнэд нөлөөлж буй хүчин зүйлсийг нарийвчлан судалж, тодорхой бодлогын зөвлөмжийг боловсруулан гаргаж байгаа анхны оролдлого юм. Энэ утгаараа түүний ач холбогдол оршино. Ийнхүү судалгааны хүрээнд судалгааны арга зүйг тодорхойлох, цаашид боловсронгуй болгохтой холбоотой туршлагууд нилээд хуримтлагдсан билээ. Чанарын болон тоон судалгааны аргуудыг судалгааны үндсэн арга зүй болгон, үр дүнг нэгтгэсэн тайланг та бүхэнд толилуулж байна.

НҮБХХ, Сангийн яамны “Ядуурлын Судалгааны Нэгж”, “Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих МОН01/Ю01 төсөл”-ийн багийнхан болон судалгааг явуулахад дэмжлэг туслалцаа үзүүлсэн дүүрэг хороодын Засаг дарга, түүний ажлын алба, ялангуяа хэсгийн ахлагч нарт, мөн судалгаанд хамрагдаж бидний ажилд үнэтэй мэдээлэл өгсөн нийт айл өрхийн гишүүдэд талархаж байгаагаа уламжилъя.



Р. Гантөмөр  
Гүйцэтгэх захирал  
“Нийгмийн Хөгжлийн Төв”

---

## Товчилсон нэрсийн тайлбар

<b>АНУ-ын ОУХА</b>	АНУ-ын Олон улсын Хөгжлийн Агентлаг
<b>АХБ</b>	Азийн Хөгжлийн Банк
<b>АТТС</b>	Амьжиргааны түвшин тогтоох судалгаа
<b>АҮК</b>	Ашигт үйлийн коэффициент
<b>ДБ</b>	Дэлхийн Банк
<b>ДЦС</b>	Дулааны цахилгаан станц
<b>Дүүрэг</b>	Хот суурин газрын засаг захиргааны нэгж
<b>ЗДТГ</b>	Засаг Даргын Тамгийн Газар
<b>МУ-ын ЗГ</b>	Монгол Улсын Засгийн Газар
<b>НҮБХХ</b>	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
<b>НХТ</b>	Нийгмийн Хөгжлийн Төв
<b>ТЭХЯ</b>	Түлш, Эрчим хүчний яам
<b>ТЭХГ</b>	Түлш, Эрчим хүчний газар
<b>УИХ</b>	Улсын Их Хурал
<b>УБЦТС ХК</b>	Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ХК
<b>УБДС ТӨХК</b>	Улаанбаатар Дулааны Сүлжээ Төрийн өмчит ХК
<b>УСАГ</b>	Ус суваг ашиглалтын газар
<b>ҮСГ</b>	Үндэсний Статистикийн Газар
<b>Хороо</b>	Хот суурин газрын засаг захиргааны анхан шатны нэгж
<b>ЭХЗГ</b>	Эрчим Хүчний Зохицуулах Газар
<b>ЯСН</b>	Ядуурлын Судалгааны Нэгж

---

## Нийтлэг ойлголт, тайлбар

**Байшин:** Бүтцийн хувьд нэг өрх амьдрах зориулалттай, нэг болон хэд хэдэн өрөөтэй сууц. Үүнд: сууцны тусдаа байшин, сууцны бус зориулалттай сууц, нийтийн сууц, нийтийн сууцны доторх сууц болон бусад сууцууд орно.

**Нийтийн сууцны байшин:** Зориулалтын зураг төслөөр баригдсан, бүтэц хийцийн хувьд хоёроос дээш айл суухад зориулан төхөөрөмжлөгдсөн (байшингийн хэмжээ, давхар, хэдэн айл суух зориулалттайгаар үл хамааран), дэд бүтцийн хангамжтай байшин.

**Нийтийн сууцны доторх сууц:** Нийтийн сууцны байшин дотор өрх тус бүрт зориулсан тусдаа нэг буюу хэд хэдэн өрөө тасалгаа, тоноглол төхөөрөмжтэй бусад айлаас тусгаарлагдсан зориулалтын ханатай, нэгдсэн шат, хонгил, эсвэл гудамж хашаа руу шууд гарах хаалгатай нэг айл суухад зориулагдсан сууц.

**Нэн ядуу хүн:** Нэн ядуу хүн гэж тухайн хүнд ногдох өрхийн орлогын хэмжээ нь амьжиргааны доод түвшингийн 40 хувиас доогуур, тэрхүү орлогынхоо хэмжээгээр хязгаарлагдмал хэрэглээтэй хүнийг хэлнэ.

**Орлого:** Амьжиргаагаа хангахын тулд төрөл бүрийн эх үүсвэрээс олж буй мөнгөн болон мөнгөн бус орлогууд. Үүнд: цалин, тэтгэвэр, тэтгэмжийн орлого, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнээс олох орлого, бусдаас авсан үнэгүй зүйл, мөнгөн тусламж, хүү, түрээсийн орлого багтана.

**Орон сууцны дэд бүтэц:** Орон сууцны дэд бүтэц гэж орон сууцны цахилгаан, холбоо, дулаан, усан хангамж, бохир, хог хаягдлын зайлуулалт болон инженерийн бусад шугам сүлжээ, орон сууцны орчны зам, талбайг хэлнэ.

**Өрх:** Өрх нь цусан төрлийн болон гэрлэлт, үрчлэлийн холбоо бүхий, харилцан үүрэг хүлээж, туслалцдаг, ахуй, аж амьдралын хувьд нэгдмэл, нийтлэг шинжтэй нийгмийн харилцааны хамгийн анхдагч бичил бүлэг юм.

**Өрхийн тэргүүлэгч:** Өрхийн тэргүүлэгч гэдэг нь бусад гишүүд нь өрхийн тэргүүн хэмээн хүлээн зөвшөөрсөн, насанд хүрсэн, өрхийн гишүүн юм. Хэрвээ тухайн сууцанд нэгээс олон өрх амьдран сууж байвал төдий тооны өрхийн тэргүүн байна.

**Өрхийн гишүүн:** Өрхийн гишүүн гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг хэлнэ.

**Өрхийн амьжиргаа:** Өрхийн амьжиргаа гэдэг нь өрхийн гишүүдийн амьдралын өдөр тутмын үйл явц, харилцаа юм. Амьжиргаа нь өрхийн оршин байгаа орчин, өрхийн орлого, өрх өөрийгөө санхүүжүүлэх чадвар, өрхийн хэрэглээ зэргээр тодорхойлогдоно.

**Өрхийн орлого:** Тухайн өрхийн бүх гишүүд амьжиргаагаа хангахын тулд олж буй мөнгөн болон мөнгөн бус орлогын нийт хэмжээг хэлнэ.

**Өрхийн зарлага:** Өрхийн зарлага гэж өрхийн гишүүдийн амьжиргааг хангахын тулд бараа үйлчилгээний худалдан явахад зарцуулж буй нийт хөрөнгийн мөнгөн илэрхийлэл юм.

---

**Хэрэглэгч:** Хэрэглэгч гэж бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээгээр хэрэгцээгээ хангах гэж байгаа буюу хангаж байгаа худалдан авагч, захиалагч, үүрэг гүйцэтгүүлэгч хувь хүнийг хэлнэ.

**Сууцны бус зориулалттай сууц:** Анхнаасаа хүн суух зориулалтын бус боловч өрх айл, хүн сууж байгаа сууц. Үүнд албан байгууллагын байшин, түүний нэг хэсэг буюу өрөө тасалгаа, вагончик, орц гэх зэрэг багтана.

**Сууцны тусдаа байшин:** Орон сууцны зориулалтын зураг төслөөр баригдсан, зориулалтын зураг төсөлгүй боловч иргэд өөрсдөө сууцанд зориулж барьсан нэг буюу хэд хэдэн өрх суухад зориулан төхөөрөмжлөгдсөн, дэд бүтцийн холбогдох хангамжтай сууц.

**Төлбөр:** Тухайн нэг бараа үйлчилгээг хүртэх, худалдан авахын тулд хангагч болон үйлчилгээ үзүүлэгчид төлж буй мөнгөн дүнг хэлнэ. Төлбөрийн хэмжээг тухайн хангагч болон үйлчилгээ үзүүлэгч тал өөрсдийн зардал, ашгийн хэмжээг тооцон тогтоосон байдаг.

**Төвлөрсөн дулаан хангамж:** Дулаан, цахилгааныг хослон үйлдвэрлэдэг эрчим хүчний эх үүсвэрээс болон 100 МВт-аас дээш хүчин чадалтай дулааны эх үүсвэрээс хэрэглэгчийг дулааны шугам сүлжээгээр диспетчерийн зохицуулалттайгаар дулаанаар хангах үйл ажиллагааг хэлнэ.

**Төвлөрсөн ус хангамж:** Төвлөрсөн ус хангамж гэж ус олборлох, цэвэрлэх, дамжуулах зориулалт бүхий шугам сүлжээ, барилга байгууламжийг ашиглан хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах үйл ажиллагааг хэлнэ.

**Төвлөрсөн бус ус хангамж:** Төвлөрсөн бус ус хангамж гэж ус олборлож, зөөвөрлөн түгээж, хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах үйл ажиллагааг хэлнэ.

**Ус хангамжийн эх үүсвэр:** Ус хангамжийн эх үүсвэр гэж гүний худаг, цуглуулах шугам, усан сан, насосны станц, цэвэршүүлэх байгууламжийг хэлнэ.

**Эрчим хүчээр хангагч:** Эрчим хүчний зохицуулалттай, эсхүл зохицуулалтгүй хангалт эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд юм.

**Ядуурал:** Ядуурал бол тухайн хүн өөрийгөө аз жаргалтай гэж мэдрэх, өөрийнх нь амьдралд хамааралтай асуудлаар шийдвэр гаргахад нөлөөлөх чадваргүй байх, боломж нь хязгаарлагдмал байхыг хэлнэ.

**Ядуурлын шугам буюу амьжиргааны доод түвшин:** Хүн амын амьжиргааны доод түвшин (ядуурлын шугам) гэдэг нь хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэлбэрээр илэрхийлсэнийг хэлнэ. Хэрэглээний доод хэмжээ гэдэгт хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэглээг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлсон бараа, үйлчилгээний шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон тоо, хэмжээг ойлгоно.

---

## Агуулга

<b>Товчилсон нэрсийн тайлбар</b> .....	<b>ii</b>
<b>Нийтлэг ойлголт, тайлбар</b> .....	<b>iii</b>
<b>Удиртгал. Судалгааны арга зүй, зохион байгуулалт</b> .....	<b>1</b>
Судалгааны зорилго .....	1
Судалгааны хамрах хүрээ .....	2
Судалгааны хугацаа .....	2
Судалгааны түүвэрлэлт.....	2
Судалгааны арга зүй.....	3
Мэдээллийн нууцлалт.....	5
Судалгааны судлаач, тоологч нарын сургалт.....	5
Мэдээллийн сангийн зохион байгуулалт.....	6
Тайлангийн бүтэц.....	6
<b>Бүлэг 1. Өрхийн шинж байдал</b> .....	<b>7</b>
1.1 Өрхийн тодорхойлолт.....	7
1.2 Ядуу өрхөд нөлөөлж буй нийтлэг хүчин зүйлүүд.....	11
1.3 Ядуу өрхийн гишүүд.....	14
1.4 Дүгнэлт.....	17
<b>Бүлэг 2. Ядуу өрхийн амьжиргаа</b> .....	<b>19</b>
2.1 Ядуу өрхийн амьжиргааны илэрхийлэл .....	19
2.2 Өрхийн орлого.....	20
2.3 Өрхийн зарлага .....	22
2.4 Өрхийн нөөц .....	24
2.5 Өрхийн амьжиргаанд нөлөөлж буй бусад хүчин зүйл.....	25
2.6 Дүгнэлт.....	28
<b>Бүлэг 3. Өрхийн ахуйн хэрэглээний зарим бүтээгдэхүүн</b> .....	<b>29</b>
3.1 Ахуйн хэрэглээний зарим бүтээгдэхүүний зориулалт .....	29
3.2 Ахуйн хэрэглээний зарим бүтээгдэхүүний хэрэглээ.....	31
3.3 Хэрэглээн дэх улирлын нөлөөлөл .....	34
3.4 Дүгнэлт.....	35

---

<b>Бүлэг 4. Ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний үнэ</b> .....	<b>37</b>
4.1 Цахилгаан эрчим хүчний үнэ тариф.....	37
4.2 Дулааны эрчим хүчний үнэ тариф.....	40
4.3 Хэрэглээний усны үнэ тариф.....	41
4.4 Түлшний үнэ тариф.....	42
4.5 Үнэ тарифт нөлөөлж буй зарим хүчин зүйлс.....	44
4.6 Өрхийн амьжиргаанд ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний үнийн үзүүлж буй нөлөөлөл.....	45
4.7 Дүгнэлт.....	49
<b>Бүлэг 5. Ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний нийлүүлэлт</b> .....	<b>51</b>
5.1 Цахилгаан эрчим хүчний нийлүүлэлт.....	51
5.2 Дулааны эрчим хүчний нийлүүлэлт.....	55
5.3 Түлшний нийлүүлэлт.....	55
5.4 Улаанбаатар хотын усан хангамж, нийлүүлэлт.....	56
5.5 Дүгнэлт.....	57
<b>Бүлэг 6. Төрийн оролцоо, түүний нөлөөлөл</b> .....	<b>59</b>
6.1 Үнэ тарифын арга.....	59
6.2 Орлогод үзүүлэх дэмжлэгийн арга.....	61
6.3 Техникийн тогтолцоог сайжруулах.....	63
6.4 Дүгнэлт.....	63
<b>Бүлэг 7. Олон улсын туршлага</b> .....	<b>65</b>
7.1 Эрчим хүчний төлбөрт дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд.....	65
7.2 Ядуу өрхөд дэмжлэг үзүүлэх механизм.....	68
7.3 Эрчим хүчний дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдийн үр дүнгээс гарсан нийтлэг сургамжууд.....	70
7.4 Словакийн орон сууцны тэтгэмжийн хөтөлбөрийн туршлага.....	73
7.5 Дүгнэлт.....	76
<b>Судалгааны нэгдсэн дүгнэлт, бодлогын зөвлөмж</b> .....	<b>77</b>
<b>Хавсралтууд</b> .....	<b>79</b>
Асуулгын загвар.....	80
Судалгааны багийн гишүүд.....	90
<b>Ном зүй</b> .....	<b>91</b>
Ном зохиол, бодлогын баримт бичиг.....	91
Судалгааны тайлан, хэвлэмэл материал.....	92



---

## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Судалгааны хүрээ хязгаар /байршил, арга зүй тус бүрээр/ .....	3
Хүснэгт 2. Оролцооны аргын судалгааг явуулах удирдамж .....	4
Хүснэгт 1.1 Хүн амын амьжиргааны доод түвшин .....	8
Хүснэгт 1.2 Ядуу өрхийг тодорхойлсон байдал .....	10
Хүснэгт 2.1 Нэг өрхийн сарын дундаж орлого, зарлага /мөнгөн дүнгээр/ .....	26
Хүснэгт 2.2 Нэг өрхийн сарын дундаж орлого, зарлага /хувиар/ .....	27
Хүснэгт 3.1 Ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнийг өрхийн амьжиргаанд ашиглаж байгаа байдал.....	29
Хүснэгт 3.2 Монгол улс дахь дулааны хангамж (хувиар) .....	33
Хүснэгт 3.3 Ахуйн хэрэглээний улирлын нөлөөлөл .....	34
Хүснэгт 4.1 Ахуйн хэрэгцээнд тоолуургүй нөхцөлд мөрдөх үнэ, тариф /НӨАТ-гүй/ .....	39
Хүснэгт 4.2 Эмзэг бүлгийн хэрэглэгчдийн цахилгааны үнэ .....	40
Хүснэгт 4.3 Айл өрхийн ахуйн хэрэгцээний дулааны үнэ /НӨАТ-гүй/.....	40
Хүснэгт 4.4 УСАГ-аас түгээх цэвэр ус, татан зайлуулах бохир усны тариф.....	42
Хүснэгт 4.5 Шинээр батлагдсан 1т нүүрсний үнэ /3 том уурхайн хэмжээнд/ .....	43
Схем 5.1 Төвийн бүсийн эрчим хүчний системийн тогтолцоо .....	54
Хүснэгт 6.1 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид .....	62
Хүснэгт 6.2 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчдад зарцуулсан хөрөнгө .....	62
Хүснэгт 7.1 Зүүн Европ ба Төв Азийн хотуудын төвийн эрчим хүчний системд хамрагдсан байдал (хувиар).....	69

---

## Графикийн жагсаалт

Зураг 1.1 Улаанбаатар хотын өрхийн тоон өсөлт /мянган өрх/ .....	7
Зураг 1.2 Судалгаанд оролцогсдын нас хүйсийн суварга .....	11
Зураг 1.3 Өрхийн гишүүдийн гэрлэлтийн байдал /хүйсээр/ .....	15
Зураг 1.4 18 ба түүнээс дээш насны өрхийн гишүүдийн боловсролын түвшин ..	17
Зураг 2.1 Нэг өрхийн сарын дундаж зарлагын бүтэц /хотод/ .....	20
Зураг 2.2 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого /орлогын төрөл, хувиар/ .....	21
Зураг 2.3. Гэр хорооллын нэг өрхийн сүүлийн нэг сарын ахуйн хэрэглээний зардал.....	24
Зураг 3.1 Гэр хорооллын хэрэглээний усан хангамж /хувиар/ .....	32
Зураг 4.1 Төвийн бүсийн цахилгааны үнийн өсөлт /ЭХЗГазар/ .....	37
Зураг 4.2 Төвийн бүсийн ахуйн хэрэгцээний дулааны үнийн өөрчлөлт .....	41
Зураг 4.3 Өрхийн ашиглаж буй зуухны төрөл /хувиар/ .....	45
Зураг 4.4 Өрхийн амьжиргаанд үзүүлэх үнэ тарифын нөлөөлөл /хувиар/ .....	46
Зураг 4.5 Өрхийн амьжиргаанд үзүүлэх цахилгаан эрчим хүчний төлбөрийн шууд нөлөөлөл /хувиар/ .....	46
Зураг 4.6 Халаалт дулааны төлбөр өрхийн гишүүдийн амьжиргаанд нөлөөлсөн байдал /хувиар/ .....	48

---

---

## Удиртгал. Судалгааны арга зүй, зохион байгуулалт

Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцааны суурийг 1990 оноос хөгжүүлж эхэлсэн билээ. Улс төр, эдийн засаг, нийгмийн өөрчлөлт, шинэчлэлт нь өргөн хүрээг хамрав. Эдийн засгийн уналт, ажилгүйдэл, ядуурал нь өрхийн амьжиргааны түвшин буурахад гол нөлөө үзүүлж байна. Өнөөдөр Монгол улсад, үүний дотор Улаанбаатар хотод хүн амын гуравны нэг ядуу, түүнээс илүү хэсэг нь эмзэг, өртөмтгий нөхцөл байдалд аж амьдралаа залгуулж байгаа нь ядуурлын олон судалгааны үр дүнд тогтоогдоод байна.

Монгол улсын Засгийн газар, олон улсын дэмжигч байгууллагуудын дэмжлэг тусалцаа, оролцоотойгоор ядуурлын асуудлыг олон талаас нь хүчин зүйлийн нөлөөллийг судлан ядуурлыг бууруулах стратегийг боловсруулан хэрэгжүүлж байна. Үүнтэй холбоотойгоор Улаанбаатар хотын Засаг даргын тамгын газар Улаанбаатар хот дахь ядуурлыг бууруулахад чиглэсэн олон үйл ажиллагааг явуулж байна.

Энэ хүрээнд “Ядуу өрхийн амьжиргаанд үзүүлэх ахуйн хэрэглээний үнийн нөлөөлөл” судалгааг Монгол улсын Засгийн Газар, НҮБХХ-ийн захиалгаар Нийгмийн Хөгжлийн Төв-ийн судалгааны баг хийж гүйцэтгэлээ.

### Судалгааны зорилго

Ядуу өрхийн амьжиргаанд үзүүлэх ахуйн хэрэглээний /цахилгаан дулааны эрчим хүч, хэрэгцээний ус, түлшний зүйлс/ үнийн нөлөөлөл, ахуйн хэрэглээний бүтэц, эрэлтэд гарсан өөрчлөлт, ядуурлын нийтлэг зүй тогтолыг тодорхойлох, тэдгээрт нөлөөлж байгаа хүчин зүйлийг судлахад судалгааны зорилго чиглэгдсэн. Судалгааны үр дүнд үндэслэн бодлогын зөвлөмж, санал боловсруулав.

Судалгаа нь дээрх зорилгын хүрээнд :

- Ахуйн хэрэглээний цахилгаан, дулааны эрчим хүч, ус, түлшний үнийн өөрчлөлт;
- Дээр дурьдсан ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний үнэ тариф ядуу өрхийн амьжиргаанд нөлөөлөх байдал, шинж;
- Ядуу өрхийн амьжиргаанд ахуйн хэрэглээний үнэ, түүний нөлөөллийг бууруулахад Засгийн газар, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, түгээгч байгууллагуудын үүрэг, оролцоог судалсан, мөн энэ асуудлын хүрээнд олон улсын сайн туршлагууд.

---

## **Судалгааны хамрах хүрээ**

Улаанбаатар хотын төвийн таван дүүргийг хамруулан судалгааг явуулан ҮСГ-аас гаргасан улсын дундаж үзүүлэлттэй судалгааны дүнг харьцуулах замаар боловсруулав. Судалгаанд давхардсан тоогоор Улаанбаатар хотын ядуу амьжиргаатай 260 орчим өрхийн 1000 гаруй гишүүд хамрагдсан.

## **Судалгааны хугацаа**

Судалгааг 2004 оны 7-р сараас 2005 оны 3-р сар хүртэлх хугацаанд гүйцэтгэсэн. Судалгаа нь үндсэн дөрвөн үе шаттайгаар хэрэгжив. Үүнд:

### **Судалгааны бэлтгэл үе шат**

Энэ үе шатанд судалгааны хүрээ, судалгаа явуулах арга зүйг тодорхойлж, судалгаатай холбоотой материал, баримт бичгүүдийг судлах ажлыг хийж гүйцэтгэв.

### **Анхан шатны нэгжээс өгөгдөл цуглуулах үе шат**

Энэ үе шатанд өмнө боловсруулсан арга зүй, асуулгын дагуу сонгогдсон хороодын өрхүүдээс судалгааг оролцооны, асуулгын, кейсийн аргаар авсан.

### **Судалгааны өгөгдөлд боловсруулалт хийх үе шат**

Анхан шатны нэгжээс цуглуулсан судалгааны өгөгдөлд үр дүнгийн боловсруулалт, алдааны засварлалт, дүн шинжилгээг хийсэн.

### **Судалгааны тайланг боловсруулж, эцэслэх үе шат**

Энэ үе шатанд өмнө хийгдсэн үйл ажиллагаануудын үр дүнг нэгтгэн судалгааны эцсийн тайланг боловсруулж, хянан эцэслэсэн.

## **Судалгааны түүвэрлэлт**

Судалгааны зорилго, ажлын даалгаврын дагуу судалгаанд хамрагдах хороодыг сонгоход дараах шалгуур үзүүлэлтийг ашигласан. Үүнд:

- Ядуурлын түвшин, ядуу нэн ядуу өрх, хүн ам: хорооны хүн амын тоо, шилжилт хөдөлгөөний байдал, ядуу нэн ядуу өрхийн тоо;
- Гэр болон байшин хорооллын төлөөлөл: урьд өмнө хийгдсэн судалгаануудын “ядуу өрх гэр хороололд илүү олноор амьдарч байна” гэсэн дүгнэлтэд үндэслэн гэр хорооллын ядуу өрхийг түлхүү хамруулах, орон сууцны өрхийн хувьд ядуу өрхүүд олноор амьдарч байдаг хороодыг сонгох;

- Онцлог нөхцөл байдал: сонгогдох хороод нь өөр өөрийн гэсэн онцлогтой байх, хүн амын дундах ядуурлын олон талт байдал, хүчин зүйлийн нөлөөлөл харуулахуйц байх;
- Байршил: судалгаанд хамрагдах хороодыг сонгохдоо төвөөс алслагдсан байдал, дэд бүтцийн хөгжлийн ялгаатай байх зэрэг болно.

Дээрх шалгуур үзүүлэлтийг ашиглан хороодыг сонгосон бөгөөд Хүснэгт 1-ээс сонгогдсон хороодыг харна уу. Сонгогдсон хороодын иргэд, Засаг даргын ажлын албатай хамтран оролцооны, асуулгын судалгаанд хамрагдах өрхүүдийг сонгосон болно.

**Хүснэгт 1. Судалгааны хүрээ хязгаар /байршил, арга зүй тус бүрээр/**

Байршил	Судалгааны үндсэн арга зүй		
	Оролцооны аргын судалгаа	Асуулгын судалгаа	Кейсийн судалгаа
Баянзүрх дүүрэг, 14-р хороо	Өрх толгойлсон эмэгтэйчүүд, Өндөр настны бүлэг	Сонгогдсон 40 өрх	Сонгогдсон 4 өрх
Сүхбаатар дүүрэг, 10-р хороо	Өрх толгойлсон эмэгтэйчүүд, Залуучуудын бүлэг	Сонгогдсон 40 өрх	Сонгогдсон 4 өрх
Сонгинохайрхан дүүрэг, 8-р хороо	Өрх толгойлсон эмэгтэйчүүд, Залуучуудын бүлэг	Сонгогдсон 40 өрх	Сонгогдсон 4 өрх
Хан-Уул дүүрэг, 8-р хороо	Өндөр настан, Холимог гишүүдтэй бүлэг	Сонгогдсон 40 өрх	Сонгогдсон 4 өрх
Чингэлтэй дүүрэг, 17-р хороо	Өрх толгойлсон эмэгтэйчүүд, Өндөр настны бүлэг	Сонгогдсон 40 өрх	Сонгогдсон 4 өрх

### **Судалгааны арга зүй**

Оролцооны аргын хувьд хорооны ядуу иргэдийн бүлгийн санал бодлыг асуулгын аргын хувьд судалгаанд хамрагдаж байгаа тухайн өрхийн гишүүдийн санал бодлыг илүү тусгасан бол кейсийн судалгааны хувьд нөхцөл байдлыг үнэлсэн судлаачийн байр суурь, үнэлгээг гол болгосон. Түүнчлэн өрхийн орлого, зарлагын статистик үзүүлэлт болон зарим бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өөрчлөлт, хандлагад дүн шинжилгээ хийв. Эдгээр нь ядуу өрхийн амьжиргаа, ахуйн хэрэглээнд цахилгаан, дулаан, түлш, усны хэрэглээ, үнийн нөлөөллийг олон талаас нь дүгнэх боломжийг бүрдүүлсэн гэж үзэж болно.

#### **Оролцооны аргын судалгаа**

- Хороо бүрт хоёр бүлгийн ярилцлагыг оролцооны аргаар зохион байгуулсан бөгөөд урьдчилан бэлтгэсэн хөтөлбөр, аргачлалын дагуу явуулав. Оролцооны аргын судалгааг явуулсан удирдамжыг Хүснэгт 2-оос харна уу.

**Хүснэгт 2. Оролцооны аргын судалгааг явуулах удирдамж**

Д/д	Үйл ажиллагаа	Ашигласан аргууд
1	Бүлгийн ярилцлагын зорилго, арга зүйг товч танилцуулах	Оролцогчдыг 1-2 бүлэг болгон ажилласан.
2	Оролцогчдын талаарх мэдээллийг цуглуулах	Зураглалын аргыг ашиглан өрхийн байршил, өрхийн гишүүдийн тоо, өрхийн бүтэц зэргийг тодорхойлов.
3	Өрхийн ядуурлын шалтгаан, үр дагаврын талаар ярилцах	Шалтгаан, үр дагаврын аргыг ашиглан эхлээд ядуурч байгаа шалтгааныг бүлгээр тодорхойлов. Дараа нь тодорхойлсон шалтгаануудын үр дагаврыг бүлгээр тодорхойлсон.
4	Өнгөрсөн хугацаанд ядуу өрхийн амьжиргаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтийн талаар ярилцах	Хуанлийн аргыг ашиглан хорооны түвшинд 1990 оноос хойш гарсан эерэг сөрөг нөлөөллийг бүлгээр ярилцсан. Үүнд: цахилгаан эрчим хүч, дулаан, түлш, усны хангамж, хэрэглээ, үнэд гарсан өөрчлөлтийн талаар авч үзсэн.
5	Эрчим хүч, түлш, устай холбоотой асуудлуудыг /ядуу өрхүүд цахилгаан эрчим хүчээр хангагдсан байдаг эсэх, орон байрны онцлог, түлш модоо хэрхэн бэлтгэдэг эсэх, ундны усаа хаанаас ихэнхдээ авдаг зэрэг асуултууд/ судлах.	Зураглалын аргыг ашиглан өмнө хийгдсэн зураглалын схем дээр цахилгаан эрчим хүчийг ашиглаж чадахгүй байгаа өрхийн байршил, ундны худаг болон мод нүүрсээ худалдаж авдаг захын байршил зэргийг судалсан. Мөн орон байрны чанар, төрөл зэргийг тодорхойлсон.  Дээрх хэрэглээний бүтээгдэхүүнүүдийн үзүүлж буй нөлөөлөл, үнийн өөрчлөлтийн амьжиргаанд үзүүлж буй нөлөөллийн талаар шалтгаан үр дагаварын аргыг ашиглан ярилцав.
6	Амьжиргаанд улирлын нөлөөллийг тодорхойлох	Улирлын хуанлийн аргыг ашиглан цахилгаан эрчим хүч, түлш, усны хэрэглээнд гарч байдаг өөрчлөлтүүдийг тодорхойлсон.
7	Асуулгын судалгаанд ямар өрхүүдийг хамруулах, яагаад тэд тухайн өрхийг сонгож байгаа шалтгааныг ярилцах	Эцэст нь асуулгын судалгаанд тухайн хорооны ямар өрхүүдийг хамруулах, тэдгээр өрхийг сонгож байгаа шалтгаан, үндэслэлийн талаар ярилцсан.

**Анкетын асуулгын талаар**

Анкетын асуулгыг боловсруулан Ядуурлын Судалгааны Нэгжтэй хамтран сайжруулж хийв. Анкетын асуулгыг хавсралтаас харна уу. Оролцооны аргын судалгааны хүрээнд урьдчилан сонгосон өрхүүдээс анкетын асуулгын судалгааг авсан. Асуулга нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэж байна. Үүнд:

- Асуулгад хариулагчийн талаарх мэдээлэл;
- Өрхийн ам бүлийн байдал;
- Өрхийн амьжиргаа;
- Өрхийн амьдарч буй орон байрны нөхцлийн талаар;

- 
- Өрхийн ахуйн хэрэглээний үнийн амьжиргаанд үзүүлэх нөлөөлөл;
  - Иргэдийн санал бодол, ядуурлын талаарх ойлголт;
  - Өрхийн орлого, зарлагын талаар;

### **Кейсийн арга**

Кейсийн судалгаагаар судлаачид сонгон авсан өрхийн гишүүдтэй ярилцах замаар тухайн өрхийн амьжиргаа, ахуйн хэрэглээг нарийвчлан судлаж дүгнэлтээ өгсөн. Энэ нь тухайн өрхийн амьжиргаа, мөн цахилгаан, түлш, усны хэрэглээний байдалд судлаачийн зүгээс өгч байгаа дүн шинжилгээ байх болно. Кейсийн судалгаагаар дараах асуултуудад судлаач хариулт өгөхийг зорьсон. Үүнд:

- Тухайн өрхийг ямар шалгуур, үзүүлэлт, үнэлэмжээр ядуу айл гэж тодорхойлж байгааг;
- Өрхийн амьжиргаа, ядууралд ямар хүчин зүйлүүд гол нөлөө үзүүлж байгааг;
- Өрхийн орлого, зарлага болон түүнд хэрэглээний үнийн эзлэх хувь хэмжээ, нөлөөлөл;
- Өрхийн цахилгаан, түлш, дулаан, усны хэрэглээ;
- Өрхийн амьжиргааг дээшлүүлэх боломж, арга замуудыг судлаач хэрхэн үзэж байгаагаа тодорхойлох;

### **Мэдээллийн нууцлалт**

Судалгааны багийн гишүүд “Хувь хүний нууцын тухай” Монгол улсын хууль, бусад хууль тогтоомжийн заалтыг мөрдөж ажиллав.

Судалгаанд оролцох өрхүүдийг сонгохдоо судалгаанд оролцохыг зөвшөөрөх эсэхийг асууж, зөвшөөрсөн нөхцөлд гэрээ байгуулсан. Судалгаанд хамрагдсан өрх шаардлагатай мэдээллийг үнэн зөвөөр мэдээлэх, судалгааг гүйцэтгэгч байгууллагын хувьд тухайн хувь хүн, өрхийн тухай мэдээллийг судалгаанаас бусад зорилгоор ашиглахгүй байх, хувь хүний нууцыг задруулахгүй байх үүргийг гэрээгээр хүлээсэн. Иймээс судалгааны тайлан болон дагалдах тайлангуудад оршин суугаа газрыг тодорхой дурьдаагүй ба жинхэнэ нэр, хаягийг өөрчилсөн болно.

### **Судалгааны судлаач, тоологч нарын сургалт**

Анхан шатны нэгжээс мэдээлэл цуглуулах судлаач, тоологч нарт нэг өдрийн сургалтыг явуулсан. Сургалт нь оролцооны аргад суурилсан. Анхан шатны нэгжид “Нийгмийн Хөгжлийн Төв”-ийн зөвлөхүүд хамтран ажиллаж шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлэв.

---

## **Мэдээллийн сангийн зохион байгуулалт**

Анкетын асуулгын анхдагч өгөгдлийг CSPro программын тусламжтайгаар SPSS-д хөрвүүлж мэдээллийн санг үүсгэв. Мэдээллийн санг ашиглан өгөгдлийн боловсруулалт, дүн шинжилгээг ерөнхий, гэр болон орон сууцны өрх, ядуу өрхүүд зэрэг төрлөөр ангилан хийв.

### **Тайлангийн бүтэц**

Судалгааны тайлан нь удиртгал, нэгтгэсэн дүгнэлт, бодлогын зөвлөмж болон үндсэн 7 бүлгээс бүрдэж байна. Удиртгал хэсэгт судалгааны зорилго, хамрах хүрээ, судалгааны арга зүй, аргачлал зэргийн талаар дэлгэрэнгүй тайлбарлав.

Нэгдүгээр бүлэгт өрхийн талаарх ойлголт, өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлоход ашиглаж байгаа арга зүй, ядуу өрхийн амьжиргаанд нөлөөлж буй нийтлэг хүчин зүйл болон өрхийн гишүүдийн өрхийн амьжиргаанд үзүүлж байгаа нөлөөллийг судалгааны үр дүнд суурилан өгүүлэв.

Хоёрдугаар бүлэгт өрхийн амьжиргааг тодорхойлогч хүчин зүйлүүд болох өрхийн орлого, зарлага, нөөцийн асуудлууд, эдгээрт нөлөөлж буй хүчин зүйлийн талаар ярилцсан.

Гуравдугаар бүлэгт цахилгаан, дулааны эрчим хүч, түлш, усны ахуйн хэрэглээний зориулалт, эдгээрийн хэрэглээний талаар судалгааны үр дүнд суурилан авч үзсэн.

Дөрөвдүгээр бүлэгт цахилгаан, дулааны эрчим хүч, түлш, усны үнэ, тэдгээрийг тогтоож байгаа арга механизм, үнийн өрхийн амьжиргаанд үзүүлж буй нөлөөллийн талаар судлав.

Тавдугаар бүлэгт ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн үйлчилгээг үйлдвэрлэгч, түгээгч байгууллагын удирдлага зохицуулалт, үйл ажиллагааны үр ашигтай, найдвартай тогтолцооны талаар судалсан.

Зургаадугаар бүлэгт ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн үйлчилгээг ядуу өрхийн хэрэглэгчдэд хүргэхэд Монгол улсын Засгийн газраас үнэ тарифын, орлогод үзүүлэх дэмжлэг, тэтгэлгийн, оновчтой хэрэглээг бий болгох аргуудаар дамжуулан явуулж байгаа үйл ажиллагаатай танилцсан.

Долоодугаар бүлэгт Зүүн Ервоп, Төв Азийн хуучин социалист орнуудад өвлийн улирлын эрчим хүчний төлбөрийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд болон Словак улсын орон сууцны хөтөлбөрийн туршлагын талаар ярилцсан.

Эцэст нь судалгааны үр дүнг нэгтгэн, бодлогын зөвлөмжийг боловсруулсан болно.



## Бүлэг 1. Өрхийн шинж байдал

Энэ бүлэгт өрхийн талаарх ойлголт, өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлоход ашиглаж байгаа арга зүй, ядуу өрхийн амьжиргаанд нөлөөлж буй нийтлэг хүчин зүйл болон өрхийн гишүүдийн хувьд өрхийн амьжиргаандахь нөлөөллийг авч үзэв.


Өрх, өрхийн гишүүд ахуйн хэрэглээний эрэлт, хэрэглээг тодорхойлогч бөгөөд тэд ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнэд нөлөөлнө.

### 1.1 Өрхийн тодорхойлолт

Өрх нь цусан төрлийн болон гэрлэлт, үрчлэлийн холбоо бүхий, харилцан үүрэг хүлээж, туслалцдаг ахуй, аж амьдралын хувьд нэгдмэл, нийтлэг шинжтэй нийгмийн харилцааны хамгийн анхдагч бичил бүлэг юм<sup>1</sup>. Өрх нь тухайн нийгмийн соёл, эдийн засаг, төрийн чухал ойлголт хүн ам зүйн гол үзүүлэлт болдог байна.

Тодорхой засаг захиргааны нэгжийн харьяалал, нутаг дэвсгэрт өрх албан ёсны бүртгэлтэй болон бүртгэлгүй хэлбэрээр оршин амьдарч байв. Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотод өрхийн тоо байнга өсөж байгаа нь хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд хурдацтай нэмэгдэж байгаатай холбоотой байж болох юм /Зураг 1.1/.

**Зураг 1.1 Улаанбаатар хотын өрхийн тоон өсөлт /мянган өрх/<sup>2</sup>**



Өрх нийгэмд оршин байх зорилгоо хангаж чадахгүй байгаа байдал нь ихэнхдээ өрхийн амьжиргаа доройтох буюу ядуурах шалтгаан болдог. Ядуурал бол тухайн хүн өөрийгөө аз жаргалтай гэж мэдрэх, өөрийнх нь амьдралд хамааралтай асуудлаар шийдвэр гаргахад нөлөөлөх чадваргүй байх, боломж нь

хязгаарлагдмал байхыг хэлнэ<sup>3</sup>.

<sup>1</sup> С. Түмэндэлгэр, Нийгмийн ухааны зарим нэр томъёоны тайлбар толь. УБ 2002. хуудас [99].

<sup>2</sup> Монгол улсын статистикийн эмхтгэл – 2003. УСГ 2004. хуудас [35].

<sup>3</sup> Жон Киуага-Нсүабуга. Орон нутгийн түвшинд ардчиллыг бэхжүүлэх нь. Тулгамдсан зарим асуудлын судалгаа. УБ 2004. хуудас [71].

---

Өрхийн ядуурал нь амьжиргаа, нөөц, мэдлэг болон эрх мэдэл гэсэн категориудаар тодорхойлогддог. Амьжиргаа нь өрхийн орлого, өрх өөрийгөө санхүүжүүлэх чадвар, өрхийн хэрэглээ, нөөц зэргээс шалтгаалж байна. Нөөцөд өрхийн гишүүдийн боловсрол, эрүүл мэндийн байдал, нийгмийн үйлчилгээг хүртэх боломж зэрэг нөлөөлөх бөгөөд гишүүдийн ур чадвар, хөрөнгө, орон сууцны байдал зэргээр тодорхойлогдож байна. Өрх нөөцтэй байх нь амьжиргааны баталгаа буюу эрсдэлээс хамгаалах хэрэгсэл болдог. Мэдлэг гэдэгт мэдээлэл авах боломж, ашиглах чадвар, боловсролын түвшин, өөрийгөө илэрхийлэх чадвар зэргийг хамруулан ойлгож болно<sup>4</sup>. Өрх болон өрхийн гишүүний эрх мэдэл нь оршин амьдрах, хувийн эрх ашиг сонирхлоо илэрхийлэх чадавхи, хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйн боломжоор тодорхойлогдоно.

Улсын хэмжээнд өрхийн гишүүдийн амьжиргааны түвшинг тооцохдоо хүн амын амьжиргааны доод түвшин буюу ядуурлын шугам гэсэн ойлголтыг ашиглаж байна. Хүн амын амьжиргааны доод түвшин (ядуурлын шугам) гэдэг нь хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэлбэрээр илэрхийлсэнийг, хэрэглээний доод хэмжээ гэж хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэглээг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлсон бараа, үйлчилгээний шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон тоо, хэмжээг ойлгоно. Хэрвээ хэн нэгэн хүн амьжиргааны доод түвшнээс доогуур хэрэглээтэй бол уг хүнийг ядуу гэж тооцно. Ядуурлын шугамыг одоогийн байдлаар үндсэн 2 аргачлалаар тооцож байна. Үүнд:

**Нэгдүгээрт:** Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай Монгол Улсын хуулийн 4.5 дугаар зүйлийн дагуу ҮСГ-аас Хүн амын амьжиргааны доод түвшинг тооцох бөгөөд энэ хуулийн 6-р зүйлд заасны дагуу хүн амын амьжиргааны доод түвшний хэмжээг жишиг үзүүлэлт болгон ашиглаж байна. Түүнийг ҮСГ-аас 1998 онд боловсруулсан «Хүн амын амьжиргааны доод түвшинг улсын хэмжээнд тодорхойлох аргачлал»-ын дагуу хэрэглээний норматив доод хэмжээг үндэслэн тооцон жил бүр шинэчлэн ҮСГ зарладаг. 2002-2004 оны байдлаарх хүн амын амьжиргааны доод түвшний хэмжээний өөрчлөлтийг Хүснэгт 1.1-д харуулав.

#### **Хүснэгт 1.1 Хүн амын амьжиргааны доод түвшин**

---

<sup>4</sup> Кит Гриффин. Тэгш байдал, ядуурлыг бууруулах асуудлыг хөгжлийн стратегид тусгах. УБ 2001. хуудас [23].

Бүсүүд	2002 он	2003 он	2004 он
Баруун	19200	19500	20200
Зүүн	20200	20500	21200
Төв	19700	19800	20600
Хангайн	19100	19900	20600
Улаанбаатар	24600	25300	26500

**Хоёрдугаарт:** Түүвэр судалгааны дүнгээр хүн амын амьжиргааны доод түвшинг (ядуурлын шугам) тооцдог бөгөөд энэхүү ядуурлын шугамыг ашиглан ядуу хүн амын тоо, ядуурлын хамралт,

гүнзгийрэлт зэргийг улс, бүс, хот, хөдөө гэсэн ангиллаар тооцож байна. Монгол улсын хувьд хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлохын тулд Амьжиргааны түвшний түүвэр судалгаа (АТТС)-г гурван удаа хийгээд байна.<sup>5</sup> Эдгээр түүвэр судалгааны дүнд хүн амын бодит хэрэглээнд үндэслэн ядуурлын шугамыг тооцон гарсан. Ядуурлын шугамыг тооцохдоо хүнсний болон хүнсний бус гэсэн зардлыг тооцдог. Хүнсний бүрэлдэхүүн хэсэг нь хүний эрүүл амьдрахад шаардлагатай хоол тэжээлийн илчлэгийн доод хэмжээнд үндэслэн тооцдог. Хүнсний бус бүрэлдэхүүн хэсгийг байгуулахдаа хүнсний ядуурлын шугамыг өргөтгөн зайлшгүй шаардлагатай хүнсний бус бүтээгдэхүүний төрлийг сагсанд багтаан тооцдог.

“Ядуу өрхийн амьжиргаанд үзүүлэх ахуйн хэрэглээний үнийн нөлөөлөл” судалгааны анхдагч мэдээллийг цуглуулахдаа ҮСГ-ын өрхийн амьжиргааны талаарх судалгааны зарим үр дүнтэй харьцуулах үүднээс өрхийн орлого, зарлагыг тодорхойлох төстэй хүснэгтийг ашиглав. Хүснэгтийн загварыг Хавсралтаас харна уу. Энэ аргачлалаар боловсруулсан асуулгын судалгааны үр дүнгээс харахад судалгаанд нийт өрхийн 42 хувийн сарын орлого 10600 төгрөгөөс бага, 41.5 хувь нь 26500 төгрөгнөөс доогуур орлого бүхий өрхүүд хамрагдсан байв. Дээрх үзүүлэлт нь өрх өөрсдийнхөө амьжиргааны түвшинг тодорхойлсон үзүүлэлттэй ойролцоо байв. Нийт өрхийн 42.5 хувь нэн ядуу, 38.5 хувь ядуу, 13.5 хувь дундаас доогуур, 5.5 хувь дундаж амьжиргаатай гэж тодорхойлжээ.

Өрхийн ядуурлыг тодорхойлоход 2000 оноос чанарын судалгааны аргыг ҮСГазар ашиглаж байна. “Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгаа”-ны анхны тайландаа амьдрал муу тааруу байх нь үндсэн хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаагаас гадна чадвар сул байх, архидах зэрэг хүчин зүйлээс шалтгаалдаг гэж тодорхойлсон. Энэ тайланд Улаанбаатар хотод дараах шалтгаанаар өрхийн амьжиргаа ядуу, эмзэг байна гэж үзжээ:

- Сууц гэр нь ядуу эсвэл орон гэргүй байх;
- Байнгын орлогын эх үүсвэргүй эсвэл бүхэл бүтэн нэг өрх нэг хүний цалингаар амьдардаг байх;

<sup>5</sup> АТТС-г 3-аас 5 жилийн давтамжтайгаар явуулдаг бөгөөд Монгол Улс 1995. 1998 онд болон 2003 онд (Өрхийн орлого, зарлага амьжиргааны түвшний түүвэр судалгаа нэртэйгээр) тус тус явуулаад байна.

- Ажил хийх чадвар, боломжгүй байх;
- Ганц бие өрх толгойлсон эмэгтэй, эрэгтэй байх;
- Мал, газрын аль аль нь байхгүй байх;
- Дорой хувцас хунар, зүс царайтай байх;
- Заримдаа идэх зүйл олдохгүй хоосон хонодог байх;
- Гэр оронгүй, гудамжний тэнүүлчин амьдралтай байх;
- Орц хонгилоор хоног төөрүүлдэг байх;
- Хог түүдэг байх;

Оролцооны аргаар амьжиргааны түвшинг тодорхойлох хоёр дахь удаагийн судалгааг ҮСГ Дэлхийн банк, Азийн Хөгжлийн Банкны дэмжлэгтэйгээр 2004 онд хийж эхлээд байна.

Манай судалгааны хүрээнд мөн оролцооны аргыг ашиглан ядуу өрхийг тодорхойлох, ахуйн хэрэглээний өөрчлөлт зэрэг олон асуудлуудыг тодорхойлсон. Энэ талаар удиртгал бүлэгт дурьдсан билээ. Өрх толгойлсон эмэгтэйчүүд, өндөр настан, залуучуудын бүлгүүд “ядуу өрх” гэсэн тодорхойлолтыг авч үзэхдээ өрхийн бүтэц, гэр бүлийн байдал, өрхийн амьдарч байгаа орчин зэрэг шинж чанарыг үндсэн тодорхойлогч үзүүлэлт болгож байв. Гэхдээ бүлэг бүрийн хувьд тухайн бүлгийн хэрэгцээ, тулгамдсан асуудал нь өөр өөр байдгаас хамааран тэдний тодорхойлсон ядуу өрхийн шинж чанарууд харьцангуй ялгаатай байв /хүснэгт 1.2-ийг харна уу/.

#### Хүснэгт 1.2 Ядуу өрхийг тодорхойлсон байдал

Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн бүлэг	Өндөр настны бүлэг	Залуучууд ба холимог бүлэг
Өрхийн орлого амьжиргааны түвшингээс доогуур байх; Хүүхдүүд нь сургууль завсардсан; Орлогоо өсгөх боломжгүй байх; Залхуу, арчаагүй, архичин байх; Олон хүүхэдтэй өрх толгойлсон байх; Өөрийн гэр оронгүй байх; Харьяалалгүй байх; Өрхийн гишүүд хүнд өвчин туссан байх;	Тэжээх үр хүүхэдгүй ганц бие хүмүүс; Үр хүүхэд ажилгүй байх; Тэтгэвэр бага, ажил хийх боломжгүй байх; Өндөр настан хэт олон хүнийг тэжээх; Өрхийн тэргүүн архичин байх;	Өрхийн гишүүд ажилгүй байх; Боловсролын түвшин бага, боловсрол эзэмших боломжгүй байх; Гэр орны орчин нөхцөл тааруу, хүнд байх, цахилгаан, халуун хүйтэй усгүй байх; Өрхийн орлого зайлшгүй зардалд хүрэлцдэггүй байх; Өвчтэй, группт орсон, хөгжлийн бэрхшээлтэй гишүүдтэй байх;

Оролцооны аргын судалгаагаар өрхийн амьжиргааны түвшин ядуу байх нь тухайн өрхийн нийт гишүүдэд нөлөөлөх боловч бага насны хүүхэд,

тэтгэврийн насны болон хөгжлийн бэрхшээлтэй, өрх толгойлсон эмэгтэй хүмүүст илүүтэй нөлөөлж байна гэж үзэж байв.


Эдгээр арга зүй нь Монгол улсын хэмжээнд ядуурлыг тодорхойлох нийтлэг аргачлал боловч анхан шатны нэгжийн түвшин дэх өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох арга зүй гэж үзэж болохгүй ба ийм жишиг арга зүй хараахан байхгүй байсан тул дээрх аргуудыг суурь болгон ашиглав. Харин НХХЯ болон бусад холбогдох байгууллагууд 2005 оноос эхлэн анхан шатны түвшинд нэгж өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг боловсруулж гаргаад байна.

## 1.2 Ядуу өрхөд нөлөөлж буй нийтлэг хүчин зүйлүүд

Өрхөд орлогогүй гишүүдийн тоо нэмэгдэх нь өрхийн зардал, хэрэглээг нэмэгдүүлж, улмаар өрхийн нэг гишүүнд ноогдох орлогын хэмжээг бууруулах шалтгаан болж байгааг судалгаанд хамрагдагсад тэмдэглэсэн. Асуулгын судалгаанд хамрагдсан нийт 200 өрхийн өрхийн гишүүдийн дундаж тоо 4 байгаа ч ядуу өрхийн хувьд энэ үзүүлэлт 4.7 байв. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж ядуурлыг бууруулах стратегийн баримт бичигт “төрөлтийн түвшин ядуу өрхийн дотор харьцангуй өндөр байна” гэж дүгнэсэн нь үүнийг нотлож байна.

Асуулгын судалгаанд нийт өрхийн 900 гаруй гишүүн хамрагдсаны 39.7 хувийг 18 хүртэлх насны хүүхдүүд эзэлж байв. Оролцооны болон кейсийн оролцогчид 16-с дээш насны хүүхдүүд 8-р ангиа төгсөөд цаашид сургуульд суралцаж чадахгүй, ажил олдохгүй байгаа нь сөрөг асуудлуудыг үүсгэж байна гэж өгүүлж байв.

Зураг 1.2 Судалгаанд оролцогчдын нас хүйсийн суварга



Монгол улсад хүн амын өсөлтийн хурд сүүлийн жилүүдэд ихээхэн буурч байгааг<sup>6</sup> судалгаанд хамрагдагсдын нас хүйсний суварга батлаж байна

<sup>6</sup> Эдийн засгийн өсөлтийг дэмжиж ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг, МУЗГ. 2003, хуудас [15-19].

---

/Зураг 1.2-с харна уу/. Өнөөгийн хүн амын төрөлтийн түвшиний бууралт нь нэг талаас өрхийн ядуурал, нөгөө талд гэр бүл салалт, өрх толгойлсон эмэгтэйчүүд нэмэгдэж байгаа зэрэгтэй шууд холбоотой байж болох юм. Эмэгтэйчүүдийн нийгэмд гүйцэтгэх үүрэг энэ хугацаанд нэмэгдэж, боловсрол, ажиллах хүчний хувьд эзлэх тоо хэмжээ ч нэмэгдсэн статистик үзүүлэлтүүд байна. Эсрэг тохиолдолд энэхүү өөрчлөлт нь төрөлт буурах шалтгаан болж байна. Энэ хандлага цаашдаа нэлээд удаан хугацаанд хадгалагдах төлөвтэй.

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 40.5 хувь гэрт, 39.5 хувь галлагаатай байшинд, 11.5 хувь орон сууцанд, үлдсэн 8.5 хувь зориулалтын бус байр сууцанд амьдарч байна. Өрхийн амьдарч байгаа орчин нь өрхийн хэрэглээ, амьжиргааны түвшинтэй хамааралтай байв. Орон байрны өөрийн өртөг нэмэгдэх тусам орон байрны тав тухтай байдал сайжирч, өрхийн амьжиргааны шууд бус зардлууд буурах, өрхийн гишүүдийн амьдрах чадвар, нөөц сайжрах нэг нөхцөл болж байна. Гэхдээ энэ нь з айлшгүй нөхцөл биш боловч нийтлэг шинжтэй байв. Жишээлбэл: Гэрт амьдрах үеийн зардлаас орон сууцны подваль, орц, нойлын өрөөнд амьдрах амьжиргааны зардал бага байдаг гэж судалгаанд оролцогчид нотолж байв. Орон сууц болон зориулалтын бус орон сууцанд амьдарснаар дулаалцуулгын зардал, усны зэрэг зардлууд буурч, өрхийн амьжиргааны тав тухтай байдал, эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл сайжирдаг гэжээ. Түүнчлэн цахилгаан эрчим хүчний хангамж, техникийн нөхцөл нь гэр хорооллоос орон сууцны хороололд сайн байдагтай холбоотойгоор цахилгаан эрчим хүчний хэрэглээний найдвартай байдал, ашиглалт нэмэгддэг байна. Өрхийн хэрэглээний талаар дараа дахин дэлгэрүүлж судлах болно.

**Кейсийн жишээ: Сүхбаатар дүүрэг, Иргэн Д. /Өрх толгойлсон эмэгтэй/**

Иргэн Д нь СӨХ-д орцны жижүүрээр ажиллаж, орцныхоо доод давхарыг /подвальд/ засаж янзлан 2 жил гаруй амьдарч байна. Урьд нь өөрийн гэсэн гэр орон, хашаатай, хувиараа бизнес эрхэлж байв. Зээлийн өрөнд орж бүх хөрөнгөө зарсан ажээ.

Тэрбээр тэтгэврийн насанд хүрсэн боловч тэтгэвэр тогтоолгож чадаагүй бөгөөд хоёр хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй учраас өөрөө асран халамжилдаг.

Өрхийн орлого нь хүүхдүүдийн тэтгэмжийн (групп) 50000 төгрөг, жижүүрийн цалин 35000 төгрөг байна. Одоогоор байрны доод давхарт амьдарч байгаа учраас өрхийн зарлагад халаалт, усны төлбөр их нөлөө үзүүлдэггүй гэж байв. Цахилгааны төлбөрөө тогтмол тоолуураар төлдөг. Орцны жижүүр болохоор тав тухтай амрах боломж багатай байдаг гэжээ.

Мөн гэр болон галлагаатай байшинд амьдрах үеийн амьжиргааны зардал, тав тухтай байдал ч ялгаатай байна. Сүүлийн жилүүдэд галлагаатай байшинг дүнз, бусад барилгын материалаар барих нь элбэгшиж байгаа хэдий ч гэр хороололд цахилгаан, усан хангамж, бохир, хаягдал зайлуулах

---

дэд бүтэц хангалтгүй хэвээр байгааг оролцооны аргын судалгааны явцад оролцогчид тэмдэглэж байв.

Монгол улсын Засгийн газар, олон улсын хөгжлийн байгууллагуудтай хамтран Улаанбаатар хотын гэр хорооллын нийтийн үйлчилгээг сайжруулахад чиглэсэн нилээд ажлуудыг хийж байгаа ч ойрын хугацаанд шийдвэрлэх шаардлагатай, боломжтой олон асуудал байна. Үүний нэг нь гэр хорооллын бохир зайлуулах системийг хөгжүүлэх юм.

Амьдарч буй орон байр, газрын өмчлөл, эзэмшлийн асуудал нь өрхийн амьжиргаа, орлоготой хамааралтай байна. Өрх өөрийн эзэмшлийн орон байраа янз бүрийн байдлаар олж авсан байдаг бөгөөд эцэг эхээс өвлөсөн, өөрсдөө барьсан, худалдан авсан эсвэл хөлсөлж байгаа зэрэг хэлбэрийг “Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн судалгааны тайлан”-д тодорхойлжээ. Харин манай судалгаанд хамрагдсан нийт өрхийн 83.5 хувь өөрийн эзэмшлийн, 8.5 хувь түрээсийн, 5.0 хувь байгууллагын, үлдсэн хувь нь бусдын орон байранд амьдарч байна. Өөрийн эзэмшлийн орон байрны чанар, өртөг нэмэгдсэнээр орон байраа барьцаалан зээл авах, бизнес эрхлэх боломж илүү бий байдаг талаар судалгаанд оролцогчид өгүүлж байв. Улаанбаатар хотод гэр хорооллын айл өрхийн оршин амьдарч байгаа газрын дийлэнх хувь өнгөрсөн хугацаанд хувьчлагдсанаар газрын болон хашаа, байшингийн зах зээлийн үнэ ханш өсөж байгааг ч нотолсон.

Асуулгын судалгаанд хамрагдсан нийт өрхийн амьдарч байгаа байрны 26 хувьд 2 өрх, 13 хувьд 3 өрх амьдардаг гэжээ. Мөн 4 өрх ч амьдарч байгаа гэсэн үзүүлэлт байна. Иймээс ядуу өрхүүдийн хувьд нэг орон байранд амьдрах өрхийн тоо нь олон, өрхийн нэг гишүүнд ногдох талбайн хэмжээ бага байв.

**Кейсийн жишээ: Сонгинохайрхан дүүрэг, иргэн Д /өндөр настан/**

Өндөр настан Д нь өөрийн хоёр охины гэр бүлийн хамт 11-үүлээ амьдарч байна. Одоо 40 гаруй жилийн өмнө барьсан галлагаатай жижиг байшинд 3 өрх хамт амьдардаг. Өрхийн нийт орлого нь 52 мянган төгрөг бөгөөд охидын нөхрүүд архи уудаг гэж өгүүлж байв. Өрхөд хөдөлмөр эрхлэх чадвартай 4 хүн байгаа боловч ажил олдохгүй байна. Ажилд орох гэхээр шаардлагыг нь хангаж чадахгүй болохоор хэцүү байдаг байна.

Өрхийн тэргүүн 39 жил төрийн захиргааны байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан бөгөөд өмнө засаг захиргааны нэгжид ажиллаж байхад нь эрчим хүчний хөнгөлөлтийг өрхүүдэд үзүүлдэг байсан талаар дурсаж байв. Тэрбээр цааш нь цахилгаанаа хэмнээд ч зардал нь өндөр гарч байна. Цахилгааны тоолуураа шалгуулахыг хүссэн боловч бөөн хүнд суртал, мөнгө шаарддаг юм байна. Түүнээс шалтгаалан сүүлийн 2 сарын цахилгааны төлбөр их бичигдсэн төлж чадахгүй байгаа гэв. Ер нь хэрэглэсэн юм чинь төлөх ёстой. Өрхийн 11 ам бүлийг тэжээхэд сарын 52000 хүрэлцддэггүй. Цахилгаан эрчим хүчний зардал сард дунджаар 4000-5000 байдаг юм. Түлшинд өвлийн сард 30000 төгрөг шаардагдана.



---

---

Гуйлгаар л амьдарч байна даа. Тэтгэврийн мөнгөөрөө ахуйн хэрэглээний зүйлсээ бага багаар өдөр аргацаахын тулд авдаг. Амьдрал нэг ийм л дүр төрхтэй байна гэв.

Орон сууцны болон гэр хороололд байршил өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлогч болж байна. Хотын төвд ойр байршилтай газруудын дэд бүтэц харьцангуй сайн, зах зээлийн үнэ, үнэлгээ өндөр. Байршлын давуу тал амьжиргааны зардлыг бууруулахад нөлөөлдөг. Сүүлийн жилүүдэд хотод хүн амын ачаалал нэмэгдэж байгаа нь цахилгаан эрчим хүч, усан хангамжийн ачааллыг эрс нэмэгдүүлэх шалтгаан болжээ. Ялангуяа оролцооны аргын судалгаанд хамрагдсан хотын захын хорооллын өрхийн оролцогчдын хувьд тээврийн зардал өндөр, цахилгаан эрчим хүчний хүчдэл муу байдаг талаар түлхүү өгүүлжээ. Өрхийн эзэмшилд байгаа байршил сайтай хашаа, орон сууцаа ядуу, эмзэг бүлэгт хамаарагдаж буй иргэд зарах замаар амьжиргаагаа тэтгэдэг гэжээ.

Ядуу өрхийн нийтлэг шинж чанарууд нь дангаараа ядууралд нөлөөлөхөөс илүү өөр хоорондоо шүтэлцсэн байдалтай байна. Өөрөөр хэлбэл, эдгээр шинж чанарууд нь эмзэг байдал, ядуурлын шалтгаан, үр дагавар аль алин болж байдаг.

### **1.3 Ядуу өрхийн гишүүд**

Өрхийн гишүүд хөдөлмөр эрхлэж чадахгүй байх, боловсролын түвшин бага, мэргэжилгүй байх, эрүүл мэнд дорой байх зэргээс шалтгаалан өрх ядуурч байгааг оролцооны аргын судалгаагаар тодорхойлсон байна. Эдгээр нь өрхийн амьжиргаанд шаардлагатай орлого олж чадахгүй байхад нөлөөлдөг. Мөн өрх ядуу байх нь өрхийн гишүүд сайн боловсрол, мэргэжил эзэмшиж чадахгүй байх, өлсгөлөн тураалд орох улмаар эрүүл мэнд муудах, ажлын байр олдохгүй байх, амьдралд хангалттай орлого олж чадахгүй байх шалтгаан болж байна. Эдгээр нь өрхийн гишүүдийг урт удаан хугацаанд ядуу орчинд амьдрах улмаар өв залгамжилсан ядууралд хүргэж байна гэж оролцогчид дүгнэсэн.


Өрхийн гишүүдийн мэдлэг, ур чадвар, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт нь өрхийн ахуйн хэрэглээний түвшинг тодорхойлохоос гадна эргээд ахуйн хэрэглээний түвшинд нь нөлөөлж байдаг харилцан хамааралтай хэмжигдэхүүн гэж үзэж болохоор байна.

Өрхийн тэргүүлэгчийн хүйсийн байдал нь өрхийн амьжиргаанд нөлөөлж байгаа хандлага ажиглагдах болов. Энэ судалгаанд нийт 100 гаруй өрх толгойлсон эмэгтэй бүхий өрх хамрагдсаны дийлэнх нь амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой гишүүд бүхий өрхөд багтаж байна. Манай асуулгын судалгааны түүвэрлэлтийг санамсаргүй байдлаар хийсэн хэдий ч олон тооны өрх толгойлсон эмэгтэй өрх хамрагдсан шалтгаан нь



хорооны нийгмийн ажилтнууд, хэсгийн ахлагч нарын нөлөөлөл байсан болно. Гэхдээ гэр бүл салах, бэлэвсрэх явдал нэмэгдэж байгаагаас өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо өсөж байна. А. Солонго судалгааны тайландаа “Нас баралтын төвшин хүйсийн хувьд нэлээд ялгаатай байна. Тухайлбал; 1993 онд нас барсан 100 эмэгтэй тутамд 119 эрэгтэй ногдож байсан бол 2003 онд 146 болж эрэгтэйчүүдийн нас баралт эрс өсөж мөн хугацаанд нийт өрхөд өрх толгойлсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь 7.4 өөс 10.9 болж нэмэгджээ. Бэлэвсэн эмэгтэйчүүдийн тоо өсөхийн зэрэгцээ гэр бүл цуцлалт ч нэмэгдсэн байна. Энэ байдал нь эмэгтэйчүүд, бага насны хүүхдийн амьжиргааны эмзэг байдлыг нэмэгдүүлсээр байна” гэжээ<sup>7</sup>. Гэр бүл салалт, эрэгтэйчүүдийн эрт нас баралтад архидалт, нийгмийн стресс, буруу хооллолт зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна гэж үздэг. Судалгаанд хамрагдсан 18–аас дээш насны оролцогчдын 22.6 хувь баталгаатай гэр бүл, 11.4 хувь батлуулаагүй гэр бүл, 15.6 хувь бэлбэсэн, 4.6 хувь цуцалсан, 3.1 хувь тусдаа амьдарч байгаа гэр бүлүүд байна. Судалгаанд хамрагдсан өрхийн дийлэнх хувь бэлбэсэн эмэгтэй бүхий өөрсдийн үр хүүхэд, тэдний гэр бүлтэй хамт амьдарч байгаа өрхүүд байв.

**Зураг 1.3 Өрхийн гишүүдийн гэрлэлтийн байдал /хүйсээр/**



Өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал өрхийн амьжиргаа, орлогод ихээхэн нөлөө үзүүлж байна. Хөдөлмөр эрхлэлтийн асуудалд ажилтай эсэхээс гадна ажлын хөлсний хэмжээг гол болгон авч үзэж байв. Судалгаанд хамрагдсан өрхийн нийт гишүүдийн 6.5 хувь төсвийн байгууллагад, 10.3 хувь хувийн хэвшлийн байгууллагад, 2.6 хувь хувиараа хөдөлмөр эрхлэж байгаа, 13.2 хувь ажилгүй, 11.3 хувь тэтгэвэр, тэтгэмж авагч нар байв.

Хөдөлмөр эрхэлж чадахгүй, ажил олдохгүй байгаа нийтлэг шалтгаан нь мэргэжилгүй, ажил хайгч нь ажлын байрны шаардлагыг хангаж чадахгүй байгаагаар холбон тайлбарлаж байв. Олдож байгаа ажлын байр нь голдуу оёдлын үйлдвэр, бар цэнгээний газар байдаг боловч тэдгээрийн цалин хөлс

<sup>7</sup> А. Солонго. Хүн ам зүйн асуудлууд ба ядуурал. УБ 2004, хуудас [9].

---

бага байдаг. Оёдолчин, үйлчлэгч, туслах ажилтны ажлын хөлс нь дунджаар 25-50 мянган төгрөг байх бөгөөд унаа, хоол зэрэг зардалд цалингийн ихэнх хувь нь зарцуулагдаж байна. Ядуу өрхийн хувьд ихэнхдээ нэг гишүүн бага цалин хөлстэй ажил хийж байгаагаас өрхийн нэг гишүүнд ногдох бодит орлого бага байна.

Төсвийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллага ч цалин хөлсийг тодорхой цаг хугацаанд олгодоггүйгээс өрхийн амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлдэг, амьжиргааны бодит өртөг, ажлын хөлсний хэмжээ хоорондын харьцаа ихээхэн зөрүүтэй гэж тэд өгүүлж байв.

Цалин хөлсний хувьд харьцангуй боломжтой байдаг харуул хамгаалалтын алба, барилгын компани, алтны үйлдвэрүүдийн ихэнх нь улирлын чанартай ажилчин авдаг бөгөөд тэр бүр олддоггүй гэж байв. Мөн дөчөөс дээш насны хүмүүсийн хувьд бараг ажилд авдаггүй. Тэтгэврийн насны иргэд ялангуяа цэрэг, боловсролын байгууллагаас цомхотголоор эрт тэтгэвэрт гарсан иргэд ажил хөдөлмөр эрхэлж өрхийн орлогоо нэмэгдүүлэх хүсэл эрмэлзэл их байдаг боловч ажлын байр алга байна.


Статистик судалгаагаар Монгол улсад хөдөлмөрийн насны хүн амын өсөлтийн хурд нь нийт хүн амын өсөлтийн хурдаас илүү байгаа бөгөөд ирэх хэдэн жилд энэ хандлага хадгалагдана<sup>8</sup>. Иймд эмэгтэйчүүд, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн асуудалд Засгийн газрын зүгээс ихээхэн анхаарал хандуулах шаардлага гарч байна. Мөн ажлын байр шинээр бий болгоход чиглэсэн хөрөнгө оруулалт, экспорт, импортын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх нь чухал юм. Эдгээр бодлогын арга хэмжээг авч чадахгүй нөхцөлд хөдөлмөрийн зах зээлийн ачаалал улам нэмэгдэж, өрхийн ядуурал хадгалагдсаар байх бололтой. Энэ нь ахуйн хэрэглээний зах зээлийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлж болно.

Өрхийн гишүүдийн боловсролын түвшин өрхийн амьжиргаа, хэрэглээнд нөлөөлж байна. Судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдийн 4.7% боловсролгүй, 11.5% бага, 30.9% бүрэн бус дунд, 29.9% бүрэн дунд, 4.7% мэргэжлийн анхан шатны, 5.4% дипломын дээд боловсролтой байна.

---

<sup>8</sup> Б.Батхүү нар. Монгол улс дахь хөдөлмөр эрхлэлтийн байдлын судалгааны тайлан 2003. хуудас 11

**Зураг 1.4 18 ба түүнээс дээш насны өрхийн гишүүдийн боловсролын түвшин**



Өрхийн гишүүдийн боловсролын түвшин бага байх тусам өрхийн ядуу, эмзэг байдалд өртөх магадлал их байгааг судалгааны үр дүн нотолж байв. Үүнийг боловсролын түвшин бага, ур чадвар хангалтгүй учир ажлын байр олдохгүй, цалин багатай ажил олдож байгаа нь өрх ядуурах, эмзэг байдалд орох нэг шалтгаан болж байна гэж оролцогчид тайлбарлаж байв. Ядуу өрхийн гишүүд ажилтай болохын тулд хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлж, түр сургалтанд хамрагддаг боловч ажлын байр олдоогүй байна.

Өрхийн гишүүдийн эрүүл мэндийн дорой байдал өрхийн амьжиргаанд нөлөөлдөг<sup>9</sup>. Өрхийн гишүүдийн эрүүл мэнд муудсанаас эмчилгээний зардал, бусад дагалдах зардалууд өсдөг гэжээ. Оролцооны аргын болон кейсийн судалгааны явцад өрхийн гишүүдийн өвчлөл, хөдөлмөрийн чадвараа алдах, төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй байдал нь өрхийн амьжиргаанд ихээхэн нөлөөлж байна гэж тодорхойлж байв.

Ядуу өрхүүдийн дийлэнх нь гэр хороололд амьдарч байгаа бөгөөд амьдрах орчин, агаарын бохирдлоос шалтгаалан сүүлийн жилүүдэд өрхийн бага болон өндөр настай гишүүдийн дунд зүрх судасны болон амьсгалын замын өвчлөл нэмэгдэж байгаа статистик үзүүлэлт байна. Жейнс (2000)-ийн судалгаанаар тухайн судалгаанд хамрагдсан өрхүүдийн 15% нь хүнд өвчин эмгэгээс болж ядуурсан ба ядуурч байна гэсэн бол, 20% нь санхүүгийн бэрхшээл, амьжиргааны ядуу байдлаас эмчийн зааврыг дагаж чадахгүй өвчнөө хүндрүүлсэн гэжээ<sup>10</sup>.

## 1.4 Дүгнэлт

ҮСГ-ын өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлохдоо ашиглаж байгаа орлого зарлагын хүснэгттэй төсөөтэй хэлбэрийн хүснэгтийг ашиглан явуулсан судалгааны үр дүнд нийт өрхийн 42 хувь нь сард 10600 төгрөгөөс

<sup>9</sup> Эдийн засгийн өсөлтийг дэмжиж ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг. Монгол улсын Засгийн Газар. Улаанбаатар 2003, хуудас [175].

<sup>10</sup> Эдийн засгийн өсөлтийг дэмжиж ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг. Монгол улсын Засгийн Газар. Улаанбаатар 2003, хуудас [175].

---

бага, 41.5 хувь 26500 төгрөгнөөс доогуур орлого бүхий гишүүнтэй өрхүүд хамрагдсан байв. Эдгээр өрх өөрсдийнхөө амьжиргааны түвшинг дараах байдлаар тодорхойлжээ. Нийт өрхийн 42.5 хувь нэн ядуу, 38.5 хувь ядуу, 13.5 хувь дундаас доогуур, 5.5 хувь дундаж амьжиргаатай гэжээ. Дээрх хоёр үр дүнгээс судалгаанд хамрагдсан өрхийн 80 гаруй хувь ядуу өрхүүд байна гэж үзэж болох юм.

Асуулгын судалгаанд хамрагдсан нийт өрхийн гишүүдийн дундаж тоо 4 байгаа ч ядуу өрхийн хувьд энэ үзүүлэлт арай өндөр хувьтай байсан тэдний ихэнх нь гэр хорооллын гэр, галлагаатай орон байранд амьдарч байгаа өрхүүд байлаа. Мөн зориулалтын бус орон байранд амьдарч байгаа өрхүүд ч хамрагджээ. Нэг орон байранд 2-оос олон өрх хамт амьдарч байгаа өрхийн тоо нийт өрхийн 30 гаруй хувьтай тэнцэж байна.

Судалгаанд хамрагдсан өрхийн нийт гишүүдийн 19.4 хувь нь төсвийн байгууллага болон хувийн хэвшилд хөдөлмөр эрхлэж, 11.3 хувь тэтгэвэр, тэтгэмж авагч нар байна. Өөрөөр хэлбэл өрхийн гишүүдийн 30.7 хувь нь ямар нэг хэлбэрээр орлого бий бологч гишүүд байна. Өрхийн гишүүдийн боловсролын түвшин бага байх тусам өрхийн ядуу, эмзэг байдалд өртөх нь явдал нэмэгдэж байна.

Өрхийн амьжиргааны түвшинд өрхийн амьдарч байгаа орчин, орон байр, гэр бүлийн байдал, ам бүлийн тоо, бүтэц болон өрхийн гишүүдийн боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийн байдал зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж байна. Эдгээр хүчин зүйлийн өрхийн амьжиргааны түвшинд үзүүлж байгаа нөлөөлөл нь өрхийн ахуйн хэрэглээнд мөн үйлчлэх нь тодорхой.

Эдгээр хүчин зүйлүүд нь шалтгаан үр дагаварын холбоог харилцан үүсгэж байдаг.

---

---

## Бүлэг 2. Ядуу өрхийн амьжиргаа

Энэ бүлэгт өрхийн амьжиргааг тодорхойлж байгаа өрхийн орлого, зарлага, нөөцийн талаар статистикийн болон асуулгын судалгааны үр дүнд үндэслэн тайлбарласан. Мөн өрхийн амьжиргаанд нөлөөлж байгаа бусад хүчин зүйлийн талаар оролцооны болон кейсийн судалгааны үр дүнд тулгуурлан судлах болно.

### 2.1 Ядуу өрхийн амьжиргааны илэрхийлэл

Өрхийн амьжиргаа гэдэг нь өрхийн гишүүдийн амьдралын өдөр тутмын үйл явц, харилцаа юм. Маслоу “Хүний бүх хэрэгцээ нь төрөлхийн зөн билгийн шинжтэй бөгөөд шатчилсан зохион байгуулалтад оршдог” гэж үзээд түүнийг ач холбогдлоор нь дараах шатлалаар ангилжээ. Үүнд:

- Физиологийн хэрэгцээ
- Аюулгүй байдлын хэрэгцээ
- Харьяалагдах, хайрлахын хэрэгцээ
- Өөрийгөө хүндэтгэх хэрэгцээ
- Өөрийгөө идэвхижүүлэх хэрэгцээ

Өрхийн гишүүдийн хувьд суурь хэрэгцээний тодорхой хувь хангагдсанаар дараагийн шатны хэрэгцээ үүсэж байдаг. Физиологийн хэрэгцээ нь хоол, ундаар өлсөж, цангахгүй байх асуудал бөгөөд энэ хэрэгцээ тодорхой хэмжээгээр хангагдаж байгаа нөхцөлд аюулгүй байдлын хэрэгцээндээ ач холбогдол өгөх болно.

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 83.5 хувь өрхийн нэг гишүүнд ногдох сарын орлого нь 26500 төгрөгөөс доош байгааг өмнө дурьдсан. Нийт хамрагдсан өрхийн 8.5 хувь зориулалтын бус орон сууцанд амьдарч, 12.5 хувь ямар нэг шалтгаанаар цахилгаан эрчим хүчээр хангагдаж чадахгүй, 5.5 хувь ундны усандаа гол булаг шандны ус ашиглаж байна гэжээ. Өрхийн нийт зардалд хүнсний зардал өндөр хувьтай байгаа ч дийлэнх өрх хүнсний наад захын шаардлагатай хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаа талаар оролцогчид судалгааны явцад танилцуулж байв. Өөрөөр хэлбэл эдгээр өрхүүд физиологийн болон аюулгүй байдлын хэрэгцээгээ хангаж чадаагүй байна гэсэн үг.


Өрхийн амьжиргаа, хэрэгцээгээ хангах асуудал нь өрхийн гишүүдийн төлбөрийн чадвартай холбоотой бөгөөд тэдний нийгэмд хандах хандлага, бие даасан байдал, өөртөө итгэх итгэл зэрэг сэтгэл зүйн зан байдалд нөлөөлдөг. Өрхийн амьжиргааны түвшин дорой байх нь тухайн өрхийн гишүүн болох бага насны хүүхэд, тэтгэврийн насны болон хөгжлийн

бэрхшээлтэй хүмүүс, өрх толгойлсон эмэгтэйчүүдэд илүү хүнд тусч байгаа нь оролцооны болон кейсийн судалгаа харуулж байна.

ҮСГазар Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшиний судалгааг жилийн судалгааг 1995, 1998, 2002-2003 онуудад явуулан тайланг боловсруулан гаргасан. Сүүлийн тайланд ядуурал хот суурин газруудад хөдөөтэй харьцуулахад харьцангуй бага буюу 30 хувь, хөдөөд 43 хувь байна гэжээ<sup>11</sup>.

Энэ судалгаанд өрхийн орлого, зарлагыг тодорхойлохдоо ҮСГ-ын сар, улирал, жилээр өрхийн амьжиргааг судлахдаа ашиглаж байгаа хүснэгттэй төсөөтэй хүснэгтийг ашигласан талаар өмнө өгүүлсэн. Энэ хүснэгтээр авсан судалгааны үр дүн нь дараах байдалтай байна. Өрхийн нийт зарлагын дунджаар 48.8 хувийг хүнсний хэрэглээ, 15.2 хувийг хүнсний бус хэрэглээний зардал, 22.5 хувийг ахуйн хэрэглээний зардал эзлэж байв. Энэ үр дүнг ҮСГ-аас гаргасан 2003 оны өрхийн зарлагын үзүүлэлттэй харьцуулж Зураг 2.1–д харууллаа. Гэхдээ энэ хоёр үзүүлэлт нь судалгааны арга зүй, хамрах хүрээ, цаг хугацааны хувьд өөр хоорондоо ихээхэн ялгаатай болохыг зайлшгүй хэлэх хэрэгтэй. Харьцуулалт нь ядуу өрхийн хэрэглээний түвшинг дундаж өрхийн хэрэглээний түвшинтэй харьцуулан тодорхойлохыг оролдсон анхны оролдлого юм.

**Зураг 2.1 Нэг өрхийн сарын дундаж зарлагын бүтэц /хотод/<sup>12</sup>**



## 2.2 Өрхийн орлого

Өрхийн орлого нь мөнгөн болон мөнгөн бус гэсэн хэлбэртэй байна. Мөнгөн орлого нь эх үүсвэрийн шинж чанараараа байнгын болон байнгын бус байв. Байнгын мөнгөн орлогод төсвийн болон хувийн байгууллагаас

<sup>11</sup> Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгааны үндсэн тайлан, 2002-2003. ҮСГ, хуудас [2].


<sup>12</sup> Үндэсний статистикийн газрын мэдээлэл. “ӨОЗАТС 2002/2003” УБ 2004.

олгож буй ажлын хөлс, тэтгэвэр, тэтгэмж, мөнгөн хадгаламж зэргийг хамруулан үзэж байна. Асуулгын судалгаагаар ихэнхдээ байнгын мөнгөн хэлбэрийн орлогыг тодорхойлжээ.

Оролцооны болон кейсийн судалгаагаар ядуу өрхөд тэтгэвэр, тэтгэмж болон цалин хөлс нь өрхийн амьжиргааны гол эх үүсвэр болж байв. Өрхийн гишүүдийн байнгын бус орлого нь албан бус хэлбэрээр хувиараа хөдөлмөр эрхлэн олж байгаа орлого, ах дүү хамаатан садан, тусламжын байгууллагаас үзүүлж байгаа мөнгөн тусламж, бусад хэлбэрийн тогтмол бус мөнгөн орлогоос бүрддэг гэжээ. Ийм төрлийн орлогын тоо хэмжээг тодорхойлох нь нилээд төвөгтэй. Ихэнх нөхцөлд тодорхойлох боломжгүй. Учир нь өрхийн гишүүдийн өдөр, сар тутам олж буй орлого тогтмол бус, тоо хэмжээ нь өөр өөр байдгаас тэр бүр нарийн тодорхойлж чадахгүй байв. Ядуу өрхүүдийн хувьд өрхийн төсөв, орлого, зарлагын бүртгэл зэрэг ойлголт бараг байхгүй юм.

Өрхийн орлогыг ҮСГ-ын Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшиний түүвэр судалгааны үндсэн тайланд /2002-2003/ нарийвчлан авч үзээгүй бөгөөд энэ үзүүлэлтийг ҮСГ-ын жил бүрийн статистикийн эмхтгэлийг ашиглан судаллаа. Эдгээр статистикийн жилийн эмхтгэлд өрхийн орлогыг цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, хувийн аж ахуйн орлого болон бусад гэсэн ангиллаар тооцсон байна /хүснэгт 2.1, 2.2-оос харна уу, хуудас 26-27/.

**Зураг 2.2 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого /орлогын төрөл, хувиар/<sup>13</sup>**



Цалин хөлсний орлого нь 1990 онд өрхийн нийт орлогын 84 орчим хувийг эзлэж байсан бол сүүлийн жилүүдэд түүний өрхийн нийт орлогод эзлэх тоо хэмжээ байнга буурсан хандлагатай байна. 2003 онд 41.1 хувийг эзэлж байгаа ч өрхийн гол орлого хэвээр байна. Өрхийн нийт орлогод цалин

<sup>13</sup> Үндэсний статистикийн газрын мэдээлэл болон 2003 оны Статистикийн эмхтгэл, ҮСГ.

---

хөлсний орлого буурч буй шалтгаан нь ажилгүйдлийн хэмжээ өндөр байгаа, албан сектор дахь ажлын хөлс бага байгааг гэрчилнэ. Тэтгэвэр тэтгэмжийн өрхийн нийт орлогод эзлэх хувь хэмжээ өнгөрсөн хугацаанд бараг өөрчлөгдөөгүй байна. Энэ нь мэдээж олон хамааралтай байж болох боловч гол нь Засгийн газраас тэтгэвэр, тэтгэмжийн өөрчлөлтийг инфляцийн түвшинтэй уялдуудан нэмж байгааг харуулна. Хувийн аж ахуйн орлого 1990 оноос хойш байнга өсөж байгаа нь Монгол улс зах зээлийн харилцаанд шилжиж, өмчийн олон хэлбэрийг хүлээн зөвшөөрсөнтэй шууд холбоотой. Мөн Улаанбаатар болон төв суурин газруудад эдийн засгийн албан бус сектор хүчтэй хөгжиж байгаатай ч холбоотой. Өрхийн бусад орлого нэмэгдэж байгаа нь гадаадад олноор гарсан ажиллах хүчний олж буй орлоготой ч холбоотой нь тодорхой.

Манай судалгаанд хамрагдсан өрхийн сарын дундаж орлого 61000 мянган төгрөг байгаа нь судалгаа дийлэнхдээ ядуу өрх хамрагдсаныг нотолно. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 65.5 хувь орлогын нэг эх үүсвэртэй, 29 хувь нь хоёр эх үүсвэртэй гэсэн бол 3 хувь нь огт эх үүсвэргүй гэжээ.

Өрхийн мөнгөн бус орлогын талаар нэмэлт тайлбар өгөх мэдээлэл бага байна. Гэр хороололд амьдарч байгаа өрхүүдийн хувьд хувийн мал аж ахуйтай байх, жижиг үйлдвэрлэл явуулах, ногоо тарих, ах дүү, хамаатан садан, бусад байгууллагаас үзүүлж байгаа материаллаг дэмжлэг туслалцааг үзүүлдэг талаар судалгаанд оролцогчид өгүүлж байсан ч тодорхой тоо баримтыг дурьдаагүй болно.

Цаашид өрхийн орлогыг судлахдаа төрөөс ядуу өрхийн гишүүдийг их дээд сургуульд суралцахад үзүүлж байгаа тэтгэлэг, хүүхдийн мөнгө зэргийг тусгаж байх өрхийн орлогыг зөв тооцох, тэгш хуваарилалтыг бий болгох ач холбогдолтой.

### **2.3 Өрхийн зарлага**

Өрхийн зарлага нь тухайн өрхийн хэрэглээг мөнгөн дүнгээр илэрхийлж буй үзүүлэлт юм. Гэхдээ өрхийн бүх хэрэглээний мөнгөн дүнг тооцох нь орлогыг тодорхойлохоос хялбар биш юм. Гэхдээ өрхийн хэрэглээний зардлыг мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр оролцогчид илэрхийлж байсан бөгөөд өрхийн хэрэглээний мөнгөн дүнг ойролцоогоор тооцож байв. Өрхөд ямар нэг бүртгэл тооцоо байдаггүйгээс түүнийг тодорхойлоход хүндрэлтэй байв. Хэрэглээний тодорхой хэсэг биет хэлбэрээр нийлүүлэгдэж байдгаас түүнийг үнэлж чадахгүй байв.

Ядуу өрхийн орлого тогтмол бус байдгаас орлогын хувиарилалт ч жигд бус. Өрх олсон орлогоо тухайн үед хамгийн чухал хэрэгцээнүүдэд хуваарилах замаар хангадаг. Өөрөөр хэлбэл “гал унтраах” хэлбэрээр хуваарилдаг. Өрхийн зарлага, хэрэглээний түвшин өрхийн орлогоос хамааралтай хэмжигдэхүүн бөгөөд өрхийн орлого өсөхийн хэрээр өрхийн



---

зарлага тодорхой түвшинд хүртэл өсөж байдаг функц юм. Энэ нь хувь хүний хэрэглээ нь тодорхой хязгаартай байдгаас тодорхой түвшинээс өсөх боломжгүй. Хэрэгцээгээ хангаж чадаагүй ядуу өрхийн хувьд хэрэглээний функцийн утга нь байнга өсөх эрмэлзэлтэй хязгаарт байрладаг.

“Ядуу өрхийн амьжиргаанд үзүүлэх ахуйн хэрэглээний үнийн нөлөөлөл” судалгаа нь ахуйн хэрэглээг өрхийн зарлага, түүнд ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний эзлэж буй хувь хэмжээг тодорхойлохоос эхэлсэн. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн сарын нийт мөнгөн зарлагын дундаж утга 97000 төгрөг байсан бөгөөд үүний 56300 төгрөгийг хүнсний бус хэрэглээндээ зарцуулдаг гэжээ.

ҮСГ–ын статистикийн жилийн эмхтгэлд өрхийн зарлагыг хүнсний, хүнсний бус, таваарын бус гэж ангилан жил жилээр улсын дундаж үзүүлэлтийг тооцжээ. Өрхийн зарлага нь 1990 оноос хойш инфляц болон бусад хүчин зүйлүүдээс шалтгаалан байнга өссөн байна. 2003 онд өрхийн бодит орлого 144176 төгрөг байхад өрхийн зарлага 158113 төгрөг байв. Өрхийн орлого, зарлага жил бүр зөрөөтэй байгаа бөгөөд зарлага байнга илүү байна /Хүснэгт 2.1, 2.2-оос харна уу/. Мөн “Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшиний түүвэр судалгааны 2002-2003 оны үндсэн тайлан”-д нэг хүнд сард ногдох хэрэглээг мөнгөн дүнгээр болон хувиар бүс бүсээр тодорхойлжээ. Дээр өгүүлсэн хоёр статистик тайлангийн хувьд түлш, цахилгаан, дулаан, усны зардлуудыг өөр өөр хэсэгт хамруулан тооцсон нь шууд харьцуулалт хийх боломжгүй байна. Статистикийн жилийн эмхтгэлд “түлш” гэсэн нэрээр өрхийн ашиглаж байгаа бүх төрлийн түлшний зардал, орон сууц, нийтийн ахуйн үйлчилгээ нэрээр цахилгаан, цэвэр, бохир ус, хог зайлуулах зэрэг үйлчилгээний зардлуудыг хамруулан авч үзсэн байна. Өрхийн түлшний сарын хэрэглээний зардал 2003 онд 7841.9 төгрөг, орон сууцны ахуйн үйлчилгээний зардал 4767.3 төгрөг байна гэжээ. “Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшиний түүвэр судалгааны үндсэн тайлан /2002-2003/-гийн Улаанбаатар хотод нэг хүнд ногдох сарын хэрэглээг өрхөд шилжүүлэн үзэхэд халаалтын зардал 7000 төгрөг, гэрэл цахилгаан, ус, телефон утасны зардал 14200 төгрөг гэж тодорхойлжээ.


“Ядуу өрхийн амьжиргаанд үзүүлэх ахуйн хэрэглээний үнийн нөлөөлөл” судалгаанд хамрагдсан нийт өрхийн нэг сарын цахилгаан эрчим хүчний дундаж зардал 5000 төгрөг, ундны усны зардал 725 төгрөг, модны зардал 8000, нүүрсний зардал 15000 төгрөг тус тус байна. Түлшний зардал нилээд өндөр байгаа шалтгаан нь судалгааг өвлийн улиралд хийсэнтэй холбоотой байж болох юм. Энэ хэрэглээг бүтэн жилийн хэрэглээнд хуваарилахад бага хэмжээтэй байх нь тодорхой.

Орон сууцанд амьдарч байгаа өрх сард дундажаар 9451 төгрөгийг цахилгааны зардалд, байрны халаалт, халуун хүйтэн ус, бохир ус, хог хаягдал, холбоо зэрэг зардлуудад сард дундажаар 26150 төгрөг зарцуулж байна. Харин гэр хороололд амьдарч байгаа өрх сард дундажаар ахуйн

хэрэглээндээ 29925 төгрөгийг зарцуулж байгаагаас цахилгаан эрчим хүчинд 5000 төгрөг, модонд 8000 төгрөг, нүүрсэнд 15000 төгрөг тус тус ногдож байв. Орон сууц гэр хорооллын ахуйн хэрэглээний сарын дундаж зардал ойролцоо байна. Харин зардлын бүтэц нь нилээд ялгаатай байв.

Өрхийн зарлагыг хүнсний, хүнсний бус, таваарын бус гэж ангилан үзэхэд судалгаагаар хүнсний зарлага нийт зарлагын 48.8 хувийг, орон сууц, ахуйн хэрэглээний зарлага 22.9 хувийг эзэлж байна. Гэр хорооллын өрхийн ахуйн хэрэглээний нэг сарын зардлын задаргааг Зураг 2.3 харна уу.

**Зураг 2.3. Гэр хорооллын нэг өрхийн сүүлийн нэг сарын ахуйн хэрэглээний зардал**



## 2.4 Өрхийн нөөц

Өрхийн амьжиргаанд нөлөөлж буй нөөцийг материаллаг ба материаллаг бус гэж авч үзэж байв. Материаллаг нөөцөд ирээдүйд хөрвөх чадвар бүхий үл хөдлөх хөрөнгийг хамруулдаг бол материаллаг бус нөөцөд мөнгөн хэлбэрийн нөөцүүдийг хамруулсан. Өрх ядуурах нь бүх хэлбэрийн нөөцийн хомсдолд орж, эмзэг байдал нэмэгдэхийг авч үзэж байв. Материаллаг бус нөөцөд өрхийн гишүүдийн чадавхи, чадвар, өрхийн хэн нэгэн гишүүн гадаадад ажиллах зэргийг ч оруулах хэрэгтэй гэж үзэж байв.

Судалгааны явцад газар хувьчлагдаж байгаагаас гэр хорооллын газар, орон байрны үнэлгээ Улаанбаатар хотод нэмэгдэж байна гэж оролцогчид тэмдэглэж байв. Энэ байдал өөрийн хөрөнгөө барьцаалах замаар банкнаас зээл авах, бизнес эрхлэх таатай боломжийг бүрдүүлж байгаа ч дөнгөж эхлэлийн төдий байна. Ядуу өрхүүд хотын төвөөс зайдуу, захын хорооллуудад олноор нягтран сууршиж байгаа бөгөөд тэнд дэд бүтэц сайн хөгжөөгүй байдаг. Түүнчлэн ядуу өрхүүд өөрийн газраа тэр бүр хувьчилан авч чадаагүй байна.

Оролцооны аргын судалгаагаар ядуу өрхүүд хувиараа бизнес эрхлэх эрмэлзэлтэй боловч хөрөнгийн эх үүсвэр байдаггүй гэжээ. Тэд банкнаас зээл авахыг хүссэн ч хөрөнгийн баталгаа байхгүйгээс бүтдэггүй гэж байв. Цаашид

---

төрийн захиргааны байгууллагууд энэ асуудалд анхаарч дэмжлэг туслалцаа үзүүлэхийг хүссэн.

Харин орон сууцанд амьдарч байгаа айл өрхийн хувьд орон сууцаа барьцаалах замаар бизнес эрхлэх боломж илүү ч бизнес эрхлэх ур чадвар хангалтгүйгээс авсан зээлээ эргүүлэн төлж чадахгүй өрөнд ордог талаар кейсийн судалгааны явцад өгүүлж байв.

Хүснэгт 2.1, 2.2-оос харахад сүүлийн жилүүдэд өрхийн хадгаламж нэмэгдсэн байна. Энэ нь өрхийн орлого нэмэгдэж, улмаар тодорхой хэмжээний хуримтлал үүсэх бололцоо бүрдэж байгаа эерэг хандлага юм.

## **2.5 Өрхийн амьжиргаанд нөлөөлж буй бусад хүчин зүйл**

Оролцооны аргын судалгааны оролцогчид өрхийн ахуйн хэрэглээнд оршин амьдарч байгаа орчны дэд бүтэц, орон нутгийн ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнийг хүргэж буй байгууллагын үйлчилгээний түвшин, үйлчилгээний хүртэмж, чанар зэрэг хүчин зүйл нөлөөлж байна гэж тодорхойлсон.

Харин өрхийн амьжиргаанд нийгмийн үйлчилгээ ихээхэн үүрэгтэй болохыг онцолж байв. Амьжиргааны түвшингээр ядуу өрхүүдийн хувьд нийгмийн үйлчилгээг ялангуяа эмнэлэг, сургууль, цэцэрлэг болон нийгмийн халамжийн үйлчилгээ чухал үүрэгтэй байна. Сүүлийн жилүүдэд хорооны нутаг дэвсгэрт гарсан өөрчлөлтүүд нь эдгээр төрлийн үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн байна. Гэвч хүн амын механик өсөлт нь хангалттай үр нөлөөг бий болгоход саад болж байна.

Мөн судалгаанд хамрагдсан ихэнх хорооны нутаг дэвсгэрт шинээр худаг барих, төвлөрсөн усан хангамжийн шугамтай болгох, цахилгаан эрчим хүчний шугмыг өргөтгөх, шинэчлэх, авто зам барих ажлууд хийгдсэн байна.

Мөн түлш, модны захууд хотод олноор байгуулагдсан нь иргэдийн түлшний хангамжид сайн нөлөө үзүүлсэн байна.

Оролцогчдын хувьд Улаанбаатар хотод орчны болон агаарын бохирдлын асуудалд ихээхэн анхаарал хандуулж байв. Ялангуяа өвлийн улиралд гэр хорооллын ил зуухны утаа, нүүрсний дутуу шаталтаас үүдэлтэй агаарын найрлага алдагдсан нь оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх болжээ.

## Хүснэгт 2.1 Нэг өрхийн сарын дундаж орлого, зарлага<sup>14</sup> /мөнгөн дүнгээр/

\* ӨДӨӨ И ДЭЙ АЙ, ЧАДЭААУ И НОААЕААА, И ҮА ° ДӨӨИ МАДУИ АОТ ААЕ И ДЭЙ АЙ, ЧАДЭААА, Д° АӨ° А° Д, И И И Д, НООДУӨ ЕААД

	Өй д												
	1990	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003
И * И А° И И ДЭЙ АЙ -А° АА	1264	3448	8629	23465	38332	51689	62522	73101	75546	92135	130402	148554	144176
Оаеөй, ө° өн	1068	2103	5397	11652	19594	26340	30373	33356	35175	44791	47927	59522	59,274.2
Оүдөүд, дүдөүд ө	117	286	1133	2041	2777	4007	5183	6685	7863	10402	12322	12660	12,714.4
Ооаеөй ае адоөй и дөй ай	25	87	138	1226	3554	4712	5241	6799	7715	22565	28939	48041	46,057.6
Аонää	54	972	1962	8547	12406	16630	21724	26261	24793	14377	41214	28331	26,130.1
И * И А° И ЧАДЭААА-А° АА	1270	3441	9017	23515	38352	51310	61989	80189	84158	111786	130 402	161 369	158 113
<b>Өзг нн өө цгээөй чадэааа-агээ</b>	<b>536</b>	<b>1738</b>	<b>5595</b>	<b>12468</b>	<b>19501</b>	<b>27051</b>	<b>31491</b>	<b>36408</b>	<b>37115</b>	<b>51602</b>	<b>57 157</b>	<b>67 388</b>	<b>67,169.0</b>
И ао,и аоай аг дүүдүүдүгүгү	167	535	1653	3661	5576	7506	8342	9749	10051	15666	17 581	17 828	18,014.4
Нгүг, бaaаар аауу	56	156	400	947	1407	1899	2189	2871	3340	4442	5 189	5 891	5,954.0
Аодөө, аодөөй аг дүүдүүдүгүгү	96	342	1911	3715	5708	8845	10454	10578	9904	12284	11 913	13 508	13,641.5
Аонää	8	19	162	382	834	1133	1260	1425	1314	1761	1 898	2 499	2,336.9
× өдө, өдөи н	62	91	311	944	1393	1680	1914	2568	2811	3913	4 579	5 480	5,405.1
Ө° и н, өгүгү өө өй ай и	26	112	221	676	1360	1820	2148	3015	3362	4965	5 668	6 052	6,013.7
Адөө, аадөн	49	181	455	861	1147	1363	1690	1965	2162	2537	3 342	4 906	4,817.4
Оаи өө	11	97	152	251	502	725	863	1173	1256	1462	1 715	2 283	2,293.3
Аонää	60	204	330	1030	1573	2079	2632	3064	2915	4572	5 273	8 941	8,692.7
<b>Өзг нн өө аон цгээөй чадэааа-агээ</b>	<b>428</b>	<b>1145</b>	<b>2161</b>	<b>6931</b>	<b>10471</b>	<b>13069</b>	<b>15435</b>	<b>21640</b>	<b>24223</b>	<b>31328</b>	<b>33172</b>	<b>50104</b>	<b>45,926.9</b>
А° н ааааоо	26	86	131	271	351	459	455	657	541	623	535	1 095	813.8
Ауууу дөдөөн	146	411	673	1671	2328	2919	2996	5302	5967	9235	10 443	11 412	10,554.1
Аодөө, ай дөй ө	82	284	479	1437	1869	2426	2700	4013	3891	5671	6 526	7 829	7,426.1
Нг, еууу аадää	35	75	120	471	809	1082	1170	1221	1219	1506	1 328	2 134	1,147.8
Аууу, аууу адоөй аадää	56	102	174	496	1412	1880	2173	2852	1592	3310	2 866	4 519	1,589.8
Үи, үдүгү ө адоөй аадää	26	60	107	328	482	620	832	1818	2803	2625	2 141	5 771	7,043.2
Өгүө ө өө өө	8	37	267	494	717	924	1088	1950	2584	2827	3 737	7 386	7,841.9
Аонää	50	89	210	1762	2502	2760	4020	3827	4702	5531	5 597	9 958	9,510.2
<b>Оаааадуу аг чадэааа-агээ</b>	<b>306</b>	<b>559</b>	<b>1261</b>	<b>4116</b>	<b>8011</b>	<b>10931</b>	<b>14649</b>	<b>21842</b>	<b>21929</b>	<b>28615</b>	<b>39597</b>	<b>42663</b>	<b>44,021.1</b>
Оууууу, өй өй и	61	138	303	782	1438	1993	2687	4710	5766	8209	10 791	13 060	15,765.0
И дөй нөоо, өө өө өө ае адоө	95	133	378	1383	2466	3288	5249	5935	5750	6095	7 280	4 239	4,767.3
Адоөй цгээ-өө өө	23	34	72	169	388	527	560	445	221	348	448	3 070	2,725.0
Ай өй аадөй ө	-	-	-	-	429	716	1,916	4946	5,751	7,149	9 440	12 358	11,455.0
Үдүгү ө и үй өө өө өө өө	-	-	-	-	398	521	487	403	315	395	411	992	893.2
Аонää	127	254	508	1782	2891	3886	3751	5403	4126	6419	11 227	8 944	8,415.6
<b>Оааааа өө өө өө өө</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>369</b>	<b>259</b>	<b>414</b>	<b>299</b>	<b>891</b>	<b>241</b>	<b>476</b>	<b>1 214</b>	<b>995.9</b>

<sup>14</sup> Үндэсний статистикийн газрын мэдээлэл.

**Хүснэгт 2.2 Нэг өрхийн сарын дундаж орлого, зарлага<sup>15</sup> /хувиар/**

<sup>a</sup> ӨДӨӨЛГӨӨНИЙ ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ

	ӨИ Ө												
	1990	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
Өгөөр, өгөн	84.5	61.0	62.5	49.7	51.1	51.0	48.6	45.6	46.6	48.6	36.8	40.1	41.1
Өгөөр, өгөн	9.3	8.3	13.1	8.7	7.2	7.8	8.3	9.1	10.4	11.3	9.4	8.5	8.8
Өгөөр, өгөн	2.0	2.5	1.6	5.2	9.3	9.1	8.4	9.3	10.2	24.5	22.2	32.3	31.9
Аон	4.2	28.2	22.7	36.4	32.4	32.2	34.7	35.9	32.8	15.6	31.6	19.1	18.1
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
<b>Өгөөр, өгөн</b>	42.2	50.5	62.0	53.0	50.8	52.7	50.8	45.4	44.1	46.2	43.8	41.8	42.5
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	13.2	15.6	18.3	15.6	14.5	14.6	13.5	12.2	11.9	14.0	13.5	11.0	11.4
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	4.4	4.5	4.4	4.0	3.7	3.7	3.5	3.6	4.0	4.0	4.0	3.7	3.8
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	7.6	9.9	21.2	15.8	14.9	17.2	16.9	13.2	11.8	11.0	9.1	8.4	8.6
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	0.6	0.6	1.8	1.6	2.2	2.2	2.0	1.8	1.6	1.6	1.5	1.5	1.5
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	4.9	2.6	3.4	4.0	3.6	3.3	3.1	3.2	3.3	3.5	3.5	3.4	3.4
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	2.0	3.2	2.4	2.9	3.5	3.5	3.5	3.8	4.0	4.4	4.3	3.8	3.8
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	3.8	5.3	5.0	3.7	3.0	2.7	2.7	2.5	2.6	2.3	2.6	3.0	3.0
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	0.9	2.8	1.7	1.1	1.3	1.4	1.4	1.5	1.3	1.3	1.3	1.4	1.5
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	4.7	5.9	3.7	4.4	4.1	4.1	4.2	3.8	3.5	4.1	4.0	5.5	5.5
<b>Өгөөр, өгөн</b>	33.7	33.3	24.0	29.5	27.3	25.5	24.9	27.0	28.8	28.0	25.4	31.0	29.0
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	2.0	2.5	1.4	1.2	0.9	0.9	0.7	0.8	0.6	0.6	0.4	0.7	0.5
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	11.5	11.9	7.5	7.1	6.1	5.7	4.8	6.6	7.1	8.3	8.0	7.1	6.7
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	6.5	8.3	5.3	6.1	4.9	4.7	4.4	5.0	4.6	5.1	5.0	4.9	4.7
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	2.7	2.2	1.3	2.0	2.1	2.1	1.9	1.5	1.4	1.3	1.0	1.3	0.7
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	4.4	3.0	1.9	2.1	3.7	3.7	3.5	3.6	1.9	3.0	2.2	2.8	1.0
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	2.0	1.8	1.2	1.4	1.3	1.2	1.3	2.3	3.3	2.3	1.6	3.6	4.5
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	0.6	1.1	3.0	2.1	1.9	1.8	1.8	2.4	3.1	2.5	2.9	4.6	5.0
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	3.9	2.6	2.3	7.5	6.5	5.4	6.5	4.8	5.6	4.9	4.3	6.2	6.0
<b>Өгөөр, өгөн</b>	24.1	16.2	14.0	17.5	20.9	21.3	23.6	27.2	26.1	25.6	30.4	26.4	27.8
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	4.8	4.0	3.4	3.3	3.8	3.9	4.3	5.9	6.9	7.3	8.3	8.1	10.0
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	7.5	3.9	4.2	5.9	6.4	6.4	8.5	7.4	6.8	5.5	5.6	2.6	3.0
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	1.8	1.0	0.8	0.7	1.0	1.0	0.9	0.6	0.3	0.3	0.3	1.9	1.7
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	0.0	0.0	0.0	0.0	1.1	1.4	3.1	6.2	6.8	6.4	7.2	7.7	7.2
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	0.0	0.0	0.0	0.0	1.0	1.0	0.8	0.5	0.4	0.4	0.3	0.6	0.6
1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup> 1 <sup>a</sup>	10.0	7.4	5.6	7.6	7.5	7.6	6.1	6.7	4.9	5.7	8.6	5.5	5.3
<b>Өгөөр, өгөн</b>	0.0	0.0	0.0	0.0	1.0	0.5	0.7	0.4	1.1	0.2	0.4	0.8	0.6

<sup>15</sup> Үндэсний статистикийн газрын мэдээлэл.

Гэвч орчны болон агаарын бохирдлын хүн амд үзүүлж буй нөлөөлөл, түүний үр дагаврыг тодорхойлсон судалгаа, шинжилгээ хомс байна. Улаанбаатар хотод өвөл, хаврын улиралд сүүлийн жилүүдэд халдварт өвчин, хүнд хэлбэрийн томуу, ханиадны давталт, тархалт нэмэгджээ. Монгол улсын Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газар болон НҮБХХ хотын орчны болон агаарын бохирдлыг бууруулах талаар зарим үйл ажиллагааг явуулж байгаа ч зайлшгүй нэгдмэл, системтэй бодлого дутагдсаар байна.

## 2.6 Дүгнэлт

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн хувьд хэрэгцээний анхан шат болох физиологийн болон аюулгүй байдлын хэрэгцээгээ хангаж чадаагүй байгаа өрх ихэнх хувийг эзэлж байна. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 83.5 хувь өрхийн нэг гишүүнд ногдох сарын орлого нь 26500 төгрөгөөс доош байгаа нь үүнийг мөн баталж байна. Үүнээс гадна хамрагдсан өрхийн 8.5 хувь зориулалтын бус орон сууцанд амьдарч, 12.5 хувь ямар нэг шалтгаанаар цахилгаан эрчим хүчээр хангагдаж чадахгүй, 5.5 хувь ундны усандаа гол булаг шандны ус ашиглаж байна гэжээ.

Оролцооны болон кейсийн судалгаагаар ядуу өрхөд тэтгэвэр, тэтгэмж болон цалин нь өрхийн амьжиргааны гол эх үүсвэр болж байв. Өрхийн гишүүдийн бусад хэлбэрээр олж байгаа орлого, ах дүү хамаатан садан, тусламжын байгууллагаас үзүүлж байгаа мөнгөн тусламж, бусад тогтмол бус орлогуудыг тодорхойлох боломж хязгаарагдмал байна. Асуулгын судалгаанд хамрагдсан өрхийн сарын дундаж орлого 61000 мянган төгрөг байсан бөгөөд нийт өрхийн 65.5 хувь орлогын нэг эх үүсвэртэй, 29 хувь нь хоёр эх үүсвэртэй гэсэн бол 3 хувь нь огт эх үүсвэргүй гэжээ.

Өрхийн орлого тогтмол бус байдгаас өрхийн зарлагын хуваарилалт гал унтраах хэлбэрээр ихэнхдээ явж байна. Судалгаагаар хүнсний зарлага нийт зарлагын 48.8 хувийг, орон сууц, ахуйн хэрэглээний зарлага 22.9 хувийг тус тус эзэлж байна. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн нэг сарын цахилгаан эрчим хүчний дундаж зардал 5000 төгрөг, ундны усны зардал 725 төгрөг, модны зардал 8000, нүүрсний зардал 15000 төгрөг тус тус байна. Орон сууц гэр хорооллын ахуйн хэрэглээний сарын дундаж зардал ойролцоо байна. Харин зардлын бүтэц нь нилээд ялгаатай байв.

Өрх ядуурах нь бүх хэлбэрийн нөөцийн хомсдолд орж, эмзэг байдал нэмэгдэхтэй холбон тайлбарлажээ. Мөн өрхийн амьжиргаанд орчны дэд бүтэц, орон нутгийн ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнийг хүргэж буй байгууллагын үйлчилгээний түвшин, үйлчилгээний хүртэмж, чанар, мөн орчны болон агаарын бохирдол зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байна гэж судалгаанд оролцогчид дүгнэв.

## Бүлэг 3. Өрхийн ахуйн хэрэглээний зарим бүтээгдэхүүн

Энэ бүлэгт цахилгаан, дулааны эрчим хүч, түлш, усны ахуйн хэрэглээний зориулалт, эдгээрийн хэрэглээний талаар судалгааны үр дүнд суурилан нарийвчлан ярилцах болно.

### 3.1 Ахуйн хэрэглээний зарим бүтээгдэхүүний зориулалт

Улаанбаатар хотын хувьд цахилгаан, дулаан, усан хангамжийн хэрэглээ нь өрхийн суурь хэрэгцээ гэж судалгаанд оролцогчид үзэж байв. Эдгээр бүтээгдэхүүний эрэлт, хэрэглээ нь өрхийн хэрэгцээ, түүний худалдан авах чадвар, орлуулах бүтээгдэхүүн зэргээс хамаарна. Өрхийн ахуйн хэрэглээний эдгээр бүтээгдэхүүн үйлчилгээний ашиглалт, зориулалтыг хүснэгт 3.1-т харууллаа.

**Хүснэгт 3.1 Ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнийг өрхийн амьжиргаанд ашиглаж байгаа байдал**

	Суурь хэрэглээ	Нэмэлт хэрэглээ	Бизнесийн хэрэглээ	Хэрэглээний нөлөөлөл
Цахилгаан эрчим хүч	Хоол унд бэлтгэх Гэрэлтүүлэг	Өвлийн цагт дулаалцуулга, зун сэнс ажиллуулах Зуны улиралд хүнсний зүйлээ муутгахгүй байхын тулд хөргөгч ажиллуулах Телевиз радио ажиллуулах	Цахилгааны хэрэглээ Мотор, хөрөө зэргийг ажиллуулах	Өрхийн гишүүдийн эрүүл мэндэд Өрхийн гишүүдийн боловсролд Өрхийн гишүүдийн бүтээмж Мэдээллийн хүртээмж Өрхийн орлогод
Дулааны эрчим хүч	Орон сууцны өрхийн дулаалцуулга			Өрхийн гишүүдийн эрүүл мэнд, боловсролд
Түлш	Гэр хорооллын өрх дулаалцуулга Хоол унд бэлтгэх	Халуун усанд орох Хувцсаа угаах	Жижиг үйлдвэрлэл явуулах	Өрхийн гишүүдийн эрүүл мэндэд Өрхийн гишүүдийн бүтээмжинд Өрхийн гишүүдийн боловсролд
Ус	Унданд хэрэглэх Нүүр гар, биеэ угаах, хувцсаа угаах	Гэр орноо цэвэрлэх	Ногоо тарих Жижиг үйлдвэрлэл явуулах	Өрхийн гишүүдийн эрүүл мэндэд Өрхийн орлогод

Өрхийн амьжиргааны түвшин дээшлэхийн хэрээр суурь хэрэглээнээс илүү нэмэлт хэрэглээнүүд бий болдог ажээ. Ердийн түвшний амьжиргаатай өрхийн цахилгаан эрчим хүчний суурь хэрэглээ нь цахилгаан зуух, телевиз

радио, хөргөгч, угаалгын машин зэрэг ахуйн хэрэгцээний цахилгаан хэрэгслийг ашиглах юм. Харин эдгээр өрхүүд цахилгаан халаагуур, сэнс ажиллуулах нь илүү тансаг хэрэглээ билээ. Гэхдээ гэр хорооллын айл өрхүүд өвлийн цагт цахилгаан халаагуурыг хулгайгаар ашиглах нь тансаг хэрэглээтэй холбоогүй асуудал юм. “Улаанбаатар хотын цахилгаан эрчим хүч хэрэглэгчдийн судалгаа”-ны тайланд эрчим хүчний хулгайн талаар дэлгэрэнгүй тайлбарлажээ.

“Ядуу өрхийн амьжиргаанд үзүүлэх ахуйн хэрэглээний үнийн нөлөөлөл” судалгаагаар нийт өрхийн 90 гаруй хувь цахилгаан эрчим хүчийг гэрэлтүүлэг, гэр ахуйн цахилгаан хэрэгслийг ажиллуулахад ашиглаж байна. Өрхийн дулаалцуулгад цахилгаан эрчим хүчийг ашиглаж байгаа өрх 2.5 хувийг эзлэж байв. Дулааны эрчим хүчийг төвлөрсөн болон төвлөрсөн бус системд холбогдсон орон сууцанд ашигладаг. Дулааны эрчим хүчний ашиглалтын хугацаа 9-р сараас 5-р сарыг хүртэл үргэлжилдэг бөгөөд түүний хэрэглээ нь тухайн орон байрны халаалтын талбайгаас хамаарна. Орон сууцны өрх ихэнхдээ тохируулах боломжгүй дулаалцуулгын системийг ашиглаж байна. Цаашид түүнийг хэрэглэгч тохируулдаг болгох, түүний үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд эрчим хүчний байгууллагууд тодорхой ажлуудыг хийж байгаа бөгөөд энэ тухай хойно дахин ярилцах болно.

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 40.5 хувь гэрт, 39.5 хувь галлагаатай байшинд амьдарч байгаа бөгөөд тэд түлшийг /мод, нүүрс, аргал, бусад шатах материал/ хоол унд бэлтгэх, гэр орноо дулаалцуулахад ашиглаж байна. Гэр хорооллын өрх зун, намар, хаврын улиралд мод, аргал, хөрсөн зэргийг ердийн зууханд, харин өвлийн улиралд ердийн пийшинд нүүрсийг түлэх нь нийтлэг ажээ. Улаанбаатар хотын гэр хороололд нүүрсний хэрэглээ их байгаа нь агаарын болон орчны бохирдлыг ихэсгэдэг ажээ. Гэр хорооллын өрхийн халаалтын түвшин орон сууцны өрхийнхөөс доогуур байна.

Өрх усыг унд хоол бэлтгэх, гэр орон, хувцсаа цэвэрлэх зорилгоор голлон ашиглаж байна. Гэр хорооллын айл өрхүүд зуны цагт хүнсний ногоогоо гол, булаг шандын усыг зөөж усалдаг ажээ.

Гэр болон орон сууцны хорооллын ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний дэд бүтэц, хэрэглээний түвшин өөр өөр байна. Орон сууцны хувьд ахуйн хэрэглээний дэд бүтэц боловсронгуй, хэрэглээний түвшин, чанар хэрэглэгчдийн ая тухтай байдлыг илүү хангадаг байна. Ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн нь өрхийн гишүүдийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөрийн чадвар, бүтээмж, мэдлэг, танин мэдэхүйн хөгжил, төлөвшилтөнд нөлөөлөх бөгөөд хэрэглээний түвшин нь өрхийн орлогоос ихээхэн хамааралтай болохыг судалгааны ерөнхий үр дүн харуулж байна. Эдгээр бүтээгдэхүүний хэрэглээ нөлөөллийн талаар дараагийн хэсэгт нарийвчлан ярилцъя.



### 3.2 Ахуйн хэрэглээний зарим бүтээгдэхүүний хэрэглээ

Өрхийн цахилгаан, дулааны эрчим хүч, түлш, усны хэрэглээний тоо хэмжээ, ашиглалтын байдал, түүнийг бэлтгэн нийлүүлэхтэй холбоотой асуудлыг асуулгын үр дүн болон өмнө энэ сэдвийн хүрээнд хийгдсэн судалгаануудыг ашиглан судаллаа.

#### **Түлшний хэрэглээ**

Гэр хороололд амьдардаг өрх жилд дунджаар халаалт, хоол унд бэлтгэхэд 30 Гдж дулааны энерги гаргах 4 тонн нүүрс, 2.5 тонн мод хэрэглэдэг байна. Өрхийн ашиглаж буй түлшний АҮК<sup>16</sup> нь дөнгөж 25 – 35% тай байна.<sup>17</sup>

Өрхийн түлшний хэрэглээ орон байрны төрөл, хэмжээнээс гадна тухайн өрх байнга хүнтэй байдаг эсэхээс ихээхэн хамаарч байв. Орон байрны хувьд галлагаатай байшин нь гэрээс илүү түлш зарцуулдаг ажээ. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 96 хувь ердийн болон хананы зуух пийшин, дөнгөж 1.3 хувь дулааны хэмнэлттэй зуух ашигладаг гэжээ. Эдгээр өрхийн 88 - 90 хувь мод, нүүрсийг голдуу түлшинд ашиглаж байхад 8.8 хувь цаас болон бусад шатах материалыг ашиглаж байна. Ихэнх өрхийн хувьд халаалт хангалтгүй гэж хариулсан байв. Үүний шалтгааныг түлшний дулаан гаргах чадвар, хүрэлцээ зэрэгтэй холбон тайлбарлахаас гадна гэр, галлагаатай байшингуудын дулааны алдагдал их гэж өгүүлж байв.

Гэр хороололд түлшийг худалдан авах зардлаас гадна түүнийг түлшинд бэлтгэхтэй холбоотой хөдөлмөр зарцуулалт чухал нөлөөтэй юм. Гэхдээ түүнийг мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжгүй байдаг. ҮСГ-аас явуулсан “Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан”-д мод, түлээ бэлтгэхэд өрхийн 5-аас дээш насны гишүүд оролцож байна. Түүнчлэн улсын хэмжээнд дөрвөн хүн тутмын нэг нь 10-19 цагийг гэрийн ажил хийхэд зарцуулдаг гэжээ<sup>18</sup>. Харин “Ядуу өрхийн амьжиргаанд үзүүлэх ахуйн хэрэглээний үнийн нөлөөлөл” судалгаагаар өрхийн гишүүдийн аль боломжтой нь түлшээ бэлтгэх бөгөөд энэ үйл ажиллагаанд 30 минутаас 2 цагийг зарцуулж байгаа үр дүн гарч байна.

Улаанбаатар хотын гэр хорооллын амьдрах орчны судалгаанд хамрагдсан өрхийн 51 хувь өвлийн улиралд урьдчилан нөөцөлдөг, 29 хувь үнэ өндөр байдгаас долоо хоногт 1–ээс дээш удаа 30-50 кг-аар худалдан авдаг гэжээ. Одоогийн судалгаанд хамрагдсан нийт өрхийн 75.6 хувь жижиглэнгээр, 13.8 хувь хорооны тусламжаар, 4.3 хувь түлээ, нүүрсний

<sup>16</sup> Ашигт Үйлийн Коэффициент

<sup>17</sup> Монгол улсын эрчим хүчний салбарын тогтвортой хөгжлийн стратегид [2003-2010] оруулах хувь нэмэр”, АНУ-ын ОУХА, ЭЗБДТөсөл. УБ 2002, хуудас [341].

<sup>18</sup> Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан, ҮСГ. Улаанбаатар, 2004, хуудас [37].


төвлөрсөн захаас, 1.9 хувь уулнаас, 2.5 хувь хог, цаас түүх хэлбэрээр түлш бэлтгэдэг гэжээ. Бөөний болон жижиглэнгийн зах зээлээс түлшээ бэлтгэж байгаа өрхүүдийн 65.6 хувь бага хэмжээгээр, 18.5 нэгээс хоёр удаа бөөнд нь, 3 хувь нь өрхүүд хамтран худалдаж авсан байна. Гэр хорооллын нэг өрх сард дунджаар 25 кг багтаамжтай 10 шуудай мод, 10 шуудай нүүрс хэрэглэж байна.

Өрхийн түлшний хэрэглээ, түүнд зарцуулж буй хөдөлмөр зарцуулалт, ашиглаж байгаа байдал, бэлтгэн нийлүүлж байгаа хэлбэр зэргийн хувьд өмнө хийгдэж байсан судалгааны үр дүн нь ойролцоо байна. Гэр хороололд ашиглаж байгаа зуух, пийшин нь ихэнхдээ түлшний зарцуулалт ихтэй, байгаль орчин сөрөг нөлөө ихтэй байна. Түүнчлэн эдгээрийг ашиглахтай холбоотой хөдөлмөр зарцуулалт өндөр байна. Түлшний зарцуулалтад орон байрны дулааны хэмнэлт муу байгаа нь нөлөөлж байна гэж үзэж болохоор байна.

### Усны хэрэглээ

Гэр хороололд гүний, төвлөрсөн сүлжээнд холбогдсон болон машинаар тээвэрлэн худагаар ундны усны хэрэгцээг хангаж байна. “Улаанбаатар хотын ядуурал ба шилжилт хөдөлгөөн судалгаа”-ны тайланд хамрагдсан 1500 өрхийн 44.3 хувь орон сууцны өрх буюу төвлөрсөн системээр, 45.7 хувь хамгаалалттай худгаас, 3.4 хувь хамгаалалтгүй худгаас, 6.6 хувь нь бусад эх үүсвэрээс ундны усаа хангадаг гэжээ. Гэр хороололд амьдардаг өрхүүд ундны усны эх үүсвэрээс дунджаар 358.5 м зайд алслагдан амьдарч байна. Улаанбаатар хотын нийт хүн амын 42.5 хувь нь гэр хороололд оршин сууж, зөөврийн 283 худгаар дамжуулан ундны усны хэрэгцээгээ хангадаг ажээ<sup>19</sup>.

**Зураг 3.1 Гэр хорооллын хэрэглээний усан хангамж /хувиар/**



ҮСГ-аас явуулсан “Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан”-д ус авахад өрхийн 5-аас дээш насны хүмүүс оролцож байгаа бөгөөд нийт хүн амын 43.1 хувь оролцдог гэсэн дүгнэлтийг хийсэн байна. Улаанбаатар хотын

<sup>19</sup> УСАГ-ын 2003 оны тайлан мэдээ

гэр хорооллын амьдрах орчны судалгаанд хамрагдсан өрхийн 50 хувь долоо хоногт 2-3 удаа, 38 хувь өдөр бүр ус зөөдөг гэжээ. Нэг удаа ус зөөхдөө дунджаар 20-40 л ус авдаг байна.

Манай судалгаанд хамрагдсан гэр хорооллын өрх сард дунджаар 1450 л усыг ахуйн хэрэгцээндээ ашиглаж байна. Тэдгээр өрхүүдийн хувьд нэгээс хоёр цаг дугаарлан зогсож байж ус авдаг, заримдаа усгүй хонох ч тохиолдол байдаг гэжээ. Мөн хуучирсан нийтийн байруудад халуун, хүйтэн усны төвлөрсөн сүлжээ байхгүйгээс ундны усны гачигдалд гэр хорооллын нэгэн адил ордог ажээ. Тэдгээр өрхүүдийн хувьд бохир систем, хог зайлуулах асуудал ч эрүүл ахуйн наад захын стандартыг хангадаггүй байна. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 20 хувь халуун усны газарт, 53.9 хувь гэртээ, 17.8 орон сууцанд амьдардаг хамаатан садангийндаа, 3.3 хувь усанд ордоггүй, 0.6 хувь зун голын усанд ордог гэж хариулсан байв.

### **Дулааны эрчим хүчний хэрэглээ**

“Ядуу өрхийн амьжиргаанд үзүүлэх ахуйн хэрэглээний үнийн нөлөөлөл” судалгаанд хамрагдсан өрхийн 80 гаруй хувь нь ердийн халаалттай гэр хорооллын өрхүүд байв. Үлдсэн хувь нь төвлөрсөн халаалтын системд холбогдсон байна. Төвлөрсөн халаалттай өрхүүдийн орон байрны дулааны түвшин гэр хорооллын өрхөөс илүү байна. Энэ тухай гэр хорооллын өрхийн халаалт, түлшний хэрэглээний талаар ярилцахдаа тайлбарласан билээ.

Орон сууцны өрхийн хувьд халаалтын төвлөрсөн болон төвлөрсөн бус системийг ашиглах бөгөөд Улаанбаатар, төв суурин газруудад дулааны төвлөрсөн системийг түлхүү ашигладаг /хүснэгт 3.2-оос харна уу/.

#### **Хүснэгт 3.2 Монгол улс дахь дулааны хангамж (хувиар)**

	Төвийн дулааны шугам	Нам даралтын зуух	Гэрийн зуух
Суурин газар	54.7	12.1	33.2
Хөдөө	2.5	13.0	84.5
Улаанбаатар	60.4	8.6	31.0
Нийт	44.3	12.3	43.4

Эх сурвалж: Д. Оюунцэцэг, “Дулааны хангамж: үр ашигтай зуух нэвтрүүлэх төсөл”, 2002 оны 3 дугаар сар.

Өмнө хийгдсэн судалгаануудад орон сууцны өрхийн дулааны хэрэглээ нь тухайн өрхийн орон байрны халаалтын талбайгаас хамаарна. Орон сууцны дулааны хэрэглээ, түүний зардлын багасгах зорилгоор дулааны хэмжүүр айл өрхөд тавих, орон сууцны дулааны алдагдлыг бууруулах арга хэмжээг эрчим хүчний байгууллагууд санаачлан хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай.

### Цахилгаан эрчим хүчний хэрэглээ

Улаанбаатар хотын эрчим хүч хэрэглэгчдийн судалгаагаар өрхийн цахилгаан эрчим хүчний сарын дундаж хэрэглээ орон сууцны өрхөд 191.4 квт, гэр хорооллын өрхөд 139.3 квт байв<sup>20</sup>. Эдгээр өрхийн 60 орчим хувь 2-3 төрлийн цахилгаан хэрэгсэл /хөргөгч, телевиз, цахилгаан зуух/ ашиглах бөгөөд өрхийн орлого буурах тусам цахилгаан эрчим хүчний өрөнд илүү өртдөг гэжээ. Мөн Улаанбаатар хотын хэмжээнд нийт 8500 орчим өрх цахилгаан эрчим хүчээр хангагдаагүйгээс гадна өртэй, төлбөрийн чадваргүйн улмаас цахилгаан эрчим хүч ашиглах боломжгүй ядуу өрхүүд байна гэжээ.

“Ядуу өрхийн амьжиргаанд үзүүлэх ахуйн хэрэглээний үнийн нөлөөлөл” судалгаагаар нийт өрхийн 12.5 хувь цахилгаан эрчим хүчээр хангагдаагүй байгаа талаар өмнө өгүүлсэн. Эдгээр өрх цахилгаан эрчим хүчээр хангагдаж чадахгүй байгаа шалтгаанаа техникийн нөхцөл бүрдээгүй, хязгаарлалт хийгдсэн, төлбөрийн чадваргүй гэж тодорхойлсон байна. Судалгаанд хамрагдсан цахилгаан эрчим хүчийг ашиглаж байгаа өрх сард дунджаар 100 квт цахилгааны эрчим хүч хэрэглэж байв. Мөн эдгээр өрхийн 50 гаруй хувь 2-3 төрлийн цахилгаан хэрэгслийг амьжиргаандаа ашиглаж байна. Цахилгаан эрчим хүчийг нийт өрхийн 52.6 хувь гэрэлтүүлэгт, 44.9 гэр ахуйн хэрэгцээгээ хангахад ашигладаг ажээ.

### 3.3 Хэрэглээн дэх улирлын нөлөөлөл

Ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний хэрэглээнд улирлын нөлөөлөл их байна. “Ядуу өрхийн амьжиргаанд үзүүлэх ахуйн хэрэглээний үнийн нөлөөлөл” судалгаанд улирлын нөлөөллийг тодорхойлсон байдлыг Хүснэгт 3.3-аас харна уу. Дулааны болон түлшний эрэлт нь өвлийн улиралд эрс нэмэгддэг. Үүнийг Монгол улсад байгаль цаг уурын онцлогоос хамааран орон байрыг дулаалцуулах хэрэгцээ нэмэгддэгтэй холбон тайлбарлаж болно.

**Хүснэгт 3.3 Ахуйн хэрэглээний улирлын нөлөөлөл**

	Цахилгаан	Түлш	Ус
Хавар	Дундаас дээгүүр	Дунд зэрэг	Дунд зэрэг
Намар	Дунд зэрэг	Дунд зэрэг	Дунд зэрэг
Өвөл	Хамгийн бага	Хамгийн их	Дунд зэрэг
Зун	Хамгийн их	Хамгийн бага	Хамгийн их

<sup>20</sup> “Улаанбаатар хотын эрчим хүч хэрэглэгчид”-ийн судалгаа, НХТ. УБ. 2004, хуудас [35].

Өвлийн улиралд ядуу айл өрхийн хувьд хүнс тэжээлийн хэрэгцээгээ хангахаас илүү амьдрах орчиноо дулаан байлгах нь аюулгүй байдлаа хангах гол хэрэгцээ болдог байна.

### 3.4 Дүгнэлт

“Ядуу өрхийн амьжиргаанд үзүүлэх ахуйн хэрэглээний үнийн нөлөөлөл” судалгаагаар өрхүүд цахилгаан, дулааны эрчим хүч, түлш, усыг ахуйн суурь хэрэглээндээ түлхүү ашиглаж байв.

Нийт өрхийн 96 хувь ердийн болон хананы зуух пийшинд мод, нүүрсийг түлж байна. Мөн эдгээр өрхийн 8.8 хувь цаас болон бусад шатах материалыг түлшинд ашигладаг гэжээ. Гэр хорооллын өрхүүдийн халаалт хангалтгүй гэжээ Гэр хорооллын нэг өрх сард дунджаар 25 кг багтаамжтай 10 шуудай мод, 10 нүүрс шуудай хэрэглэх бөгөөд түлшээ бэлтгэхдээ өрхийн гишүүд 30 минутаас 2 цагийг зарцуулж байна.

Гэр хорооллын болон хуучин нийтийн орон сууцны өрхүүд сард дунджаар 1450 л усыг ахуйн хэрэгцээндээ ашиглах бөгөөд тэдгээр өрхүүд нэгээс хоёр цаг дугаарлан зогсож байж ус авдаг, заримдаа усгүй хонох ч тохиолдол байдаг гэжээ. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 20 хувь халуун усны газарт, 53.9 хувь гэртээ, 17.8 орон сууцанд амьдардаг хамаатан садангийндаа, 3.3 хувь усанд ордоггүй, 0.6 хувь зун голын усанд ордог гэж хариулсан нь усны хязгаарагдмал хэрэглээний түвшинг харуулж байна. Эдгээр өрхийн хувьд бохир систем, хог зайлуулах асуудал ч эрүүл ахуйн наад захын стандартыг хангахгүй байна.

Нийт өрхийн 12.5 цахилгаан эрчим хүчээр хангагдаагүй, үлдсэн өрхүүд сард дунджаар 100 квт цахилгааны эрчим хүч хэрэглэж байв. Цахилгаан эрчим хүчийг ашиглаж байгаа өрхийн 50 гаруй хувь зөвхөн гэрэлтүүлэгт ашигладаг гэжээ.

Өрхийн ахуйн хэрэглээнд улирлын нөлөөлөл их бөгөөд өвлийн улиралд түлшийг илүүтэй дулаалцуулгад ашиглаж байна.



## Бүлэг 4. Ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний үнэ


Ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний зах зээлийн үнэ бүрдэж буй хэлбэр, механизм нь өөр хоорондоо ялгаатай бөгөөд ихэнхдээ эдгээр бүтээгдэхүүний зах зээлийн үнийг нийлүүлэгч тал тодорхойлж байна. Энэ бүлэгт цахилгаан, дулааны эрчим хүч, түлш, усны үнэ, тэдгээрийг тогтоож байгаа арга механизм, үнийн өрхийн амьжиргаанд үзүүлж буй нөлөөллийн талаар дэлгэрүүлж судална.

### 4.1 Цахилгаан эрчим хүчний үнэ тариф

Улаанбаатар хотод ашиглаж буй цахилгааны үнэ нь 1990 оноос хойш эрчим хүчний салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлж байгаатай холбоотойгоор байнга өсөж ирсэн бөгөөд цаашид нийлүүлэгч байгууллагууд хэвийн тогтвортой ажиллах боломжтой нөхцлийг хангах хүртэл өсгөх хандлага ажиглагдаж байна. Үнийн өөрчлөлтийг зураг 4.1-ээс харна уу.

Гэхдээ үнийг өсгөх нь бүх асуудлыг шийдэх гол арга биш гэдэгт бүх талууд санал нэгтэй байдаг бөгөөд салбарын байгууллагуудын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, техникийн алдагдлыг бууруулах, орчин үеийн хэмнэлттэй тоног төхөөрөмжийг өргөнөөр ашиглах зэрэг олон аргыг зэрэг ашиглахыг зорьж байгаа талаар уулзалт ярилцлагад оролцогчид өгүүлж байв. Энэ талаар дараагийн бүлэгт дэлгэрэнгүй ярилцах болно.

**Зураг 4.1 Төвийн бүсийн цахилгааны үнийн өсөлт /ЭХЗГазар/**



Эрчим хүчний үнэ тарифыг тодорхойлоход баримтлах зарчмыг ЭХЗГ-ийн Зохицуулагчдын зөвлөлийн 2001 онд гаргасан “Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үнэ, тарифыг тооцох түр аргачлал”-д дараах байдлаар тодорхойлсон:

- Үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орлого нь түүний санхүүгийн чадавх хэвийн байлгахуйц хэмжээнд байх;
- Эрчим хүч үйлдвэрлэх дамжуулах, түгээх, хангах, диспетчерийн зохицуулалт хийх үйл ажиллагаанд техник, технологийн найдвартай ажиллагааны шаардлагад нийцүүлэн хамгийн бага өртгийн зарчмыг мөрдөх;
- Өртөг нь сүүлийн жилүүдэд гарсан зардлын гүйцэтгэлд үндэслэгдсэн байх бөгөөд зардлын бүтцэд ирээдүйд оруулах хөрөнгө оруулалт, шинэчлэлийн зардалд бодогдох элэгдэл, хорогдлыг оруулахгүй байх;
- Санхүүжилтийн эх үүсвэр нь Засгийн газрын эрх бүхий байгууллагаар баталгаажсан нөхцөлд татаасыг тарифын тооцоонд оруулж тооцох;
- Бүтээгдэхүүн ба ажил үйлчилгээний үнэ тариф тооцох зардалд тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаанд хамааралгүй бүх төрлийн шагнал урамшуулал тэтгэмж, бусдад өгсөн хандив, бэлэг дурсгал, хүлээн авалт, туслах аж ахуй, амралт, сувилал, гуанз, цайны газар зэрэг үйлдвэрлэлийн бус үйлчилгээний зардлыг оруулахгүй байх;

Тариф /Г/-ыг тооцохдоо борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ /БОш/-ээс Засгийн газрын эрх бүхий байгууллагаар баталгаажсан татаас /ТСо/-ыг /орлого хэлбэрээр/ хасаж үйлчилгээний биет хэмжээ /Үб.х/-нд харьцуулж тодорхойлно. Тарифыг төгрөг мөнгөөр буюу зууны нарийвчлалтайгаар тооцон гаргадаг.

Төвийн бүсийн цахилгаан түгээх сүлжээнүүдээс айл өрхийн хэрэглэгчдэд борлуулах цахилгааны үнийг ЭХЗГ-ийн 2002 оны 9-р сарын 2-ны өдрийн 83 дугаар тогтоолоор тоолуураар тооцох үед 47 төгрөг, тоолуургүй нөхцөлд болон цагийн ялгавартай тарифыг /хэдий цагийн ялгаварт тариф байдаг ч электрон тоолуургүйгээс ялгаатай тооцох боломж ялангуяа гэр хорооллын айл өрхөд байдаггүй тэд ихэвчлэн хуучны орос загварын тоолуур ашигладаг/ дараах байдлаар тогтоон мөрдөж байна /хүснэгт 4.1, 4.2-оос хуучин үнэ, тарифыг харна уу/.



Харин 2005 оны 2-р сарын 14-ний өдрөөс эхлэн цахилгаан эрчим хүчний шинэ үнэ тарифыг мөрдөж байна. Энэ тариф нь өмнөхөөсөө дараах онцлогтой /хүснэгт 4.1 болон 4.2–оос харна уу/. Үүнд:

- Орон сууц болон гэр хорооллын цахилгаан эрчим хүчний үнийг ялгаатай тогтоосон;
- 2 болон 3 тарифт тоолууруудын үнийг тодорхойлсон;
- Эмзэг бүлгийн хэрэглэгчдийн цахилгааны үнийг хязгаарлалттайгаар тогтоосон зэрэг болно.

#### Хүснэгт 4.1 Ахуйн хэрэгцээнд тоолуургүй нөхцөлд мөрдөх үнэ, тариф /НӨАТ-гүй/

Тоолуургүй нөхцөлд /НӨАТ-гүй/		Айл өрхөд		ТҮЦ, гараж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг айл өрхөд
Ангилал	Хэмжих нэгж	Хуучин үнэ	Шинэ үнэ	Шинэ үнэ
Залгуур /1 шир/	төг/сард	15236	8266	16531
Гэрлийн шил /шир/				
25 Вт	төг/сард	286	310	621
40 Вт	төг/сард	466	506	1011
60 Вт	төг/сард	709	769	1539
75 Вт	төг/сард	892	968	1936
100 Вт	төг/сард	1177	1277	2554
150 Вт	төг/сард	1763	1913	3826
200 Вт	төг/сард	2355	2555	5110
500 Вт	төг/сард	5891	6392	12783
1000 Вт	төг/сард	11909	12921	25843

Ялгаварт тариф /НӨАТ-гүй/					
Ангилал	Цагийн ялгаа	Хэмжих нэгж	Хуучин үнэ	Цагийн ялгаа	Шинэ үнэ
Өдрийн хэрэглээ	06. <sup>00</sup> - 22. <sup>00</sup>	төг/квтц	47	06. <sup>00</sup> - 21. <sup>00</sup>	51
Орой, шөнийн хэрэглээ	22. <sup>00</sup> - 06. <sup>00</sup>	төг/квтц	4.7	21. <sup>00</sup> - 06. <sup>00</sup>	11.3

ЭХЗГазрын Зохицуулагчдын зөвлөлийн 2005 оны 6 дугаар тогтоолын хавсралт

Гэр хорооллын ядуу өрхүүдийн дийлэнх хувь нь электрон тоолуургүйн улмаас цахилгаан эрчим хүч ашигласан өрөнд орж байна гэсэн дүгнэлт өмнө энэ чиглэлээр хийгдсэн судалгаа явцад хийгдсэн агаад энэ судалгаагаар дахин сөхөгдсөн билээ. Тоолуургүй өрх цахилгаан зуух болон 60 Вт-ын чийдэнг бүтэн нэг сар хэрэглэхэд 18070 төгрөг төлнө. Энэ нь тоолууртай өрх сард 100 квт цахилгаан эрчим хүч хэрэглэхэд төлөх 4880 төгрөгөөс даруй 3.7 дахин их байна. Иймд ядуу өрхийг тоолуураар хангах, тоолуурыг баталгаажуулах, эвдэрсэн нөхцөлд үнэ төлбөргүй засварлах үйлчилгээнүүдийг нэвтрүүлэх тэдгээр өрхийн амьжиргаанд бодитой дэмжлэг болох магадлалтай. Ядуу өрхийг нийтэд нь тоолуураар хангах асуудал нилээд их хөрөнгө, цаг хугацаа шаардагдана. Харин тоолууртай айл өрхөд шаардлагатай үйлчилгээг хөнгөлөлттэй нөхцлөөр үйлчилгээ үзүүлэх асуудлыг юуны өмнө зохион байгуулж болно.

Мөн эмзэг бүлгийн хэрэглэгчдийн хязгаарлалттай үнийг ЭХЗГ-аас санаачилж байгаа нь сайшаалтай. Энэхүү тарифыг ашигласнаар орон сууцны ядуу өрх сард хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний төлбөрөөсөө даруй 750 төгрөг хүртэл, гэр хорооллын өрх 588 төгрөг хүртэл чөлөөлүүлэх боломжтой болно. Харин энэ хөнгөлөлтийг авахын тулд өрхөөс, түүнийг тодорхойлохын тулд дүүргийн эрчим хүчний салбараас хичнээн төгрөг зарцуулах шаардлагатай вэ гэсэн асуулт тавигдах нь тодорхой. Энэ зардал нь ямар ч тохиолдолд үзүүлж байгаа хөнгөлөлтөөсөө илүү байж болох юм. Иймд эрчим хүчний салбарын үнийн хөнгөлөлтийн бодлогыг Засгийн газрын нийгмийн хамгааллын бодлоготой уялдуулах замаар шинэ тарифыг мөрдөхөд гарах зардлаа бууруулах, ядуу өрхөд илүү үр өгөөжтэй байх хэлбэрийг цаашид хөгжүүлэх чухал юм.

#### Хүснэгт 4.2 Эмзэг бүлгийн хэрэглэгчдийн цахилгааны үнэ

Д/д	Бүсийн ялгаа	Орон сууц /сарын хэрэглээ квт.ц/	Үнэ /НӨАТ-гүй/ (төг/квт.ц)	Гэр хороолол /сарын хэрэглээ квт.ц/	Үнэ /НӨАТ-гүй/ (төг/квт.ц)
1	Улаанбаатар	75 квт.ц хүртэл	41.00	60 квт.ц хүртэл	39.00
		75 квт.ц-аас дээш	51.00	71 квт.ц-аас дээш	48.80
2	Дархан, Эрдэнэт, Багануур	50 квт.ц хүртэл	41.00	40 квт.ц хүртэл	39.00
		71 квт.ц-аас дээш	51.00	41 квт.ц-аас дээш	48.80
3	Бусад	40 квт.ц хүртэл	41.00	30 квт.ц хүртэл	39.00
		41 квт.ц-аас дээш	51.00	31 квт.ц-аас дээш	48.80

ЭХЗГ-ын Зохицуулагчдын зөвлөл анх удаа Монгол улсад Эмзэг бүлгийн хэрэглэгчдийн цахилгааны үнийг баталж, 2005 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахаар болов.

#### 4.2 Дулааны эрчим хүчний үнэ тариф

Харин ЭХЗГ-ын 2002 оны 10-р сарын 18-ны өдрийн 105 дугаар тогтоолоор хэрэглэгчдэд борлуулах “УБДС” ТӨХК-ний дулааны үнийг дараах байдлаар тогтоон мөрдөж байгаад 2005 оны 2-р сарын 14 өдрөөс мөн шинэчилсэн тарифыг мөрдөх боллоо.

#### Хүснэгт 4.3 Айл өрхийн ахуйн хэрэгцээний дулааны үнэ /НӨАТ-гүй/

Д/д	Ангилал	Хэмжих нэгж	Хуучин үнэ	Шинэ үнэ
1	Орон сууцны дулаацуулга	төг/м <sup>2</sup>	160	191
2	Хэмжүүрээр тооцох дулаан	төг/Гкал	3705	4420
3	Ахуйн хэрэгцээний халуун ус	төг/хүн	520	620


Дулааны эрчим хүчний хэрэглээ нь зөвхөн төвлөрсөн дулааны системд холбогдсон өрхөөр хязгаарлагдаж байдаг. Дулааны эрчим хүчний үнийг

тогтоож буй арга зүй цахилгаан эрчим хүчний үнийг тогтоож буй аргачлалтай үндсэндээ ижил байдаг.

Орон сууцны халаалтын үнэ болон хэрэгцээний халуун усны үнэ нь сүүлийн жилүүдэд байнга өсөж байгаа боловч цаашид салбарын үйлдвэрүүд алдагдалгүй ажиллах түвшинд хүртэл өсгөх чиг барьж байна. Түүнчлэн нефтийн зах зээлийн үнийн өсөлт дулааны эрчим хүчний үнийг өсгөх нэг шалтгаан болж байна. Төвлөрсөн бус сүлжээтэй орон сууцны халаалтын үнийг тухайн халаалтын зуухыг хариуцаж байгаа байгууллага тогтоодог.

Орон сууцны халаалт болон ахуйн хэрэглээний халуун усыг хэмжих үнэ тоолуур айл өрхөд байхгүйгээс өргөн хэмжээнд ашиглаж чаддаггүй. Зураг 4.2-оос төвийн бүсийн ахуйн хэрэгцээний дулааны үнийн өөрчлөлтийн байдлыг харна уу.

**Зураг 4.2 Төвийн бүсийн ахуйн хэрэгцээний дулааны үнийн өөрчлөлт**



### 4.3 Хэрэглээний усны үнэ тариф

Хэрэглэгчдийг үндсэнд нь гурван бүлэгт хувааж үздэг. Үүнд:

- Хүн амд
- Албан газарт
- Тоолууртай орон сууцны байгууллага гэж ангилна.

УСАГ–ын усны тариф нь 2000 оны 7-р сараас мөрдөхөөр батлагдсан тарифыг хүснэгт 4.4-д харууллаа.

**Хүснэгт 4.4 УСАГ-аас түгээх цэвэр ус, татан зайлуулах бохир усны тариф<sup>21</sup>**

Үйлчилгээний төрөл		Хэмжих нэгж	Тариф (төг)	Үүнээс	
				Нөөц	Үйлчилгээ
Цэвэр ус	Албан газар	м <sup>3</sup>	200		200
	Хүн ам	м <sup>3</sup>	181	5	125
	Тоолууртай орон сууцны байгууллага	м <sup>3</sup>	112	5	100
Бохир ус	Гэр хороолол	м <sup>3</sup>	500		
	Албан газар	м <sup>3</sup>	115		115
	Хүн ам	м <sup>3</sup>	105	5	80
	Тоолууртай орон сууцны байгууллага	м <sup>3</sup>	72	5	65

“Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хуульд заасны дагуу түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Дэд бүтцийн сайдын 2003 оны тушаалд үйлчилгээний төлбөрийг тооцох аргачлалыг боловсруулсан байна. Үнэ төлбөрийг төвлөрсөн болон төвлөрсөн бус системийн хувьд ялгаатайгаар зах зээлийн аргачлалын дагуу боловсруулна. Энэхүү аргачлалд тухайн үйлчилгээг үзүүлэх зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагааны сүүлийн гурван жилийн бодит зардлын гүйцэтгэлд тулгуурлан үнэ төлбөрөө тооцож, тухайн харьяа аймаг, нийслэл, сумын Засаг даргатай зөвшилцөх замаар баталж мөрдөхөөр заажээ.

Үйлчилгээний үнэ, тарифын бүтэц нь нэгж бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнд ногдох хөрөнгө оруулалтын өгөөж, үйл ажиллагааны зардлаас бүрдэж байна. Үнэ, тарифыг жил бүр улсын болон орон нутгийн төсөв зохиох үеэр инфляцийн түвшинг харгалзан шинэчлэн тогтоодог.

#### 4.4 Түлшний үнэ тариф

Улаанбаатар хотын нүүрсний хэрэгцээг Багануур, Шивээ-овоо, Шарын голын уурхайнууд хангаж байдаг талаар өмнө өгүүлсэн. Эдгээр компаниуд нь төрийн өмч давамгайлсан хувьцаат компаниуд юм. Эдгээр компанийн нүүрсний борлуулалтын үнийг тухайн компанийн удирдах зөвлөл тогтоож байдаг. 2004 онд баталсан борлуулалтын үнийг Хүснэгт 4.5-д харууллаа.

Ахуйн хэрэглэгчдэд очих түлшний үнэ тээвэрлэлтийн зардлаас шалтгаалан өсөж байдаг. Гэр хорооллын хэрэглэгчид 2003 онд 1 тн нүүрсийг 19000 орчим төгрөгөөр худалдан авч байсан. Үүнийг 2001-2002 оны нүүрсний үнэтэй харьцуулан авч үзвэл буурсан байна.

<sup>21</sup> УСАГ-ын даргын 2000 оны 94-р тушаалын хавсралт

**Хүснэгт 4.5 Шинээр батлагдсан 1т нүүрсний үнэ /3 том уурхайн хэмжээнд/**

Уурхайнууд	Хэмжих нэгж	Хуучин үнэ	Нүүрсний Уурхайнуудын ТУЗөвлөлийн шийдвэрээр 21-47%-иар нэмэгдүүлсэн үнэ	
			Үнийн өсөлт	Шинэ үнэ
Багануурын уурхай	1 тонн	9250	2250	11500
Шивээ-Овоогийн уурхай	1 тонн	5880	1240	7120
Шарынголын уурхай	1 тонн	10000	3650	13650

Гэр хороололд мод, нүүрсийг ахуйн хэрэглээнд түлхүү хэрэглэж байгаа талаар өмнө өгүүлсэн билээ. Модны үнэ зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээр тодорхойлогдох ба зах зээлийн үнэ нь бөөний болон жижиглэнгийн, улирлаар ялгаатай байв.

Нүүрсний бөөний үнийг нүүрс үйлдвэрлэгч компаниудын ТУЗөвлөл тодорхойлж байна Харин нүүрсний ахуйн хэрэглээний буюу жижиглэнгийн үнийг бөөний үнэ-д суурилан тээвэрлэлтийн зай, улирлын нөлөөлөл, зах зээлийн эрэлт нийлүүлэлт, нүүрсний чанар зэргээс шалтгаалан зах зээл тогтоодог. Иймээс нүүрсний бөөний болон жижиглэнгийн үнэ нилээд ялгаатай байна.

**Кейсийн жишээ: Хангай зах дээр түлээ, нүүрсний худалдаа эрхэлж байгаа “ О ”-той хийсэн ярилцлага**

Би зах дээр ирж зардаг хувь хүмүүсээс мод худалдан авдаг. Нүүрсийг ихэнхдээ мөн зах дээрээс авах боловч заримдаа өөрөө нүүрсний уурхайгаас авчирдаг. Бөөнөөр худалдан авсан мод, нүүрсээ хүмүүс хөлслөн бэлтгүүлж шуудайлдаг.

Бөөний үнээр нэг машин модыг 150000 төгрөгөөр, нүүрсийг 130000 төгрөгөөр авдаг. Сүүлийн жилүүдэд мод нүүрсний үнэ ханш их өөрчлөгдөж байна. Өнгөрсөн жил нэг машин нүүрс 80000-90000 төгрөг, мод 130000-150000 төгрөгийн хооронд байв.

Жижиглэнгийн үнийг зах зээл өөрөө тогтоодог, бусад худалдаачидтай ойролцоо үнээр зардаг. Нэг машин нүүрсийг 3 хоногт, модыг 10 гаруй хоногт зардаг. Нэг шуудай модыг 600-700 төгрөгөөр, нүүрсийг 1200-1500 төгрөгний хооронд зарна. Жижиглэнгийн үнэ ханш ойролцоогоор модны хувьд 100-200 төгрөгөөр, нүүрсний хувьд 300-500 төгрөгөөр хэлбэлзэж байна. Өвөл удаан үргэлжлэх нь гүйлгээг нэмэгдүүлж, ханшыг өсгөдөг. Модны үнэ ханш ер нь тогтсон өөрчлөлт багатай. Зундаа ч адилхан ханштай байдаг. Цаг агаар хүйтэн болох тусам нүүрсний үнэ нэмэгдэнэ.

Түлээний модны хувьд чанар чухал биш байдаг, хуурай модыг хүмүүс авах гэдэг. Мэдээж хар мод шаталт, илч сайтай. Харин нүүрсний хувьд чанар, элч сайтай, хуурай, том нүүрс зарах нь чухал. Алдагдал бага байдаг.

Худалдан авагчид голдуу гэр хорооллын иргэд байдаг. Хүмүүс амьжиргааны түвшин, хэрэгцээнээсээ хамааран янз бүрийн хэмжээгээр авч байдаг. Харж байхад боломжтой нэг нь аль болох бөөнөөр авах сонирхолтой байхад, боломж муутай хүмүүс нэг хоёр өдрийн хэрэгцээний түлшээ авч байдаг. Зээлээр худалдаж байгаагүй. Зарж байгаа мод, нүүрснээсээ өөрийн өрхийнхөө хэрэгцээг илүүчлэн хангадаг.

#### **Кейсийн жишээ: “Гялгар” зах дээр түлээ, нүүрсний худалдаа эрхэлж байгаа “М”-тэй хийсэн ярилцлага**

Модыг уулнаас авчирч зардаг худалдаачдаас би бөөнөөр авдаг болохоор шат дамжлага гэх зүйл байхгүй. Ирсэн машинтай модны ачилт, хуурай нойтон байдал зэргээс хамааран үнээ тохиролцоод авдаг. Нэг машин мод 180000 төгрөг байна. Сарын өмнө 200000 төгрөг хүрээд буурч байна.

Бид модыг банзлаж нэг куб.м хар модыг 9000 төгрөг, нарсыг 7000 төгрөгөөр борлуулж байна. Борлуулахдаа ихэвчлэн тохиролцдог. Бөөнөөр зарах үед авсан үнэ дээр 15000-20000 төгрөг нэмдэг. Борлуулалтанд улирлын онцлогоос шалтгаалаад үнийн хэлбэлзэл гардаг. Намар, хавар модны худалдаалах нөөц багасдаг. Түүнээсээ шалтгаалан үнэ нь арай өндөр байдаг.

## **4.5 Үнэ тарифт нөлөөлж буй зарим хүчин зүйлс**

Нефтийн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өөрчлөлт нь цахилгаан, дулааны эрчим хүч, түлш, усны үйлдвэрлэлийн болон тээвэрлэлтийн зардлыг өсгөх гол шалтгаан болгодог талаар зах зээлийн судалгаанд оролцогчид өгүүлсэн.


Мөн ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн, үйлчилгээний нэмүү өртгийн татвар нь нэгжийн үнийг 15 хувиар өсгөж байна. Нэмүү өртгийн татвар тооцсоноор нэг квт цахилгаан эрчим хүч хэрэглэсэн өрх 4.59 мөнгийг нэмж төлнө гэсэн үг. Өрх сард дунджаар 100 квт цахилгаан эрчим хүч хэрэглэдэг гэж тооцоход сардаа 459 төгрөгийг нэмүү өртгийн татвар өгч байна.

Цахилгаан болон дулааны эрчим хүч, ус, түлшний салбарт хийгдэж буй технологийн шинэчлэл нь түүний найдвартай ажиллагаа, бүтээгдэхүүний чанарыг сайжруулж байгаа боловч өртгийг нэмэгдүүлэх нэг шалтгаан болж байна.

Ядуу өрхийн хувьд тоолуургүй байх, ашиглаж буй цахилгаан хэрэгслийн тоо цөөн байх, ашиглаж буй цахилгаан хэрэгсэл цахилгааны зарцуулалт ихтэй, гар хийцийн хэрэгсэл ихэнхдээ ашиглаж байгаа нь

цахилгааны нийт төлбөрийг ихэсгэх шалтгаан болдог. Улаанбаатар хотын эрчим хүч хэрэглэгчдийн судалгаанд хамрагдсан тоолуургүй нийт өрхийн 69.2 хувь гэр хорооллын, тэдний 74.8 хувь нь цахилгаан эрчим хүч ашигласан төлбөрийн өртэй өрх байв. Дээрх өрхүүд тоолуургүйн улмаас тоолууртай өрхөөс хоёр дахин бага хэрэглэж, хоёр дахин их төлдөг талаар өмнө тайлбарласан билээ.

**Зураг 4.3 Өрхийн ашиглаж буй зуухны төрөл /хувиар/**



Гэр хорооллын хувьд өрхийн ашиглаж буй зуух, пийшингийн төрөл хийц, загвараас өрхийн түлшний хэрэглээ хамаарч байдаг. Энэ утгаараа түлшний нийт төлбөрт нөлөөлнө. Судалгаанд хамрагдсан ил

зуух ашигладаг өрхийн дийлэнх хувь ердийн зуух ашиглаж байна.


Мөн үйлчилгээг хүргэж байгаа байгууллагуудын бүртгэл, мэдээллийн үйлчилгээтэй холбоотой нэмэлт төлбөрүүд ч нөлөөлнө.

#### **4.6 Өрхийн амьжиргаанд ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний үнийн үзүүлж буй нөлөөлөл**

Өрхийн амьжиргаанд ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний нэгжийн үнээс илүү нийт төлбөрийн хэмжээ нөлөөтэй. Бүтээгдэхүүний үнийн талаар өмнө нэлээд дэлгэрэнгүй ярилцсан. Бүтээгдэхүүний үнэд тухайн бүтээгдэхүүний үнээс гадна дагалдах хэрэгсэл, ажил үйлчилгээний зардал хамрагдаж байдаг. Иймээс өрх тодорхой бүтээгдэхүүний үнийн тухай ярихдаа үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс гадна дагалдах ажил үйлчилгээний зардлыг хамт тооцон үзсэн нийт төлбөрийг авч үзэх нь нийтлэг байна.

Судалгаанд оролцсон нийт өрхийн 61 хувь нь цахилгаан, дулаан, түлш, усны төлбөр өрхийн амьжиргаанд нөлөөлж байна гэж хариулсан бол нийт өрхийн 40.2 хувь цахилгаан эрчим хүч, 49.5 хувь дулаан, түлш, 4.7 хувь усан хангамжийг өрхийн амьжиргаанд хамгийн их нөлөө үзүүлж байна гэжээ.

**Зураг 4.4 Өрхийн амьжиргаанд үзүүлэх үнэ тарифын нөлөөлөл /хувиар/**




**Цахилгаан эрчим хүчний үнийн нөлөөлөл**

Цахилгаан эрчим хүчний төлбөрийн нөлөөлөл нь өрхийн амьдарч буй орон байрны төрлөөс хамааран бага зэрэг ялгаатай байна. Гэр, галлагаатай байшинд амьдарч байгаа өрхийн 80 орчим хувь, орон сууцны өрхийн 90 орчим хувь, зориулалтын бус байранд амьдарч байгаа өрхийн 70 орчим хувь цахилгаан эрчим хүч өрхийн амьжиргаанд маш их буюу их нөлөөлж байна гэжээ. Сүүлийн хоёр жилд ахуйн хэрэглээний нэг квт цахилгаан эрчим хүчний үнэ өөрчлөгдөөгүй ч түүнийг ашиглахтай холбоотой ажил үйлчилгээний зардал нэмэгдсэн, өрхийн тогтмол орлого багассан нь нөлөөлжээ.

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 28.6 хувь эрчим хүчний хэрэглээ хязгаарлагддаг, 60.7 хувь өр төлбөр үүсдэг, 7.1 хувь бусад хэрэгцээ хязгаарлах шаардлагатай болдог, 3.6 хувь амьжиргаа доройтох шууд шалтгаан болдог гэсэн байна. Эдгээр нөлөөллийн талаар авч үзье:

**Зураг 4.5 Өрхийн амьжиргаанд үзүүлэх цахилгаан эрчим хүчний төлбөрийн шууд нөлөөлөл /хувиар/**





Өрхүүд цахилгаан эрчим хүчний төлбөр нэмэгдсэнээр хамгийн түрүүнд цахилгаан эрчим хүчний хэрэглээгээ хязгаарладаг ажээ. Өрхүүд өвлийн цагт хөргөгчөө ажиллуулахгүй байх, ил гал дээр хоол ундаа хийх, мөн хийн түлш ашиглах зэрэг арга хэмжээг авчээ. Түүнчлэн цахилгаан эрчим хүчээ хэмнэх үүднээс зурагт үзэх цагаа багасгах, оройн цагаар хүүхдүүд хичээл давтах хугацааг багасгадаг байна.

Цахилгаан эрчим хүчний төлбөр нэмэгдсэнээс шалтгаалан ашигласан төлбөрөө төлж чадахгүй өрөнд ордог байна. Цахилгаан эрчим хүчний төлбөр нэмэгдэх нэг шалтгааныг тухайн газар нутгийг хариуцсан эрчим хүчний байцаагчийн үйл ажиллагаатай холбоотой тайлбарлаж байв. Тодруулбал, өрхийн тоолуурын баталгаат хугацаа дууссан, өртэй гэсэн шалтгаанаар цахилгаан эрчим хүчний төлбөрийг задгай тарифаар бичих, төлбөрийг сар бүр хэрэглэсэн хэмжээгээр нь бичихгүй хуримтлуулж байж бичих зэрэг нь өрхөд нөлөөлдөг байна.

Мөн баяр ёслол болох, өрхийн гишүүдийн цалин хөлс цаг хугацаандаа буухгүй байх, өрхийн аль нэг гишүүн гэнэт хүнд өвчин тусах зэрэг өрх цахилгаан эрчим хүчний төлбөрөө төлж чадахгүй өрөнд ороход нөлөөлөх тохиолдол байна. Урьд өмнө хийгдсэн судалгаануудад ч цахилгаан эрчим хүчийг тоолуургүйгээр ашиглаж байгаа өрхүүд ихэнхдээ ядуу, нэн ядуу амьжиргааны түвшинтэй байгааг тэмдэглэсэн байна.

Цахилгаан эрчим хүчний төлбөрийг цаг хугацаанд бичихгүй байх, тоолуур ашиглахгүй байх нь эрчим хүчний байгууллагын үйлчилгээтэй холбоотой асуудал юм. Мөн өрхийн байнгын орлогын хэмжээг нэмэгдүүлэх, тогтворжуулах асуудал эрчим хүчний төлбөртэй холбоотой байна. Эрчим хүчний төлбөрийн өр үүсэх, цахилгаан эрчим хүчний хэрэглээгээ хязгаарлах нь өрхийн амьжиргаанд сөрөг үр дагавартай байна.

### ***Түлшний болон дулааны үнийн нөлөөлөл***


Судалгаанд хамрагдсан өрхүүд түлшний болон дулааны үнийн нөлөөлөл маш өндөр байдаг гэж үзжээ. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 40.5 хувь өр тавих замаар хэрэглээгээ хангадаг, 29.5 хувь хэрэглээндээ хязгаарлалт хийдэг, 10.5 хувь өөр шатах боломжтой орлуулах бүтээгдэхүүнийг ашигладаг, 3 хувь бусад хэрэгцээгээ бууруулдаг гэж хариулсан байна. Мөн огт галгүй амьдардаг гэж хариулсан өрх ч байна. Эдгээр нөлөөллийн талаар дэлгэрүүлж ярилцъя.

Өвлийн улиралд өрхийн түлшний хэрэглээ нэмэгддэг ажээ. Энэ нь зах зээлд түлшний үнэ нэмэгдэх нэг шалтгаан болно. Иймд айл өрх ах дүү, хамаатан садан, хөршөөсөө түлш болон түлш худалдан авах зорилгоор зээл авах нь элбэг гэжээ. Учир нь түлшний бэлтгэн нийлүүлэлт нь зах зээлийн харилцаанд шилжсэн учраас түлшийг зөвхөн бэлэн мөнгөөр худалдан авах боломжтой. Энэ нь цахилгаан эрчим хүч, түлшний нийлүүлэлт хоёрын

хооронд байгаа нэг гол ялгаа ажээ. Амьжиргаа боломжтой өрхүүд зун, намрын улиралд түлшийг хямд үнээр нөөцөлж авдаг байна.

Түлшний үнийн өсөлтийн эсрэг өрхөөс авч байдаг өөр нэг арга нь хэрэглээгээ хязгаарлах явдал юм. Айл өрхүүд түлшинд зарцуулж байгаа зардлаа хязгаарласнаар өрхийн халаалт хэвийн хэмжээнээс ихээхэн буурдаг ажээ. Судалгаанд хамрагдсан гэр хорооллын өрхүүд өвлийн улиралд өрхийн халаалтын байдал дунд зэрэг, хүйтэвтэр, хүйтэн байдаг гэж 80 гаруй хувь хариулсан нь үүнийг нотолж байна.

**Зураг 4.6 Халаалт дулааны төлбөр өрхийн гишүүдийн амьжиргаанд нөлөөлсөн байдал /хувиар/**



Түлшний үнэ нэмэгдсэнээр ядуу өрх шатах боломжтой өөр хямд орлуулах бүтээгдэхүүнийг хайж эхэлдэг ажээ. Үүнд: уулнаас мод түүх, аргал, картон, хуучин хувцас зэргийг ашигладаг. Зориулалтын бус шатах материал ашиглах нь нэмэгдсэнээр хотын бохирдолд шууд нөлөөлдөг. Түүнчлэн бусад айл хөрш, албан байгууллага, галт тэрэг зэргээс мод, нүүрсийг хулгайлах замаар ашигладаг. Өвлийн улиралд ядуу өрхөд нийгмийн халамжийн байгууллагаас өгч байгаа нүүрс модны тусламж нь ач холбогдолтой зүйл юм. Гэхдээ агаарын болон орчны бохирдлыг нэмэгдүүлэх нь тодорхой.

Зарим өрхүүд түлшний үнийн өсөлтийг даван туулах аргагүйгээс шалтгаалан галгүй орчинд амьдрах, зориулалтын бус орон байранд шилжин амьдардаг ажээ (Траншей, байрны подваль).

Өрхөд түлшний нөлөөлөл өвлийн улиралд хамгийн их байна. Гэр орон дулаан байх асуудал нь өрхийн хувьд аюулгүй байдлын хэрэгцээгээ хангах, улмаар өрхийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөрийн бүтээмжинд эерэг нөлөө үзүүлдэг байна.

### **Усан хангамжийн үнийн нөлөөлөл**

Гэр хороололд усан хангамж өрхөд үзүүлэх эдийн засгийн нөлөө бага гэж судалгаанд хамрагдсан өрхийн ихэнх нь хариулжээ. Орон сууцны өрх нь ахуйн хэрэглээний халуун, хүйтэн ус болон бохир ус зайлуулах төвлөрсөн системийг ашиглаж байдаг учир үнийн өөрчлөлт нь өрхийн амьжиргаанд нөлөөлнө гэжээ.

Гэр хорооллын өрхийн хувьд усны үнийн өөрчлөлт нь гол, булаг шандны ус ашиглах сонирхлыг нэмэгдүүлдэг болохыг кейсийн болон оролцооны аргын судалгаанд оролцогчид өгүүлж байв.

Гэр хорооллолд цэвэр, бохир усны дэд бүтцийг хөгжүүлэх асуудал нь Улаанбаатар хотын хөгжил, хүн амын амьжиргааны түвшин, чанарыг сайжруулахтай шууд холбоотой асуудал юм. Энэ нь өрхийн усны хэрэглээ төлбөрийг нэмэгдүүлэх боловч бусад зардлыг бууруулах нөхцөл болно гэж судалгаанд оролцогчид үзэж байв.

## **4.7 Дүгнэлт**

Ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний зах зээлийн үнэ бүрдэж буй хэлбэр, механизм нь өөр хоорондоо ялгаатай ажээ. Ахуйн хэрэглээний үнийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх үйл явц үргэлжилж байна. Цахилгаан, дулаан болон усан хангамжийн үнийн зохицуулалтад төрийн хяналт байгаа ч мэргэжлийн бие даасан байгууллага асуудлыг хариуцах боллоо. Түлшний үнэ үндсэндээ зах зээлийн эрэлт нийлүүлэлтээр зохицуулагдаж байна. Ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний үнэ нь сүүлийн арав гаруй жил өсөж ирлээ. Үүний шалтгаан нь үнийг зах зээлийн буюу олон улсын жишигт ойртуулах, салбарын шинэчлэлттэй холбоотойгоор өртөг нэмэгдэх, нефть бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өөрчлөлт, нэмүү өртгийн татвар зэрэг олон хүчин зүйлээс хамаарч байна.

Цахилгаан, дулааны эрчим хүчний үнийг 2001 оноос эхлэн ЭХЗГ-ийн Зохицуулагчдын зөвлөлийн баталсан журмын дагуу ахуйн хэрэглэгчдийн эрчим хүчний үнийг 2 удаа өөрчлөн тогтоожээ. Хамгийн сүүлд 2005 оны 2-р сард шинэчилсэн бөгөөд энэхүү шинэ үнэ тариф нь өмнөхөөсөө хэд хэдэн онцлогтой байна. Шинэ үнэ тарифыг тогтоохдоо анх удаа гэр болон орон сууцны, мөн эмзэг бүлгийн иргэдэд зориулсан ялгаатай үнийг тогтоов. Энэ санаачлага нь эрчим хүчний салбарынхны хувьд хэрэглэгчид хандсан үйлчилгээг хөгжүүлж байгаа нэг алхам билээ. Цаашид үнийн энэ бодлогоо төрийн нийгмийн хамгааллын бодлогуудтай уялдуулах нь илүү үр ашигтай байж болохыг судлаачдын зүгээс зөвлөж байна.

Өрх ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний нэгжийн үнээс илүү нийт төлбөрийг тооцож байв. Судалгаанд оролцсон нийт өрхийн 61 хувь нь

---

цахилгаан, дулаан, түлш, усны төлбөр өрхийн амьжиргаанд нөлөөлж байна гэж хариулсан бол нийт өрхийн 40.2 хувь цахилгаан эрчим хүч, 49.5 хувь дулаан, түлш, 4.7 хувь усан хангамжийг өрхийн амьжиргаанд хамгийн их нөлөө үзүүлж байна гэжээ.

Цахилгаан эрчим хүчний төлбөрийн нөлөөлөл нь цахилгаан эрчим хүчний хэрэглээ хязгаарлах, өр төлбөр үүсгэх, өрхийн бусад хэрэгцээгээ хязгаарлах шалтгаан болох бөгөөд улмаар өрхийн амьжиргаа доройтдог гэжээ. Түлшний төлбөрийн хувьд өрх нь бусдад өр тавих замаар хэрэглээгээ хангах, хэрэглээгээ хязгаарлах замаар, өөр шатах боломжтой материалиудыг орлуулах, мөн өрхийн бусад хэрэгцээгээ бууруулах замаар шийдвэрлэдэг байна. Гэр хорооллын хувьд өвлийн улиралд түлшний хэрэглээнд цахилгаан эрчим хүчээс илүү ач холбогдол өгч байв.

Цахилгаан эрчим хүчийг Улаанбаатар хотод зөвхөн тоолуур ашиглан түгээх тогтолцоонд оруулах бодлогыг баримтлах, тоолууртай холбоотой үйлчилгээг хөгжүүлэх, зардлыг бууруулах нь чухал байна.

Цаашид гэр хорооллын өрхийн ахуйн хэрэглээний үнэ, төлбөрийн сөрөг нөлөөллийг бууруулах асуудал нь цахилгаан эрчим хүчний үнийн бодлогыг төрийн нийгмийн халамжийн болон байгаль орчны талаарх бодлогуудтай уялдуулах, ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнийг хүргэх үйлчилгээг үзүүлж байгаа байгууллагуудын үйлчилгээний чанар, зохион байгуулалтыг сайжруулах, гэр хороололд цэвэр болон бохир усан хангамж, цахилгаан эрчим хүчний дэд бүтцийг хөгжүүлэхтэй шууд холбоотой юм.

## Бүлэг 5. Ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний нийлүүлэлт

Ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн үйлчилгээг үйлдвэрлэгч, түгээгч байгууллагын удирдлага зохицуулалт, үйл ажиллагааны үр ашигтай, найдвартай тогтолцоо, үйлчилгээний чанар нь өрхийн амьжиргаанд нөлөөлж байдаг талаар өмнө өгүүлсэн. Эдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээний байгууллагуудын удирдлага, бүтэц, тэдний үйл ажиллагааны талаар энэ бүлэгт дэлгэрүүлэн ярилцъя. Эдгээр байгууллагууд нь ихэнхдээ төрийн болон орон нутгийн өмчийн мэдлийн компани хэлбэртэй байгаа бөгөөд ихэнхийг нь ойрын жилүүдэд хувьчлахаар Засгийн газар төлөвлөж байна.

### 5.1 Цахилгаан эрчим хүчний нийлүүлэлт

#### *Бодлого, эрх зүйн орчин*

Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийг УИХ-аар 2001 онд шинэчлэн баталсан. Энэ хууль нь эрчим хүчний зохицуулалтыг боловсронгуй болгох, салбарыг арилжааны хэлбэрт шилжүүлж үйл ажиллагааг нь тогтворжуулахад чиглэсэн. Шинэ хуулиар эрчим хүчний салбарын үнийн зохицуулалт, тусгай зөвшөөрлийн асуудлыг хянах үүрэг бүхий Эрчим хүчний зохицуулах газрыг (ЭХЗГ) бий болгов. Эрчим хүчний салбарт өмчийн олон хэлбэрийг хүлээн зөвшөөрч, төрийн өмчийн үйлдвэрүүдийг бие даан ажиллах нөхцлийг бүрдүүлэв.<sup>22</sup> Шинэ хуулийн үзэл санааг зохицуулах 10 гаруй дүрэм зааврыг боловсруулж мөрдөхөөс одоогийн байдлаар “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үнэ тарифыг тооцох түр аргачлал”, “Төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм”, “Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг тогтоох аргачлалыг батлах” “Олон нийтийн хэлэлцүүлэг явуулах түр журам” зэргийг Эрчим хүчний зохицуулах газраас баталжээ.

Монгол Улсын Засгийн газар 2002 оны 7 дугаар сард баталсан Эрчим хүчний салбарыг хөгжүүлэх стратеги [2003-2010]<sup>23</sup> болон “Эдийн засгийн өсөлтийг дэмжиж ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг”-үүдэд хэрэглэгчдийн төлбөрийн чадварыг бодолцсон үнэ тарифын механизмыг ашиглах замаар нийгмийн эмзэг бүлгийнхэнд эрчим хүчний хүртээмжийг жигд байлгах талаар бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх эхний алхамууд хийгдээд байна.

<sup>22</sup> “Улаанбаатар хотын цахилгаан эрчим хүч хэрэглэгчид”, хуудас [13]. УБ 2004.

<sup>23</sup> “Монгол улсын эрчим хүчний салбарын тогтвортой хөгжлийн стратегид [2003-2010] оруулах хувь нэмэр”, АНУ-ын ОУХА, ЭЗБДТөсөл. УБ 2002.

### **Бүтэц, зохион байгуулалт**

Эрчим хүчний салбар нь шинэ хуулийн дагуу үйлдвэрлэх, дамжуулах, түгээх хуваарилах болон хэрэглэгч гэсэн хэлбэрт шилжиж байна. Удирдлагын босоо тогтолцооноос уян хатан хэвтээ тогтолцоонд шилжив. Өөрөөр хэлбэл үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа нэгжүүд зах зээлийн эрэлт нийлүүлэлтээр үйл ажиллагаагаа зохицуулах боломжтой болсон.

Монгол улсын Засгийн газар, Түлш, эрчим хүчний яам нь салбарын хэмжээнд бодлого боловсруулах, эрх зүйн орчинг бүрдүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих үүргийг хүлээнэ. ЭХЗГ нь зохицуулалт хийх, тусгай зөвшөөрөл олгох, хянах, хүчингүй болгох, тариф тогтоох аргачлал боловсруулах, үнэ тарифын бүтцийг тодорхойлох, зохицуулах зөвлөлийн гишүүдийг мэргэжлийн удирдлагаар хангах үүргийг хүлээх болов. Тус газар нь 2004 оноос эхлэн дараах асуудлаар олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж байна. Үүнд:

- Хэрэглэгчдийн цахилгаан, дулааны үнэ тарифыг өөрчлөх
- Шинээр цахилгаан станц барих, шугам сүлжээ барих
- Бусад асуудлууд

Олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулах талаар 20-иос доошгүй хоногийн өмнө олон нийтэд зарлаж, оролцох хүсэлтэй иргэд, байгууллагыг бүртгэж эхлэнэ. Хэлэлцүүлэгт асуудалд холбогдогч, өргөдөл гаргагч болон бусад сонирхогч талууд оролцоно. Хэлэлцүүлгийг урьдчилан гаргасан удирдамжийн дагуу зохион байгуулна. Эрчим хүчний үнийг өөрчлөх талаар олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг хийх практик нь үнийг өөрчлөх шалтгааны талаар олон нийт нэгдмэл ойлголттой болох замаар үнийн харилцан зөвшилцсөн түвшинг тогтоох боломжийг олгосон билээ.

Эрчим хүчийг үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хуваарилах үйл ажиллагааг ТЭХГ болон түүний харьяа үйлдвэр аж ахуйн газрууд гүйцэтгэх болов. Монгол улсын хэмжээнд нийт 39 үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага ЭХЗГ-аас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр цахилгаан дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах, диспетчерийн зохицуулалт хийх болон эрчим хүчний импортын үйл ажиллагааг эрхэлж байна.<sup>24</sup> Энд бүтэц тогтолцооны хувьд шинэчлэгдэн зохион байгуулагдсан 18 компанийг онцгойлон дурьдаж болно.

Монгол улсын хэмжээнд эрчим хүчний гурван томоохон сүлжээ байгаагийн хамгийн том нь Төвийн бүсийн эрчим хүчний сүлжээ юм. Энэ сүлжээ нь Улаанбаатар хот, 12 аймгийн нутаг дэвсгэрийг хамрах бөгөөд Монгол улсын нийт хүн амын 53 хувь, газар нутгийн 40 хувийг цахилгаан

<sup>24</sup> “Улаанбаатар хотын цахилгаан эрчим хүч хэрэглэгчид”, хуудас [13]. УБ 2004.

эрчим хүчээр хангаж байна гэсэн үг.<sup>25</sup> Төвийн бүсийн эрчим хүчний сүлжээний цахилгаан хангамжийн ерөнхий тогтолцоо, энэ бүтцийн нэгж бүрт ЭХЗГ-аас тогтоосон дундаж үнэ тарифыг дараах схемд үзүүлэв /Схем 5.1-ийг харна уу/.

Хэрэглэгчдийг эрчим хүчээр хангахтай холбоотой үйлчилгээг дүүргүүдийн Эрчим хүчний салбар хариуцаж байна.

### ***Цахилгаан эрчим хүчний салбарын тулгамдсан асуудлууд***

*Цахилгаан, дулааны эрчим хүчний техникийн болон техникийн бус алдагдал өндөр байна.* Олборлосон нийт нүүрсний 85 хувийг дулааны цахилгаан станцуудад нийлүүлсэн ба түүний 48.7 хувийг эрчим хүч үйлдвэрлэх явцад алдагдаж байна. Үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчний алдагдлын 14 хувь дамжуулалт, түгээлтийн явцад алдагдах техникийн алдагдал, 18 хувийг техникийн бус алдагдал эзлэж байна.<sup>26</sup> Техникийн бус алдагдлын дийлэнх хувийг гэр хорооллын ахуйн хэрэглээний хулгай эзлэж байдаг.

Эрчим хүчний зохицуулах газраас жил бүр салбарын алдагдлын хэмжээг тогтоож байдаг. 2005 онд төвийн бүсийн нэгдсэн сүлжээний дулааны станцуудын дотоод хэрэгцээнд ашиглах эрчим хүчний хэмжээг 18.3 хувь, шугамын алдагдлыг 18.3 хувь байхаар тогтоожээ.

### ***Ахуйн цахилгаан эрчим хүчний өрийн асуудал***


УБЦТС ХК-ний нийт өр авлагын хэмжээ 2003 оны байдлаар 8.2 тэрбум төгрөг байгаагаас гэр хорооллын өрх 6.2 тэрбум төгрөгийн, орон сууцны өрх 1.7 тэрбум төгрөгийн, аж ахуйн нэгж 820 сая төгрөгийн тус тус өртэй байна<sup>27</sup>. Үүнээс нийт 3 тэрбум төгрөгийн өрийг эргэн төлөгдөх боломжтой гэж үзэж байна. Өр үүсэж буй шалтгаан нь олон янз байгаа бөгөөд ихэнхдээ өрх төлбөрийн чадваргүй болсонтой холбоотой.

<sup>25</sup> “Монгол улсын эрчим хүчний салбарын тогтвортой хөгжлийн стратегид [2003-2010] оруулах хувь нэмэр” хуудас [49], АНУ-ын ОУХА, ЭЗБДТөсөл. УБ 2002.

<sup>26</sup> Монгол улсын эрчим хүчний тогтвортой хөгжлийн стратегид оруулах хувь нэмэр, хуудас (44), АНУ-ын ОУХА, ЭЗБДТөсөл. УБ 2002.

<sup>27</sup> “Улаанбаатар хотын цахилгаан эрчим хүч хэрэглэгчид”, хуудас [15]. УБ 2004

Схем 5.1 Төвийн бүсийн эрчим хүчний системийн тогтолцоо



Эх сурвалж: “Улаанбаатар хотын цахилгаан эрчим хүч хэрэглэгчид”, хуудас [14]. УБ 2004



## 5.2 Дулааны эрчим хүчний нийлүүлэлт

### ***Бодлого, эрх зүйн орчин***

Эрчим хүчний салбарын бодлого, эрх зүйн талаар өмнөх хэсэгт нилээд дэлгэрэнгүй тайлбарласан билээ. Эдгээр салбар нь эрчим хүч нэрийн дор нэг бодлого, эрх зүйн баримт бичгүүдээр зохицуулагдаж байдаг.

### ***Бүтэц, зохион байгуулалт***

Дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах талаарх бодлогын болон хэрэгжүүлэх асуудлыг Түлш эрчим хүчний яам, түүний харьяа түлш эрчим хүчний агентлаг хариуцаж байна. Улаанбаатар хотод дулааны эрчим хүчний дамжуулах төвлөрсөн системийн үйл ажиллагааг Улаанбаатар хотын дулааны шугам сүлжээ компани, түгээх хуваарилах сүлжээг Дүүргүүдийн орон сууц, ашиглалтын байгууллагууд хариуцаж байна. Төвлөрсөн бус дулаан хангамжийн үйлчилгээг тодорхой байгууллагуудын харьяа жижиг зуухнуудаар хангаж байдаг. Дулааны эрчим хүчний эцсийн хэрэглэгч нь үйлдвэр аж ахуйн газрууд, зөвхөн төвлөрсөн болон төвлөрсөн бус дулааны системд холбогдсон орон сууцны өрхүүд байдаг.

### ***Дулааны эрчим хүчний салбарын тулгамдсан асуудлууд***

Холбогдох яам, агентлагуудаас дулааны хангамжийг сайжруулж чанаржуулах, алдагдлыг бууруулах зорилго бүхий журам, стандартыг боловсруулж мөрдөж байгаа ч хуучин орон сууц, гэр хорооллын хувьд түүнийг мөрдөх боломж багатай байна.

## 5.3 Түлшний нийлүүлэлт

### ***Бодлого эрх зүйн зохицуулалт***

“Монгол улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр” зэрэг салбарын хөгжлийн бодлого боловсруулан УИХ, Засгийн газраар батлуулан хэрэгжүүлж байна. Түлшний хангамжийг сайжруулах зорилгоор “Шингэрүүлсэн шатдаг хийн хөтөлбөр”, “Нүүрсний үйлдвэрүүдийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө”, болон хэрэгжихээр төлөвлөгдсөн төслүүдийн талаар товч мэдээлэл өгсөн билээ.

Түүнчлэн байгаль орчны бохирдлыг бууруулах зорилготой шахмал түлшний үйлдвэр байгуулах, хэмнэлттэй зуух ашиглахыг дэмжих бодлого баримталж байна.

### **Салбарын бүтэц, зохион байгуулалт**

Түлшний салбарын бодлого тодорхойлох, хэрэгжүүлэх үйл ажиллагааг Түлш эрчим хүчний яам болон түлш эрчим хүчний удирдах газар хариуцаж байдаг. Түлшний үндсэн түүхий эд болох нүүрсийг олборлож буй уурхайнууд нь төрийн өмчийн үйлдвэрүүд байх бөгөөд бүтээгдэхүүний зах зээлийн үнийг тухайн аж ахуйн нэгжийн удирдах зөвлөл шийдэж байдаг. Улаанбаатар хотын хувьд гурван том уурхайгаас (Багануур; 3 сая тн, Шарын гол; 700 мянган тн, Шивээ овоо; 600 мянган тн) нүүрс нийлүүлж байна.<sup>28</sup> Түлшний модны хангамж нь зах зээлийн эрэлт нийлүүлэлтээр жижиг үйлдвэрлэгчид шийдэж байдаг.

## **5.4 Улаанбаатар хотын усан хангамж, нийлүүлэлт**

### **Бодлого, эрх зүйн орчин**

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хууль нь хот суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн байгууламжийг ашиглах харилцааг зохицуулна. Дээрх хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тушаалыг Дэд бүтцийн сайд 2003 онд гаргажээ.

### **Бүтэц зохион байгуулалт**

Улаанбаатар хотын нийт хэрэглэгчдийн хэрэгцээт унд, ахуйн цэвэр усыг стандартад тохируулан хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг зайлуулж, цэвэрлэх үйлдвэрлэл үйлчилгээг хүргэх үүргийг Ус Суваг Ашиглалтын Газар (УСАГ) хүлээнэ. Удирдлага зохион байгуулалтын матриц бүтэцтэй бөгөөд захиргаа ба үндсэн үйлдвэрлэл гэж ангилан чиглүүлж зохион байгуулсан.

### **Хэрэглэгчдийг усаар хангах үйлчилгээ**

УСАГ нь дөрвөн эх үүсвэрийн 160 гаруй худгаар дамжуулан хоногт 160 мян.м<sup>3</sup> ус олборлон хотын нийт оршин суугч болон үйлдвэр аж ахуй газруудад түгээж, тэдний бохир усыг татан цэвэрлэж байна. Усны үйлчилгээ, хэрэглээний хувьд орон сууц, гэр хороолол ихээхэн ялгаатай байдаг. Гэр хороололд усан хангамжийг хөгжүүлэх асуудлыг Монгол улсын Засгийн газар, Улаанбаатар хотын Засаг даргын тамгын газар, олон улсын байгууллагууд ихээхэн анхаарч байна.

<sup>28</sup> Монгол улсын эрчим хүчний тогтвортой хөгжлийн стратегид оруулах хувь нэмэр, хуудас (37), АНУ-ын ОУХА, ЭЗБДТөсөл. УБ 2002.

## 5.5 Дүгнэлт

Цахилгаан, дулааны эрчим хүч, нүүрс, усан хангамжийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь төрийн өмчийн компани хэлбэрээр зохион байгуулагдсан байгаа бөгөөд эдгээр байгууллагыг хувьчлах, зах зээлийн харилцаанд шилжүүлэх үйл явц идэвхтэй өрнөж байна. Ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн нийлүүлэгч байгууллагууд нь үйл ажиллагаагаа зах зээлийн харилцаанд шилжүүлэх, тэд төрийн оролцоог багасгах замаар бие даасан, өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчимд шилжих, техник технологийн шинэчлэлтийг хийх замаар найдвартай ажиллагаагаа нэмэгдүүлэх, улмаар зардлаа бууруулахад ихээхэн анхаарч байна. Сүүлийн жилүүдэд эдгээр байгууллагуудад хийгдсэн эрх зүйн болон бүтэц зохион байгуулалтын шинэчлэл нь дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэжээ.

Хэдийгээр эрчим хүчний салбарт шинэчлэл эрчимтэй явагдаж байгаа боловч цахилгаан эрчим хүчийг дамжуулах, түгээх сүлжээнүүд шинэчлэгдээгүй, техник технологийн хувьд хуучирсан, орон байрны дулааны алдагдал өндөр байгаа нь техникийн болон техникийн бус алдагдлыг нэмэгдүүлж байна. Цаашид гэр хороололд шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэх асуудалд анхаарал хандуулах шаардлагатай юм.

Мөн салбарын шинэчлэлтийн бодлогыг төрийн нийгмийн шинэчлэлийн бодлогуудтай уялдуулах, салбар хоорондын зохицуулалтыг сайжруулах асуудлын талаар энэ бүлэгт огт дурьдаагүй.



## Бүлэг 6. Төрийн оролцоо, түүний нөлөөлөл

Зах зээлийн харилцаанд ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн үйлчилгээг ядуу өрхийн хэрэглэгчдэд хүргэхэд төлбөрийн таатай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор төрөөс үнэ тариф, орлогод үзүүлэх дэмжлэг болон техникийн оновчтой тогтолцоог бий болгох арга замыг ашиглаж байдаг. Эдгээр нь ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт, нийлүүлэлтэд нөлөөлнө. Монгол улсын хувьд эдгээр аргууд нь хөгжлийн буюу туршилтын шатандаа байна.

Ахуйн хэрэглээний үр ашигтай дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн техникийн шинэчлэл хийхэд нь цаг хугацаа, хөрөнгө оруулалт ихээр шаардагдаж байдаг. Хөгжиж буй орнуудын хувьд энэ асуудал ихээхэн ач холбогдолтой боловч дангаар ашиглах боломж хязгаарагдмал байдаг. Хөгжиж буй орнуудад үнэ тарифын аргыг ашиглах нийтлэг юм. Ахуйн хэрэглээг дэмжсэн хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх нь хамгийн түгээмэл арга юм.

### 6.1 Үнэ тарифын арга

Монгол улсад эрчим хүч, усны хувьд ядуу өрхийг дэмжсэн бага хэрэглээний үнэ тарифыг хэрэглэх боломжийн талаар яригдаж зарим нэг судалгааг мэргэжлийн байгууллагын түвшинд хийгдсэн байдаг. Эрчим хүчний зохицуулах газраас цахилгаан эрчим хүч ашигласны төлбөрийг ахуйн хэрэглэгчдийн онцлог, амьжиргааны түвшингээс хамаарсан ялгаатай үнэ тарифаар Төвийн эрчим хүчний системд 2005 оны 2-р сараас эхлэн мөрдөх болсон талаар өмнө бүлэгт ярилцсан. Гэр хороололд эрчим хүчний дэмжлэг үзүүлэх үнэ тарифыг анх удаа туршиж байгаа нь сайшаалтай. Гэхдээ шинэ үнэ тарифыг мөрдсөнөөр гэр хорооллын өрхийн цахилгааны хэрэглээ, төлбөр төлөлтөнд хангалттай нөлөөлөхгүй байх магадлал ихтэй. Үүнийг дараах үндэслэлүүдээр тайлбарлаж болох юм. Үүнд:

- Гэр хорооллын ашигласан цахилгаан эрчим хүчний үнэ орон сууцны өрхтэй харьцуулахад багаар тогтоосон үнэн боловч хуучин үнээс өссөн;
- Гэр хорооллын цахилгаан эрчим хүчний хангамж, техникийн нөхцөл муу хэвээр байгаа;
- Хөнгөлөлттэй үнийн бодлого нь нийгмийн чиглэлийн бусад хөтөлбөрүүдтэй холбоогүй;
- Ядуу, эмзэг бүлгийн өрхүүд цахилгаан эрчим хүчийг тоолуургүй ашиглах нь их байна;

Иймд энэ үнэ тарифыг ашигласнаар гэр хорооллын цахилгаан эрчим хүчний хэрэглээ нэмэгдэхгүй байх гэж судлаачдын зүгээс үзэж байна.

Мөн 2 болон 3 тарифт тоолуурыг ашиглах үеийн үнэ тарифыг тогтоогоод байна. Одоогийн хувиараа бизнес эрхэлж байгаа болон цахилгаан эрчим хүчийг дулаалцуулгад ашиглаж байгаа өрхүүдийн хувьд ашигтай юм. Цаашид гэр хорооллын хувьд өвлийн улиралд өрхийн дулаалцуулгад цахилгаан эрчим хүчийг тодорхой хэмжээгээр ашиглах бодлогыг хөгжүүлэх боломжийг бүрдүүлж байна. Гэхдээ энэ бодлогыг хэрэгжүүлэхэд техникийн хувьд шийдвэрлэх шаардлагатай олон асуудал байдаг.

Мөн 2005 оны 4-р сараас эхлэн эмзэг бүлгийн хэрэглэгчдийн цахилгааны үнэд хөнгөлөлт үзүүлэх тарифыг мөрдөнө. Энэ нь ЭХЗГ-ын санаачлага бөгөөд үүнд Засгийн газрын оролцоо, дэмжлэг байхгүй байна. Ийм нөхцөлд эмзэг бүлгийн хэрэглэгчдийн үнэ тарифыг мөрдөх асуудал нилээд байх нь ойлгомжтой. Хэрэгжүүлэгч байгууллага болох түгээх сүлжээний компаниуд хөнгөлөлтийн зөрөөг төлөх бөгөөд энэхүү хөнгөлөлтийг үзүүлэх тогтолцоог бий болгох зардал нь үзүүлж байгаа хөнгөлөлтийнхөө дүнгээс илүү гарч болох талаар өмнөх бүлэгт тайлбарласан. Хэрэгжсэн ч хамрах хүрээ нь хязгаарлагдмал байх нь тодорхой.

Эрчим хүчний зохицуулах газраас эмзэг бүлгийн хэрэглэгчдийн цахилгааны үнийг мөрдөхтэй холбоотой ерөнхий зөвлөмжинд дараах шалгуурыг дурьджээ. Үүнд:

- Өрх хөнгөлөлттэй тарифт хамрагдах хүсэлтэй байх;
- Өмнөх төлбөрийн үлдэгдэлгүй байх, өрийг 6 сарын дотор төлж барагдуулах;
- Хэрэглээг тоолуураар тооцох боломжтой байх;
- Эрчим хүчийг зүй бусаар ашиглагддаггүй байх зэрэг болно.

Эдгээр шалгуур нь өрхийн хүлээх хариуцлагыг тодорхойлсон сайн талтай боловч эмзэг, ядуу өрхийн олонх нь тоолуургүй, өртэй байгаа өнөөгийн нөхцөлд энэ нь хэрэгжих бололцоогүй. Иймээс үүнийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор юуны өмнө айл өрхийг тоолууржуулах, өрийн сүлжээг арилгах, хуваарилах сүлжээг сайжруулах ажлуудыг хийх шаардлагатай. Хамгийн хүндрэлтэй асуудал нь эмзэг, ядуу өрхийг хэн, яаж тодорхойлох вэ гэдэг асуудал байна. Төрөөс үзүүлж байдаг бусад нийгмийн халамжийн хөтөлбөрүүдтэй хэрхэн уялдуулах вэ гэсэн асуудал ч тодорхойгүй байна.

Цахилгаан эрчим хүчний эдгээр тарифыг нийгмийн бусад бодлоготой уялдуулан амжилттай хэрэгжүүлсэн нөхцөлд эмзэг ядуу өрхөд болон эдийн засаг, улсын төсөвт ихээхэн таатай нөлөөг үзүүлэх болно.

## 6.2 Орлогод үзүүлэх дэмжлэгийн арга

Монгол улсад үйлчилж байгаа нийгмийн халамжийн тухай хуулиар ахмад настан, тахир дутуу иргэд, ядуу өрхөд дараах үйлчилгээг үзүүлэхээр заасан байна. Үүнд:

- Хуульд тодорхойлсон шалтгаанаар харьяалах байгууллагагүй амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой ахмад настануудад харьяа орон нутгийн нийгмийн халамжийн газраас эзэмшиж байгаа орон сууцны байрны /талбай, халаалт, цэвэр, бохир усны/ хөлсний 50 хувийг хөнгөлнө.
- Гэр, ердийн галлагаатай сууцанд амьдардаг бол жилд нэг удаа 4 шоо метр түлээ, 4 тн нүүрсний үнэ /тээврийн хөлсийг оруулан тооцож/ -ийн 50 хувийг тус тус нөхөн олгоно.
- Амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой гэр болон ердийн галлагаатай сууцанд амьдардаг өрхөд 2 шоо метр түлээ, 2 тонн нүүрсний үнэ тээврийн хөлсийг оруулан тооцож жилд нэг удаа олгоно.
- Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу гишүүнтэй өрхийн эзэмшиж байгаа орон сууцны байрны хөлс/ талбай, халаалт, цэвэр, бохир усны/ -ийг гэр болон ердийн галлагаатай сууцанд амьдардаг бол жилд нэг удаа 4 тн нүүрс, 4 шоо метр түлээний үнэ/ сум, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний газраас олгоно гэж заажээ.

Амьжиргааны доод түвшингээс доогуур орлогыг тодорхойлох нь нилээд төвөгтэй болох талаар өмнө ярилцсан билээ. Нийгмийн халамжийн үйлчилгээг авах гол шалгуур нь тахир дутуу, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй, өрх амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой байх явдал юм.

Доорх хүснэгтэд 1997-2001 онд нийгмийн халамжийн үйлчилгээний хүрээнд орон байр, түлээ, нүүрсний хөнгөлөлт хүртсэн хүмүүсийн тоог харууллаа<sup>29</sup>. Тухайн үйлчилгээг хүртэгчдийн тоо улсын хэмжээнд бага биш байгаа боловч үйлчилгээ хүртэж байгаа өрхийг сонгон авч байгаа шалгуур, арга зүй ил тод бус, үйлчилгээний үр өгөөж нь хангалтгүй байгаа талаар судалгааны тайланд тэмдэглэсэн байдаг.

<sup>29</sup> Нийгмийн халамжийн үйлчилгээний шинэ шалгуур үзүүлэлтийг боловсруулах ажлын тайлан, АХБ, Улаанбаатар. 2002, хуудас 17-20

**Хүснэгт 6.1 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид**

Үзүүлэлт		Хамрагдсан хүний тоо				
		1997	1998	1999	2000	2001
Гавьяат цолтон, дайнд оролцогсод, төрийн өндөр албан тушаалд ажиллаж байсан ахмад настан болон амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой ахмад настанд үзүүлэх	Орон сууцны талбай, халаалт, цэвэр бохир уусны хөлсний хөнгөлөлт	9506	8753	4488	4062	-
	Түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт	15428	21260	8862	14419	-
Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу гишүүнтэй, амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой өрхөд үзүүлэх	Өрхийн хөлслөн эзэмшиж байгаа байрны талбайн хөлсний хөнгөлөл	735	512	174	425	408
	Гэр, ердийн галлагаатай сууцанд амьдардаг өрхөд түлээ, нүүрс олгох	1016	2272	1286	3376	4024
Нөхөр, эхнэр хоёулаа хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу, хараагүй, дүлий 2 ба түүнээс дээш хүн амьдардаг өрхөд үзүүлэх	Өрхийн хөлслөн эзэмшиж байгаа орон сууны байрны хөлсийг хөнгөлөх	159	152	73	77	70
	Гэр, ердийн галлагаатай сууцанд амьдардаг өрхөд түлээ, нүүрс олгох	10	28	44	32	83

Дараагийн хүснэгтэд дээрх үйлчилгээнд хамрагдсан хүмүүст зарцуулсан нийт хөрөнгийн хэмжээг харууллаа.

**Хүснэгт 6.2 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчдад зарцуулсан хөрөнгө**

Үзүүлэлт		Олгосон хөнгөлөлт (сая төгрөг)				
		1997	1998	1999	2000	2001
Гавьяат цолтон, дайнд оролцогсод, төрийн өндөр албан тушаалд ажиллаж байсан ахмад настан болон амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой ахмад настанд үзүүлэх	Орон сууцны талбай, халаалт, цэвэр бохир уусны хөлсний хөнгөлөлт	93.8	87.1	66.6	65.6	-
	Түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт	346.8	596.4	292.2	543.2	-
Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу гишүүнтэй, амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой өрхөд үзүүлэх	Өрхийн хөлслөн эзэмшиж байгаа байрны талбайн хөлсний хөнгөлөлт	8.5	12.5	4.6	7.3	13.2
	Гэр, ердийн галлагаатай сууцанд амьдардаг өрхөд түлээ, нүүрс олгох	21.2	59.2	42.6	135.6	114.4
Нөхөр, эхнэр хоёулаа хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу, хараагүй, дүлий 2 ба түүнээс дээш хүн амьдардаг өрхөд үзүүлэх	Өрхийн хөлслөн эзэмшиж байгаа орон сууны байрны хөлсийг хөнгөлөх	3.6	6.5	2	3.5	8.1
	Гэр, ердийн галлагаатай сууцанд амьдардаг өрхөд түлээ, нүүрс олгох	0.2	0.6	1	1	2.2

Судалгаанаас харахад түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлтөд зарцуулж байгаа хөрөнгийн хэмжээ нилээд өндөр хэмжээтэй байна. Гэхдээ ядуу, нэн ядуу өрхийн хэдэн хувь энэ үйлчилгээнд хамрагдаж байгаа талаар тодорхой судалгаа алга байна. Улаанбаатар хотод цахилгаан, дулааны эрчим хүч, түлш, усан хангамжийн асуудлыг нийгмийн бусад асуудлуудтай уялдуулсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлага байна.



### 6.3 Техникийн тогтолцоог сайжруулах

Эрчим хүчний салбарын техник технологийг шинэчлэх, салбарын боловсон хүчний чадавхийг хөгжүүлэхэд зориулсан нийт төсөл хөтөлбөрүүдийн мөнгөн дүн 728 орчим сая ам.долларт хүрчээ. Эдгээр төслийн хүрээнд эрчим хүчний түгээх, хуваарилах сүлжээг шинэчлэх, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлууд хийгдэж байгаа бөгөөд эдгээрийн зарим нэгийн талаар дэлгэрүүлж ярилцая.

Дэлхийн банкнаас санхүүжүүлэн хэрэгжүүлж байгаа “Эрчим хүчний салбарын шинэчлэлт” төслийн бүрэлдэхүүн хэсэг болох Улаанбаатар хотын түгээх сүлжээг шинэчлэх дэд төслийн хүрээнд хуваарилах болон дамжуулах сүлжээний трансформатор шинэчлэх, нам хүчдэлийн хуваарилах шугамуудыг бүрээстэй утсаар солих зэрэг ажлуудыг хийж байна. Түүнчлэн гэр хорооллын 80 мянган өрх, 6100 аж ахуйн нэгжийг электрон тоолуураар хангахаар төсөлд тусган хэрэгжүүлж байна. Энэ үйл ажиллагааны хүрээнд ядуу болон нийгмийн эмзэг бүлэгт хамрагдах айл өрхийг илүү хамруулах нь чухал юм.

Мөн АХБ-ны санхүүжилтээр “Дулааны үр ашгийн нэмэгдүүлэх” төслийг гурван багц болгон хэрэгжүүлж байна. Эхний хоёр багцын хүрээнд ДЦС-уудад сүлжээний тоног төхөөрөмжийг шинэчлэх, автоматжуулалтын ажил хийгдсэн. Мөн хуваарилах сүлжээний битүү горимоор ажиллах найдвартай байдлыг хангах зорилгоор 400 тоног төхөөрөмжийг шинэчилсэн. Түүнчлэн томоохон аж ахуйн нэгж, төсвийн байгууллага, орон сууцны айл өрхөд дулааны тоолуур тавих ажлыг хийж байна. Үүний үр дүнд хэрэглэгч өөрсдөө дулааны хэрэглээгээ тохируулах боломж анх удаагаа бүрдэж байна.

### 6.4 Дүгнэлт

Монгол улсын Засгийн газар нь ядуу өрхийн амьжиргаа, ахуйн хэрэглээнд дэмжлэг үзүүлэх зорилгоор үнэ тарифын, орлогод үзүүлэх дэмжлэг, тэтгэлгийн, оновчтой хэрэглээг бий болгох аргуудыг ашиглах талаар нилээд санаачлагатай ажиллаж байгаа боловч цаашид улам ихийг хийх шаардлагатай байна.

Эрчим хүчний зохицуулах газраас цахилгаан эрчим хүчийг ашигласан төлбөрийг ахуйн хэрэглэгчдийн онцлог, амьжиргааны түвшингээс хамаарсан ялгаатай үнэ тарифыг Төвийн эрчим хүчний системд 2005 оны 2-р сараас эхлэн мөрдөх гэж байгаа нь сайшаалтай. Гэхдээ гэр хорооллын болон эмзэг бүлгийн хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний шинэ үнэ нь одоогийн тулгамдсан нийгмийн болон салбарын асуудлыг шийдвэрлэхэд тустай нөлөө үзүүлж чадахааргүй байгаа нь харамсалтай. Эрчим хүчний шинэ үнийн бодлогод салбарын шинэчлэлт болон Засгийн газрын нийгмийн халамж үйлчилгээний үйл ажиллагаануудтай уялдаа холбоо хангалтгүй байна. Эмзэг

бүлгийн хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний үнээс илүү тэдэнд зориулсан цогц хөтөлбөр хэрэгтэй байна.

Монгол улсад үйлчилж байгаа нийгмийн халамжийн тухай хуулиар ахмад настан, тахир дутуу иргэд, ядуу өрхөд түлшний болон орон сууцны хөнгөлөлтийг үзүүлж байна. Гэхдээ энэхүү хөнгөлөлтийн бодлого эрчим хүчний салбарын бодлого үйл ажиллагаа болон Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагаатай уялдаа алга байна. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах бодлоготой зарим талаар зөрчилдөж байна гэж дүгнэхэд дэлсдэхгүй биз ээ.

## Бүлэг 7. Олон улсын туршлага

Энэ бүлэгт Зүүн Ервоп, Төв Азийн хуучин социалист орнуудад өвлийн улирлын эрчим хүчний төлбөрийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд болон Словак улсын орон сууцны хөтөлбөрийн туршлагын талаар ярилцах болно.

### 7.1 Эрчим хүчний төлбөрт дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд<sup>30</sup>

Хуучин социалист орнуудын эрчим хүчний төлбөрт дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд (Energy Payment Assistance Programs) нь тухайн улсуудын Засгийн газрын тодорхойлсон шалгуур үзүүлэлтийг хангасан бага орлоготой өрхөд эрчим хүчний төлбөрийн дэмжлэг үзүүлэх зорилготой шилжүүлэг, бэлэн мөнгөн төлбөрийн хэлбэртэй байна. Энэ нь өвлийн улиралд өрхийн дулааны зардалд хөнгөлөлт үзүүлэх маягаар хэрэгждэг.

Румын болон Болгар улсууд эрчим хүчний салбарын тогтвортой үйл ажиллагааг дэмжиж байхад Армени болон Унгар улсууд эрчим хүчний үнийн хурдацтай өсөлт “үнийн хөөрөгдөл”-ийг даван туулахад чиглэгдсэн богино хугацааны дэмжлэгийн хөтөлбөр, харин Казахстан улс эрчим хүч, усны хэрэглээ, түрээс болон засвар зэрэг өрхийн ахуйн зардалд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлжээ.

Эдгээр улсуудын хөтөлбөрийг дараах нийтлэг шинж чанаруудаар өөр хооронд нь харьцуулан судалсан болно. Үүнд: зорилтот ашиг хүртэгчид ба сонгох шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байдал, төлбөрийн удирдлага ба тоо хэмжээ, хамрах хүрээ, Засгийн газраас гаргаж буй төсөв зэрэг болно.

#### ***Зорилтот ашиг хүртэгчид ба сонгох шалгуур үзүүлэлт***

Болгар улсын өвлийн хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөр нь (Bulgaria's Winter Supplement Program) амьжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхөд дэмжлэг үзүүлэх зорилготой. Энэ хөтөлбөрт хамрагчид нийгмийн янз бүрийн тэтгэлэг болон нийгмийн халамжид хамрагдах боломжгүй өрхүүд байдаг.

Унгар улс энэ хөтөлбөрт хамрагдах өрхийг тодорхой шалгуур үзүүлэлтийн тусламжтайгаар сонгож байна. Гэхдээ эдгээр шалгуур үзүүлэлт, төлбөрийн хэмжээг орон нутгийн засаг захиргаа тухайн орон нутгийн онцлогт нийцүүлэн тогтооход голлох үүрэг гүйцэтгэнэ.

Румын улсад халаалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрт хамрагдах өрхүүд орлогын доод түвшингээс доогуур орлоготой өрх байх

<sup>30</sup> USAID, A Regional Review of Social Safety Net Approaches In Support of Energy Sector Reform, October 2003. page [9-13].

ёстой. Казахстан улсын хувьд өрхийн орлогынхоо 30-аас дээш хувийг ахуйн хэрэглээндээ төлж байгаа бүх өрх хамрагдах боломжтой.

### ***Төлбөрийн удирдлага, тоо хэмжээ***

Эрчим хүчний дэмжлэгийн хөтөлбөрийн ихэнх өрхийн хэрэглэсэн дулааны төлбөр төлөлтөд дэмжлэг үзүүлдэг. Цөөн хөтөлбөрийн хувьд өрхөд үзүүлэх дэмжлэгийг бэлэн мөнгөөр шууд олгож байсан бөгөөд түүнийг өрх дулааны зардалд биш өрхийн бусад хэрэгцээнд /хоол хүнс, эм тариа гэх мэт/ зарцуулж байсан тул үр дүнгүй байв.

Харин Казахстан улс бэлэн мөнгөөр төлбөрийн дэмжлэгийг үзүүлдэг ч төлбөрийн тооцоо хийгдсэн баримтыг үндэслэж нөхөн төлбөр хэлбэрээр олгодог байна. Энэ хэлбэр нь илүү үр дүнтэй байна.

Армени улсад өрхийн дулааны хэрэглээнд бэлэн мөнгөний дэмжлэг үзүүлж байдаг ч зарим талаар бэрхшээлтэй тулгарсан байна. Армени улсын ядуу өрхөд туслах хөтөлбөрийн төлбөрийн сан нь дулааны хэрэглээний гадна өөр өөр хэрэглээнд дэмжлэг үзүүлж байдгаас хангалттай хүрэлцэхгүй болжээ.

Болгар улсын өрхийн цалингийн доод хэмжээ болон өрхийн бодит орлогын зөрүүнээс хамаарч дэмжлэгийн хэмжээ нь сард хамгийн их нь 18.50\$ бөгөөд халаалтын улиралд нийт 93\$ байна. Өвлийн хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд дүүргийн дулаан, цахилгаан эрчим хүчний хангамжийн компаниудад төлбөрийн дэмжлэгийн мөнгийг шууд шилжүүлдэг байна. Харин түлшний дэмжлэгийг өрхөд бэлэн мөнгөөр олгож байна.

Унгар улсын нэг өрхөд дунджаар 15.04\$ олгож байгаа бөгөөд Засгийн газрын зүгээс “Үндэсний сан”-гаас санхүүжих “норматив тэтгэмжийн тогтолцоо”-гоор дамжуулан орон нутгийн засаг захиргаанд дэмжлэг үзүүлдэг ажээ.

Румын улс дулааны төлбөрийн дэмжлэгийг янз бүрийн хэлбэрээр тухайлбал байгалийн хий болон дулаан ашигласны төлбөрийн мөнгөний тодорхой хувийг тухайн компанид шилжүүлэх, халаалтанд ашиглах түлшийг (мод, нүүрс, шингэн түлш г.м) худалдан авахад шаардагдах бэлэн мөнгийг өрхөд олгох зэрэг хэлбэрийг ашиглаж байна. 2002 оны байдлаар нэг өрхийн дулааны төлбөр төлөлтөнд үзүүлсэн дэмжлэгийн дундаж төлбөр 12.30\$ байв.

### ***Эрчим хүч ашигласны дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн зардал, хамрах хүрээ***

Болгар улсад хэрэгжүүлж буй хөтөлбөрт нийт өрхийн бараг 20% хамрагдаж, ашиг хүртэж байна. 1998 онд хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш хамрагдаж буй өрхийн тоо байнга нэмэгдсээр байна. Унгар улсын орон сууцны амьжиргааны түвшин хөтөлбөрийг (Housing Maintenance Program)

Румын болон Болгар улсын хөтөлбөрүүдтэй харьцуулахад хамрах хүрээ бага бөгөөд нийт өрхийн 5% үүний дотор ядуу өрхийн 35% нь хамрагдсан байдаг.

Румын улсад хэрэгжиж буй хөтөлбөр хамрах хүрээгээрээ том бөгөөд 2 сая гаруй өрхөд нийт 88 сая долларын дэмжлэг үзүүлсэн байна. Жилд нэг өрхөд дунджаар 44\$-ийг дэмжлэг үзүүлж байгаа нь сард 8.80\$ болдог ажээ. Казахстан улс орон сууцны тэтгэмжийн хөтөлбөрийг (Housing Allowance Benefit Program) 1996 онд нэг дүүрэгт туршсан бөгөөд 1998 оноос үндэсний хэмжээнд хэрэгжүүлж нийт 150.000 өрх ашиг хүртсэн байна.

### ***Төв болон орон нутгийн түвшин дахь санхүүжилт***

Засгийн газраас орон нутгийн засаг захиргаанд эрчим хүч ашиглахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн санг өсгөх үүрэг хариуцлагыг хүлээлгэж байгаа нь зарим нөхцөлд хялбар биш байдаг байна. Эрчим хүчний дэмжлэг үзүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж буй дөрвөн орны гурав нь төв болон орон нутгийн түвшиний санхүүжилттэй байна.

Болгар улс нь эрчим хүчний дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг улсын төсвөөс санхүүжүүлж байдаг байна. Харин Унгар улс өнгөрсөн хугацаанд улсын төсвийн санхүүжилтээ 70 хүртэл хувиар бууруулж, орон нутгийн төсөвт шилжүүлжээ.

Румын улс хөтөлбөрөө 2002 он хүртэл улсын төсвөөс бүрэн санхүүжүүлж байсан санхүүжилтийнхээ 45%-ийг орон нутгийн засаг захиргаанд хариуцуулсан байна.

### ***Богино хугацааны буюу үнийн хөөрөгдлийн эсрэг нэг удаагийн хөтөлбөр***

Эдгээр хөтөлбөрөөс гадна Унгар улс хий болон цахилгааны үнийн хэт өсөлттэй холбоотойгоор ядуу өрхөд богино хугацааны эрчим хүчинд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлжээ.

Хөтөлбөрийн хүрээнд 1997-1998 онуудад нийт 9 сая долларын санхүүжилтийг Засгийн газар, үйлдвэр, аж ахуйн газрууд хийсэн. Унгар улсын энэ богино хугацааны хөтөлбөр нь Зүүн Европын улсуудад шинэ хандлага, арга зүй болж чадсан. Энэ нь дараах ач холбогдолтой байв. Нэгдүгээрт, бага орлоготой өрхөд дэмжлэг үзүүлэхэд хувийн хэвшлийн байгууллагууд оролцсон туршлага, Хоёрдугаарт, богино хугацааны эрчим хүчний үнийн өсөлтийг урьдчилан таамаглаж үнийн хөөрөгдлийн эсрэг хамтран төлөвлөгөө боловсруулан ажиллаж чадсан явдал байв.

## 7.2 Ядуу өрхөд дэмжлэг үзүүлэх механизм<sup>31</sup>

### **Зохицуулалт хийх**

Зохицуулалт, стандарт мөрдүүлэх нь тухайн өрхөд өөрийн халаалтын хэлбэрээ сонгоход ихэнхдээ хязгаар тогтоож байдаг. Энэ арга нь харьцангуй хялбар бөгөөд бохир түлш, эрчим хүч ашиглах явдалд хязгаарлалт хийх боломжийг нэмэгдүүлдэг сайн талтай. Жишээлбэл: ашиглах түлшний утаа, хорт хийн зөвшөөрөгдөх хэмжээг тодорхойлсон байх, модыг түлшинд ашиглахгүй байхад чиглэсэн зохицуулалт хийх, шаардлага хангаагүй технологийг ашиглахыг хориглох (ердийн зуухны хэрэглээг хязгаарлах) зэрэг арга хэмжээнүүд багтана.

Өрхийн халаалтын шинэ хэлбэр нь чанар өөрчлөгдөхгүйгээр хэрэглээ буурах, цэвэр түлш, эрчим хүчний үнэ, төлбөр бага тохиолдолд хэрэгжих боломжтой. Ерөнхийдөө, ядуу өрх хямд, стандартын бус түлш хэрэглэж заншсан байх бөгөөд халаалтын шинэ хэлбэрийг ашиглахад гарах суурилалтын зардлыг төлөх чадваргүй байдаг. Мөн эцсийн үр дүн, үр ашгийн талаарх ойлголт, мэдээлэл бараг байхгүй байдаг.

### **Татвар ногдуулах**

Зохицуулалт хийх өөр нэг хувилбар нь бохир түлшинд татвар ноогдуулах замаар халаалтын цэвэр хэлбэрийг сонгоход өрхөд нөлөөлөх явдал юм. Бохир түлшинд татвар ногдуулах нь хялбар боловч хууль бус хэрэглээг бий болгож байдаг. Бохир түлшний үндсэн хэрэглэгч нь ядуу, эмзэг бүлгийн хэрэглэгчид байдгаас татвар ногдуулснаар ядуу өрхөд илүү их дарамтыг бий болгодог. Харин энэ аргыг хэрэглэхдээ бохир түлшний татварын орлогыг ядуу, эмзэг бүлгийн цэвэр түлшний төлбөрт нь дэмжлэг үзүүлэх замаар буцаан олгох хувилбар илүү зохимжтой юм.

### **Хөнгөлөлт үзүүлэх**

Түлшинд үзүүлж байгаа бүх төрлийн хөнгөлөлт нь ядуу өрхийн цэвэр түлшний (газ болон эрчим хүч гэх мэт) хэрэглээг дэмжихэд чиглэдэг. Засгийн газраас ийм төрлийн хөнгөлөлт үзүүлэх нь өртөг ихтэй, ядуу өрхийг нийтэд хамруулах боломж багатай байдаг нь зарим хүндрэлийг бий болгодог. Гэсэн хэдий ч энэ арга нь тодорхой асуудлыг цогц байдлаар шийдвэрлэхэд үр дүнгээ өгдөг гэж үздэг. Амьжиргааны хэвийн түвшинтэй өрхүүдэд хөнгөлөлт ядуу өрхөөс илүү үр дүнгээ өгч байдаг. Энэ нь эдгээр өрх цэвэр эрчим хүчийг ашиглахыг илүүтэй эрмэлзэж байдагтай холбоотой /хүснэгт 7.1/. Иймээс хөнгөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэхдээ хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтийг нарийн боловсруулах шаардлагатай байдаг.

<sup>31</sup> Julian A. Lampietti, Anke S. Meyer. 2003. Coping with the Cold: Heating Strategies for Eastern Europe and Central Asia's Urban Poor, the World Bank. Page [24].

**Хүснэгт 7.1 Зүүн Европ ба Төв Азийн хотуудын төвийн эрчим хүчний системд хамрагдсан байдал (хувиар)**

Улс орнууд	Төвлөрсөн дулааны эрчим хүчинд холбогдсон		Төвлөрсөн шингэн түлшинд холбогдсон /газ/		Төвлөрсөн цахилгаан эрчим хүчинд холбогдсон	
	Ядуу	Хэвийн	Ядуу	Хэвийн	Ядуу	Хэвийн
Армени, 1999	11	14	4	16	97	99
Хорват, 1997	15	39	19	30	99	100
Киргиз, 1999	17	55	13	33	100	99
Латви, 1997	70	83	57	68	99	100
Литва, 1998	31	46	47	56	85	94
Молдав, 1999	17	57	37	70	65	89
Таджикстан, 1999	1	1	3	6	100	100

Эх үүсвэр: Өрхийн судалгааны үр дүнг ашиглан хийсэн тооцоо

**Амьжиргааны түвшинтэй уялдуулсан тариф тогтоох**

Түлшний хэрэглээнд үзүүлэх хөнгөлөлтөнд хязгаар тогтоох нь нийтэд нь хөнгөлөлт үзүүлэхээс өртөг багатай байдаг ч Засгийн газрын зарим нийтлэг ашиг сонирхолтой зөрчилддөг. Хэдий тийм ч, төвлөрсөн системд өрхийн хэрэглээг тоолуураар тооцох боломжтой нөхцөлд л амьжиргааны түвшинтэй уялдсан тарифыг ашиглах нь үр дүнтэй. Хуучин системийг нь шинэчлэхэд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардагддаг сул талтай. Ядуу өрхийн ахуйн хэрэглээг зөв тодорхойлох нь амьжиргааны түвшинтэй уялдуулсан хөнгөлөлттэй тарифт хамруулах шалгуур болно.

Ядуу өрхүүд эрчим хүчний системд холбогдож чадахгүй байх тохиолодол илүү бөгөөд энэ нөхцөлд тарифын хөнгөлөлт тэдний амьжиргаанд нөлөөлөхгүй.

**Ваучер**

Ваучер (тэтгэлэг)-ийн хэлбэр нь тухайн хэрэглэгчийн хувийн болон өрхийн онцлог байдалд тохируулан ахуйн хэрэглээний тодорхой хэсгийг хөнгөлөх тасалбар олгох арга юм. Жишээлбэл: өвлийн улиралд ядуу өрх ваучер /тасалбар/-аар керосин олгох нь тэдэнд өөр зүйлд төсөв, цагаа зарцуулах боломжийг олгодог. Ваучерийн хүндрэлтэй зүйл нь хоёрдогч зах зээлд үнэгүйдэх эрсдэл байдаг. Ваучерыг олгох ядуу өрхийг сонгох шалгуурын асуудал хүндрэлтэй. Ваучер нь татвар ногдуулах болон хөнгөлөлт үзүүлэх хэлбэрээс илүү зохион байгуулалт, хяналт шаарддаг. Зөв зохион байгуулсан нөхцөлд илүү үр дүнтэй байдаг бөгөөд нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээг бага зардлаар иргэд, өрхөд хүргэх боломжийг олгодог.

**Төлбөр шилжүүлэх**

Ядуу өрхийн хэрэглээг дэмжих өөр нэг хэлбэр нь өрхийн хэрэглээний тодорхой хэсгийн төлбөрийг хангагч байгууллагад шилжүүлэх арга юм. Энэхүү шилжүүлэг хийх арга нь өрхөд өрхийн төсвөөсөө амьжиргаанд шаардлагатай бусад зүйлд мөнгө зарцуулах боломжийг олгодог. Шилжүүлэгт урьдчилан тодорхойлсон шалгуурын дагуу сонгогдсон өрхүүд хамрагдах



боломжтой. Түүнчлэн шилжүүлэг нь тодорхой ахуйн хэрэглээний зардлын төлбөрийн хэмжээтэй холбоотой учраас ядуу өрхийн суурь хэрэгцээтэй харьцуулахад дэндүү бага байдаг.

### **7.3 Эрчим хүчний дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдийн үр дүнгээс гарсан нийтлэг сургамжууд<sup>32</sup>**

***Эрчим хүчний дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд нь эрчим хүчний салбарын өөрчлөлт шинэчлэлттэй холбоотой нөхцөлд илүү үр дүнтэй байдаг.***

Засгийн газраас бага орлоготой өрхөд үзүүлэх дэмжлэг, туслалцаа нь тухайн оронд мөрдөж буй эрчим хүчний төлбөрийн хэмжээ, эдийн засгийн чадавх болон бусад онцлогоос шалтгаалан ялгаатай байна. Эрчим хүчний төлбөрт дэмжлэг үзүүлж буй хөтөлбөр нь эрчим хүчний салбарын өөрчлөлт шинэчлэлтийг хэрэгжүүлэх явцад гарах үнэ тарифын өсөлт нь бага орлоготой, ядуу өрхөд дарамт учруулахаас хамгаалж чадсан тохиолдолд үр дүнгээ өгнө. Ихэнх хөтөлбөрүүд эцсийн ашиг хүртэгсдэд хангалттай дэмжлэг үзүүлж чаддаггүй нь харамсалтай.

Ахуйн хэрэглэгчид хэрэглээний төлбөрөө цаг хугацаанд нь төлж барагдуулаагүйгээс хангагч, үйлдвэрлэгч байгууллагуудын хэвийн үйл ажиллагаа алдагдаж, улмаар өрийн сүлжээ үүсэж байна. Энэ байдал нь эрчим хүчний хэрэглээний үнийг өсгөх нэг шалтгаан болдог. Хамгийн энгийн зарчим бол хэрэглэгч бүр төлбөрөө цаг хугацаанд нь төлөх явдал юм. Бага орлоготой өрхийн ахуйн хэрэглээний төлбөр төлөлтийг сайжруулах нь энэ зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэх ёстой.

***Эрчим хүчний дэмжлэгийн хөтөлбөр нь орон нутгийн захиргаанд төсвийн хүндрэл болон үр ашгийн аль алийг нь бий болгоно.***

Ийм хөтөлбөр хэрэгжүүлж байгаа ихэнх орны орон нутгийн засаг захиргаа хөтөлбөрийг удирдах, тодорхой хэсгийг санхүүжүүлэх үүргийг хүлээж байна. Энэ нь давуу болоод сул талын аль алинийг нь бий болгож байна. Нэг талаас орон нутгийн төсвийн ачааллыг нэмэгдүүлж байгаа ч, нөгөө талд орон нутгийн түвшинд нийгмийн хамгааллын нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж байдаг.

Румын болон Болгар улсын хувьд орон нутгийн засаг захиргаа эрчим хүчний дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн санхүүжилтэд үүрэг хүлээдэггүй. Эдгээр улсуудын орон нутгийн засаг захиргаа нь эрчим хүчний хангалттай хөтөлбөр, бодлогыг хэрэгжүүлэхгүй байгаагаас бага орлоготой, ядуу өрхүүд амьжиргааны түвшин өндөртэй муж, дүүрэгт шилжин суурьших нь нэмэгдсэн.

<sup>32</sup> USAID, A Regional Review of Social Safety Net Approaches In Support of Energy Sector Reform, October 2003. page [14-20].



Унгар улс орон нутгийн засаг захиргаа үндэсний хэмжээнд тавьж буй ядуурлын эсрэг авч хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилтыг харгалзан үзэлгүй Засгийн газраас хуваарилсан сангийн хөрөнгийг тухайн орон нутгийн хэмжээнд нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай асуудалд зарцуулснаас энэ хөтөлбөрийн зорилго бүрэн биелэгдэхгүйд хүрчээ.

***Өрхийн түлшний дэмжлэгийг бусад дэмжлэгтэй холбохгүй байна.***

Бага орлоготой өрхийн түлшний хэрэглээний зардалд үзүүлж байгаа дэмжлэгийг бусад хөтөлбөр, дэмжлэгтэй уялдуулахгүй байгаа гол шалтгаан нь үзүүлж байгаа дэмжлэгийн хэмжээ бага байгаагаар тайлбарлаж байна. Түлшинд үзүүлж буй дэмжлэгийг өрх бэлэн мөнгө хэлбэрээр авч байгаагаас бусад зардлаа тухайлбал хүнс болон эрүүл мэндэд зардалдаа зарцуулах элбэг байна. Иймээс түлшний төлбөр төлөгдөхгүй өр үүсэж байна. Өрхийн түлшний дэмжлэгийг нийгмийн хамгаалал, халамжийн бусад хөтөлбөртэй уялдуулснаар өрх эрчим хүчний төлбөрөө төлөх баталгааг улам бүр нэмэгдүүлнэ.

Өрхийн түлшний хэрэглээний зардалд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрт хамрагдаж байгаа өрхийг сонгох шалгуур үзүүлэлт хангалтгүйгээс үр дүн нь ч хангалтгүй байна. Өөрөөр хэлбэл, ихэнхдээ зайлшгүй шаардлагатай өрхөө сонгон хамруулж чаддаггүй байна.

***Урьдчилгаа бэлэн мөнгө, эрхийн бичиг (ваучер) өгөхөөс илүү хэрэглээний төлбөрийн тодорхой хувийг төлөх нь үр дүнтэй механизм юм.***

Казахстан улс эрчим хүчний төлбөр төлсөн баримтыг үндэслэн өрхөд нөхөн төлбөр олгосноор өрх эрчим хүч ашигласны төлбөрөө баталгаатай төлдөг болжээ. Румын болон Болгар улсын хувьд төрийн байгууллага, эрчим хүчний компани болон бага орлоготой өрхүүд гурвалсан гэрээ байгуулах замаар өрхийн эрчим хүчний төлбөрийг хөтөлбөрийн сангаас компанид шилжүүлдэг байна. Энэ хэлбэр нь эрчим хүч ашигласны төлбөрийн төлөлтийг сайжруулдаг ч өрхийн хүлээх хариуцлагыг сулруулдаг байна.

Цахилгаан эрчим хүчнээс гадна төвлөрсөн сүлжээнд холбогдоогүй өрхийн түлшний дэмжлэгийг бэлэн мөнгө хэлбэрээр олгож байгаа нь Румын болон Болгар улсын хувьд дараах бэрхшээлүүдийг үүсгэсэн байна.

Болгар улсын түлшинд үзүүлж буй дэмжлэгийн хөтөлбөр нь улс төрийн шинж чанартай байдаг. Өөрөөр хэлбэл, Засгийн газраас түлшний дэмжлэг үзүүлэх нөхцөл нь улсын эзэмшлийн ганц нүүрсний уурхайгаас түлшээ худалдан авсан тохиолдолд үйлчлэхээр хязгаарласан. Засгийн газраас хөтөлбөр хэрэгжүүлж байгаа ч өрхүүд түүнд хамрагдах сонирхлыг бий болгож чадаагүй. Ийнхүү үр дүн багатай туршлагаа үл харгалзан дахин ваучерийн тогтолцоог бий болгохоор Засгийн газар ажиллаж байна.

Румын улсын нийтийн орон сууцны халаалттай байранд амьдардаг өрхүүд халаалтанд хий ашиглаж, өндөр төлбөр төлснийхөө төлөө Засгийн газраас дэмжлэг авахаасаа илүү хатуу түлшийг ашиглах замаар бага зардал гаргах нь дээр гэж үзэж байна. Зарим өрхүүд дэмжлэгийн хөтөлбөрт хамрагдсан хийн халаалтын төлбөрөө төлөхгүй байгаагаас хотын дулаан хангамжийн системд санхүүгийн хямрал нүүрлээд байна.

***Хөнгөлөлтийн хөтөлбөрт хамрагдсан ч ахуйн хэрэглээний төлбөрөө төлөхгүй байх сэтгэл зүй хүчтэй хэвээр байна.***

Эрчим хүчний системийн удирдлага, зохион байгуулалт сайн байгаа нөхцөлд хэрэглээний төлбөрөө төлөхгүй байх үзэгдэл бага гардаг. Ер нь хэрэглэгч төлбөрөө төлөөгүй нөхцөлд эрчим хүчийг нь таслах ёстой. Харин төлбөрөө төлсөн баримтыг үндэслэн эрчим хүчээр шуурхай хангадаг байх нь чухал. Эрчим хүчний үйлчилгээ нь хэрэглэгчид хандсан, тэдний эрэлт хэрэгцээг бүрэн хангаж чадахуйц байх нөхцөлд энэ зарчим үйлчилж байдаг.

Ихэнх хөгжиж буй орны хувьд ахуйн хэрэглээний төлбөрөө төлөхгүй байх явдал нь тулгамдсан асуудлын нэг юм. Энэ нь ихэнхдээ ахуйн хэрэглээний төлбөрөө төлөөгүй хэрэглэгчтэй эвлэрэнгүй ханддаг, тэдний эрчим хүчийг хязгаарладаггүйтэй холбоотой. Мөн ахуйн хэрэглээний төлбөрөө төлөхгүй тохиолдолд хүлээх нийгмийн хариуцлагууд тодорхойгүй байдаг.

Төлбөрөө төлөөгүй өрхийн өрийг Засгийн газрын бодлого, зохицуулалтаар хүчингүй болгож, эрчим хүчний татаас олгож байгаагаас хэрэглэгч, үйлдвэрлэгч талууд өр үүсгэх сонирхолыг дэмжих хандлагыг бий болгодог байна.

Ахуйн зүй бус хэрэглээтэй тэмцэх эрх зүйн тогтолцоо байхгүй нөхцөлд хэрэглэгчид зүй бус хэрэглээний аргуудыг нийтээрээ хэрэглэх нь элбэг байдаг. Тухайлбал, эрчим хүчний тоолуурын гүйлтийг удаашруулах, эрчим хүчийг хулгайгаар ашиглах, цахилгааны байцаагчыг хахуульдах зэрэг аргыг дурьдаж болно.

Ахуйн хэрэглээний төлбөрөө өрхүүд төлөхгүй нөхцөлд тухайн өрхийн эрчим хүчийг таслах техникийн нөхцөл байхгүй, зардал ихтэй байх нь хүндрэл учруулдаг байна. Энэ аргын хувьд эрчим хүчний компанид өөрт ч ашиггүй, эдийн засгийн хувьд ихээхэн хохиролтой байдаг. Айл өрхүүд бохир түлшийг илүү ихээр хэрэглэх, нийгмийн бусад зардлууд өсөх сөрөг үр дагаварыг бий болгож байдаг. Иймээс энэ аргыг орчин үеийн технологтой хослуулан урьдчилан сануулах хэлбэрээр хэрэглэх нь зүйтэй гэж үздэг байна. Унгар улс нь ахуйн хэрэглээний төлбөрөө төлөхгүй өрхийн асуудлыг хуулиар зохицуулахыг оролдож байна.

Төлбөрөө төлөхгүй байх явдалтай тэмцэх хамгийн шилдэг аргыг Казахстан улс боловсруулсан гэж үздэг. Төвлөрсөн халаалттай орон сууцны

өрх ахуйн хэрэглээний төлбөрөө төлөөгүй нөхцөлд эрчим хүчийг нь тасалж хязгаарладаг боловч цахилгаан халаагуур ашиглан орон байраа халааж байгаа хэрэглэгчийн төлбөр төлсөн баримтыг үндэслэн өрхөд гарч байгаа цахилгааны нэмэлт төлбөрийг Засгийн газраас төлдөг байна. Ингэснээрээ агаарын бохирдлыг бууруулахад ихээхэн үр нөлөө үзүүлжээ. Мөн өрхийн түлшний зардал буурсан байна.

#### 7.4 Словакийн орон сууцны тэтгэмжийн хөтөлбөрийн туршлага<sup>33</sup>

##### **Словак улсын өнөөгийн нөхцөл байдал**

Словак улсын эрчим хүч, байгалийн хийн салбарт шинэчлэл үргэлжилж байна. Шинэчлэл хэрэгжсэнээр эрчим хүчний үнэ тариф одоо байгаа түвшинээс 40-өөс 100% хүртэл нэмэгдэнэ гэж тооцож байна. Энэ үнийн өсөлт нь хэрэглэгчид таатай бусаар нөлөөлөх нь тодорхой. Шилжилтийн хугацаанд /2003–2006 онд/ цахилгаан эрчим хүчний тариф 20%-иар, байгалийн хийн тариф 30%-иар, халаалтын тариф 15%-иар жил тутам өсөх хандлага ажиглагдаж байна. Словак улсын нэг өрх өнөөдөр дунджаар өрхийн орлогынхоо 11%-ийг эрчим хүчний төлбөрт зарцуулж байгаа бол энэ нь цаашид улам өсөх юм. Ядуу, бага орлоготой өрхийн талаар хангалттай мэдээлэл байхгүй байгаа ч тэд төлбөрийн одоогийн хэмжээг 18-19%-иар өсгөснөөр ядуу өрхийн орлогынх нь 50-60%-д хүрч магадгүй гэж тооцож байна. Иймд Словак улс 2000 оноос эрчим хүч хэрэглэгч бага орлоготой өрхийн ахуйн хэрэглээнд дэмжлэг үзүүлэхээр “Орон сууцны тэтгэмжийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна.

Орон сууцны тэтгэмжийн хөтөлбөрийн зорилго нь бага орлоготой орон сууцны өрхийн ахуйн хэрэглээний зардлуудыг /түрээс, цахилгаан эрчим хүч, байгалийн хий, бусад түлш, халуун ус болон төвлөрсөн халаалт, ус болон бохиртой холбоотой/ төлөхөд дэмжлэг үзүүлэхэд оршино. Хөтөлбөрт түрээсийн, хувийн орон сууц болон бүх хэлбэрийн эзэмшил бүхий өрхүүд хамрагдах боломжтой.

Өрхөд үзүүлэх орон сууцны тэтгэмжийг (PB) тооцохдоо өрхийн нийт зардалд эзлэх орон сууцны нийт зардлын хувийг тухайн өрхийн нийт орлогоор (Y) үржүүлж, орон сууцны норматив зардлын (MVB) хэмжээнээс (R) хасаж боддог.  $(PB=MVB-RxY)$ . Хөтөлбөрт хамрагдах өрхийг тухайн орон нутгийн нийгмийн хамгаалал, халамжийн байгууллагууд тодорхойлж байдаг.

##### **Орон сууцны норматив зардал /MVB/**

**Орон сууцны норматив зардалд дараах зардлууд хамаарна. Үүнд:**

- түрээс

<sup>33</sup> Alleviation of Social Impacts of Energy tariff Rationalization in Slovakia, World Bank and Regulatory Office for Network Industries, September 2002. page [11-36]

- цахилгаан
- байгалийн хий
- халуун ус болон төвлөрсөн халаалт
- цэвэр болон бохир ус
- хог хаягдал болон бусад
- Өрхийн нийт орлогод орон сууцны зардлын эзлэх хувь /R/

Словак улсын Засгийн газар хөтөлбөрт хамрагдах өрхийг нийт орлогынхоо 29% дээш зарцуулж байх ёстой гэж тодорхойлжээ.

#### **Өрхийн нийт орлого / Y/.**

Өрхийн нийт орлогыг орон нутгийн захиргааны байгууллага дараах үзүүлэлтүүдийн нийлбэрээр тооцон гаргаж байна. Үүнд:

- Нийт орлогоос татвартай холбоотой шимтгэлүүдийг хасах
- Эрүүл мэнд, аваар осол, тэтгвэр болон ажилгүйдлийн даатгалын шимтгэл, хураамж
- Бусад хэлбэрийн тэтгэврийн даатгалын төлбөр
- Орлогын татвар
- Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой зардал
- Орлого бүтээхтэй холбоотой зардал
- Төрөөс үзүүлж байдаг сургалтын тэтгэмж

#### **Нийт орлого дахь нийгмийн тэтгэлгүүд**

- Эрүүл мэнд, тэтгэвэр, даатгалын мөнгө
- Ажилгүйдлийн тэтгэмж
- Хүүхдийн тэтгэмжээс бусад нийгмийн тэтгэмжүүд
- Цэрэг болон гадаадад ажиллаж байгаатай холбоотой тэтгэлгүүд

Орон сууцны тэтгэмжийн хөтөлбөрт өрхийн сарын орлогыг тухайн өрхийн хагас жилийн орлогын нийт дүнг зургаад хуваан тооцдог. Энэ нь өрхийн сарын орлогын зөрүүг багасгана гэж үздэг байна.

#### ***Хөтөлбөрийн эдийн засгийн үр ашиг***

Орон сууцны тэтгэмжийн хөтөлбөр нь эдийн засгийн дараах үр ашиг нөлөөтэй байна. Үүнд

- *Нэгдүгээрт*, Хэрэглэгчид орон сууцны зардлынхаа тодорхой хувийг нөхөн төлбөр хэлбэрээр бөөнд нь авч байдаг.

- *Хоёрдугаарт*, Орон сууцны тэтгэмжийн хөтөлбөр нь татвараар санхүүжиж байгаа учир хөрөнгийн хувьд баталгаажсан байдаг.
- *Гуравдугаарт*, Өрхийн орлого нэмэгдэхийн хирээр тухайн өрхийн авах тэтгэмжийн хэмжээ буурч, ингэснээр тэтгэмж авах эрх нь хязгаарлагдах үед тухайн өрх “ядуурлын гинжин холбоо” болон үнийн нөлөөлөлд өртөхгүй байх чадамжтай болсон байдаг.

Орон сууцны тэтгэмжийн хөтөлбөрийн загварыг боловсруулахад дараах хоёр асуудалд анхаарал хандуулах чухал юм. *Нэгдүгээрт*, Хөтөлбөрийн үр ашгаас өрхүүд адил тэгш хүртэж чаддаггүй. *Хоёрдугаарт*, Хөтөлбөр нь орон сууцны тэтгэмжийн хэмжээ, түрээс, ахуйн хэрэглээний төлбөр хоорондын уялдааг нарийн тооцоогүйгээс сөрөг нөлөөлөл бий болгох магадлал ихтэй. Хэрэглэгчийн үр ашиггүй хэрэглээг багасгах сонирхлыг тэтгэмжийн хөтөлбөр бууруулах хандлага их байдаг.

Хөтөлбөрийн тэтгэмжийн хэмжээг түрээсийн болон хэрэглээний бодит зардлаас гадна норматив зардалд суурилан тооцож байгаагаас хэрэглээний олон талын нөлөөллийг тооцох боломж бага байдаг. Өрхөд үзүүлж тэтгэмжийн үр нөлөө өрх бүрд ялгаатай байдаг.

### ***Хөтөлбөрөөс ашиг хүртэгчид***

Словакийн орон сууцны тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд зорилтот ашиг хүртэгчиддээ хүрч үйлчлэж чадахгүй гэж үздэг. Хөтөлбөрт хамрагдахын тулд өрх байнгын оршин суух газрын бүртгэл, өрхийн орлогын тодорхойлолт, тухайн байрыг түрээслэх эсвэл эзэмших эрхийг баталгаажуулсан баримт бичгүүдийг шаарддаг. Ердийн өрхийн хувьд энэ нь хүнд асуудал биш боловч ядуу өрх эдгээр шаардлагыг хангаж чадахгүй байх нь нийтлэг. Мөн хөтөлбөрт хамрагдах өрх сүүлийн зургаан сарын хугацаанд ахуйн хэрэглээний төлбөр болон үл хөдлөх хөрөнгийн татвар, түрээсээ бүрэн төлсөн байх шаардлагатай. Эдгээрээс шалтгаалан хөтөлбөрт зайлшгүй хамрагдах шаардлагатай олон өрх хамрагдаж чаддаггүй байна.

Түүнчлэн хөтөлбөрт хамрагдсан ч янз бүрийн шалтгаанаар төлбөрөө төлж чадахгүй нөхцөлд хасагдах болно. Жишээлбэл, өрхийн гишүүдийн хэн нэг хүнд өвчин туссаны улмаас эрүүл мэндийн зардал нэмэгдэж, ахуйн хэрэглээний төлбөрөө төлөөгүй бол хасагдах болно. Үүнийг зохицуулах нь нилээд төвөгтэй байдаг байна.

### ***Хамрах хүрээ***

Орон сууцны тэтгэмжийн хөтөлбөрт хамрагдсан өрхийн хувьд хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцох оролцоо бага байдаг. Хөтөлбөрийн талаар иргэдийн мэдээлэл, ойлголт байхгүйтэй холбоотой. Энэ нь хамрагдаж байгаа өрхийн тоо цөөн байхад нөлөөлдөг. Ер нь нийгмийн бусад хөтөлбөрүүдэд хамрагдсан өрхүүд энэ хөтөлбөрт хамрагдах боломжтой

байдаг. Гол шалгуур нь амьжиргааны түвшингээс доогуур орлоготой байх ёстой.

## 7.5 Дүгнэлт

Зүүн Ервоп, Төв Азийн хуучин социалист орнуудад хэрэгжүүлж байгаа эрчим хүчний хөтөлбөрүүдийн арга зүй, туршлага нь Монгол улсын хувьд ихээхэн ач холбогдолтой юм. Эдгээр улсуудын хөтөлбөрүүд нь зорилтот ашиг хүртэгсдийг сонгох шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байдал, төлбөрийн удирдлага ба тоо хэмжээ, хамрах хүрээ, Засгийн газраас гаргаж буй төсөв зэрэг өөр хоорондоо ялгаатай байсан бөгөөд хөтөлбөрүүдийн үр дүн ч өөр хоорондоо ялгаатай байв.

Болгар улс нь эрчим хүчний салбарын тогтвортой ажиллагааг дэмжих зорилго бүхий өвлийн хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийг ядуу өрхүүдийг хамруулан хэрэгжүүлжээ. Хөтөлбөрийг улсын төсвөөс санхүүжүүлсэн бөгөөд улс төрийн шинжтэй байв. Энэ хөтөлбөрт нийт өрхийн 20 орчим хувь хамрагдсан ч хүн амын шилжилт хөдөлгөөн амьжиргааны түвшин өндөртэй бүс нутгууд руу нэмэгджээ.

Унгар улсын хувьд эрчим хүчний үнийн хурдацтай өсөлт, үнийн хөөрөгдлийг даван туулахад чиглэсэн хөтөлбөрийг орон нутгийн засаг захиргаагаар дамжуулан хэрэгжүүлсэн билээ. Энэ хөтөлбөрийн хувьд орон нутгийн засаг захиргаа нь үндэсний хэмжээний ядуурлын эсрэг бодлого, арга хэмжээнүүдтэй уялдуулж авч үзээгүйгээс хөтөлбөрийн зорилго бүрэн хэрэгжээгүй гэж үздэг.

Казахстан улс нь өрхийн ахуйн хэрэглээний зардалд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг өрхийн орлогын 30–аас дээш хувийг ахуйн хэрэглээндээ зарцуулдаг өрхийг хамруулан хэрэгжүүлсэн. Эрчим хүчний төлбөрөө төлсөн баримтыг үндэслэн өрхөд нөхөн төлбөрийг мөнгөн хэлбэрээр олгосон үр дүнгээ үзүүлжээ. Төлбөрөө төлөөгүй өрхийн цахилгаан эрчим хүчийг шууд тасалж байсан боловч цахилгаан эрчим хүчийг өрхийн дулаалцуулгад ашигласан тохиолдолд хэрэглэгчийн төлбөрийн баримтыг үндэслэн нэмэлт зардлыг буцаан олгож байсан нь агаарын бохирдлыг бууруулахад чухал нөлөө үзүүлжээ.

Эдгээр болон бусад улс орнуудын туршлагаас үзэхэд Монгол улсад өрхийн ахуйн хэрэглээг дэмжсэн цогц хөтөлбөрийг боловсруулж ашиглах нь үр дүнтэй арга байх болно. Түүнийг боловсруулахад дээрх орнуудын туршлагыг нарийвчлан судлах нь чухал юм.

## Судалгааны нэгдсэн дүгнэлт, бодлогын зөвлөмж

“Ядуу өрхийн амьжиргаанд үзүүлэх ахуйн хэрэглээний үнийн нөлөөлөл” судалгаа нь ядуу өрхийн амьжиргаанд ахуйн хэрэглээний /цахилгаан дулааны эрчим хүч, хэрэгцээний ус, түлшний зүйлс/ үнийн нөлөөлөл, ахуйн хэрэглээний бүтэц, эрэлтэд гарсан өөрчлөлт, өрхийн амьжиргаа, ядуурлын нийтлэг зүй тогтолыг тодорхойлох, тэдгээрт нөлөөлж байгаа хүчин зүйлийг судлах зорилгоор хийгдсэн билээ.

Судалгааг оролцооны, кейсийн, анкетын асуулгын аргуудыг ашиглан Улаанбаатар хотын 5 дүүргийн 300 орчим өрхийг хамруулан явуулсан бөгөөд асуулгын судалгаанд хамрагдсан нийт 200 өрхийн 80 гаруй хувь нь ядуу өрхүүд, үүний 42 хувь нь нэн ядуу амьжиргаатай өрхүүд байв. Эдгээр өрхийн 8.5 хувь зориулалтын бус орон сууцанд амьдарч, 12.5 хувь ямар нэг шалтгаанаар цахилгаан эрчим хүчээр хангагдаж чадаагүй, 5.5 хувь ундны усандаа гол булаг, шандны усыг ашиглаж байв. Өрхийн амьжиргаанд ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний төлбөр нөлөөлж байна гэж судалгаанд оролцогчдын 61 хувь нь үзжээ.

Судалгаанд хамрагдсан өрхийн амьжиргаа, эдгээрийн ахуйн хэрэглээний түвшинд өрхийн гишүүдийн тоо, боловсрол, мэргэжил, ур чадвар, цалин хөлс, өрхийн амьдарч байгаа орчин, орон байр, гэр бүлийн байдал зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байв. Тухайлбал өрхийн гишүүдийн дундаж тоо 4 байсан ч өрхийн гишүүдийн тоо нь өрхийн амьжиргааны түвшин буурч, ядуурах тусам нэмэгдэх хандлагатай байв. Мөн судалгаагаар нийт өрхийн 30 хувь нь 2 буюу түүнээс дээш өрх хамтдаа нэг орон байранд амьдарч байна гэжээ. Нийт өрхийн гишүүдийн 30.7 хувь хөдөлмөр эрхэлж байгаа болон тэтгэвэр авагч нар байв. Өрхийн тэргүүлэгч болон насанд хүрсэн гишүүдийн боловсролын түвшин бага байх нь ихэнхдээ тухайн өрхийн орлого бага байх шалтгаан гэж оролцогчид тодорхойлж байв.

Судалгаанд хамрагдсан өрхийн ихэнх хувь нь зайлшгүй шаардлагатай хэрэгцээгээ /физиологийн болон аюулгүй байдлын/ хангаж чадахгүй байгаа нь судалгаанд хамрагдсан нийт өрхийн 42 хувьд өрхийн нэг гишүүнд ногдох сарын орлого 10600 төгрөгөөс бага байгаатай холбон үзэж болох юм. Өрхийн сарын дундаж орлого 61000 төгрөг байгаа бөгөөд орлогын гол эх үүсвэр нь цалин, тэтгэврийн орлого байна. Нийт өрхийн 61 хувь нь орлогын нэг эх үүсвэртэй байхад 3 хувь нь огт эх үүсвэргүй байв. Өрхийн орлогын тогтмол бус, хүрэлцээгүй байдал нь өрхийн зарлагын хуваарилалтыг “гал унтраах” хэлбэрээр явуулахад хүргэж байна. Өрхийн нийт зарлагын 48.8 хувийг хүнс, 22.9 хувийг ахуйн хэрэгцээ эзэлж байв. Өрх сард дунджаар 5000 төгрөгийн цахилгаан эрчим хүч, 23000 төгрөгний түлш, 725 төгрөгний хэрэгцээний усыг ахуйдаа тус тус хэрэглэдэг ажээ. Өрх ядуурах гэдгийг тэд бүх хэлбэрийн



нөөцийн хомсдолд орж зайлшгүй шаардлагатай хэрэгцээгээ хангаж чадахгүй эмзэг байдал нэмэгдэх байдлаар ойлгож байна.

Өрхүүд ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнүүд болох цахилгаан, дулааны эрчим хүч, түлш, усыг суурь хэрэгцээгээ хангахад ашиглаж байв. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 96 хувь ердийн зуух пийшинг ашиглан мод нүүрсийг түлж байв. Гэр хорооллын өрх сард дунджаар 1450 л усыг ахуйн хэрэгцээндээ хэрэглэж байгаа нь орон сууцны айл өрхтэй харьцуулахад хэт бага түвшинд байна. Түлш, усыг бэлтгэхэд өрхийн гишүүд тодорхой хэмжээний тооцоологдоогүй хөдөлмөрийг зарцуулж байна. Гэр хорооллын өрхийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ нь орон сууцны өрхтэй харьцуулахад бага байна. Гэр хорооллын зөвхөн гэрэлтүүлэгт ашигладаг гэжээ. Ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнд улирлын нөлөөлөл их байв. Мөн гэр хороололд хүн амын нягтрал нэмэгдэхийн хэрээр өвлийн улиралд агаарын болон орчны бохирдол нэмэгдэж байгааг оролцооны болон кейсийн судалгаанд оролцогчид тэмдэглэжээ.

Ахуйн хэрэглээний эдгээр бүтээгдэхүүний зах зээлийн үнэ бүрдэж байгаа хэлбэр, аргачлал өөр хоорондоо ялгаатай байгаа ч үнэ бүрдэх тогтолцоо нь аажмаар зах зээлийн харилцаанд шилжиж байна. Эдгээр бүтээгдэхүүний үнийн өсөлт нь зах зээлийн хүчин зүйлүүд ялангуяа нефть бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, технологийн шинэчлэлттэй холбоотой байна. Цахилгаан эрчим хүчний үнийн орон сууц, гэр хороолол, эмзэг бүлгийн ялгавартай үнэ тариф нь хэрэглэгчид хандсан үйлчилгээний шинэ алхам болжээ.

Цахилгаан эрчим хүчний төлбөр нь өрхөд цахилгаан эрчим хүчний хэрэглээгээ хязгаарлах, өр төлбөр үүсэх, өрхийн бусад хэрэгцээг хязгаарлах шалтгаан болж байхад түлшний төлбөр өрхөд бусдад өр тавих, хэрэглээгээ бууруулах болон бусад шатах боломжтой материалиудыг ашиглахад нөлөө үзүүлж байв. Өвлийн улиралд гэр хороололд түлшинд цахилгаан эрчим хүчнээс илүү зардал гаргаж байна. Ядуу өрхийн хувьд орон сууц болон гэр хорооллын ахуйн хэрэглээний нийт зардлын мөнгөн дүн ойролцоо байв. Харин эдгээр бүтээгдэхүүнийг хэрэглэсэн тоо хэмжээ нь өөр хоорондоо ихээхэн ялгаатай байлаа.

Ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний үнэ, төлбөртэй холбоотой бодлого үйл ажиллагааг нийгмийн бусад үйл ажиллагаатай уялдуулах нь Засгийн газар төсвийн хөрөнгийг илүү үр өгөөжтэй зарцуулах боломж бий болгохыг судалгаа харуулж байв. Цахилгаан, дулааны эрчим хүч, түлш, усан хангамжийн бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэгч байгууллагуудыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх, хувьчилах замаар төрийн оролцоог багасгах үйл явц идэвхтэй өрнөж байна. Энэ нь өөрөө өөрийгөө санхүүжүүлэх чадавхийг бий болгох, техник технологийн шинэчлэлтийг хийх, эрх зүйн орчинг бүрдүүлэх олон үе шаттай үйл явц юм. Энэ нөхцөлд төрийн бодлого, үйл ажиллагаа нь хоёр талтай байна. Үүнд: нэгдүгээрт дээрх салбарын үйл ажиллагааг зах



зээлийн харилцаанд шилжүүлэх, Хоёрдугаарт нийгмийн эмзэг бүлгийн амьжиргааг дэмжсэн үйлчилгээг бий болгоход чиглэж байна. Төр бодлогоо үнэ тариф, орлогод үзүүлэх дэмжлэг, техник технологийн оновчтой тогтолцоог хөгжүүлэх аргуудаар дамжуулан хэрэгжүүлэхийг зорьж байгаа ч эдгээр арга механизмууд өөр хоорондоо уялдаа холбоо муутай, хангалтгүй байна. Цаашид цахилгаан эрчим хүчний үнэ тарифыг нийгмийн халамжийн бодлогууд, техник технологийн шинэчлэлтэй уялдуулах, улмаар ахуйн хэрэглээг Улаанбаатар хотын агаарын болон орчны бохирдлыг бууруулах бодлого үйл ажиллагаатай холбох нь хөрөнгө нөөцийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх болно гэж судлаачид үзэж байв.

Цаашид ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний үнэ, төлбөрийн өрхийн амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгахад чиглэсэн бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хуучин социалист системийн орнууд болох Төв Ази болон Зүүн Европын орнууд, үүний дотор Казахстан улсын өрхийн ахуйн хэрэглээний зардалд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн туршлагыг ашиглах боломжтой юм.

## **Бодлогын зөвлөмж**

Ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ төлбөрийн бодлогыг нийгмийн халамжийн бодлого болон эдгээр бүтээгдэхүүний техник технологийн шинэчлэлийн бодлоготой уялдуулсан байдлаар цогц хэлбэрээр шийдэх арга замыг хөгжүүлэх;

Улаанбаатар хотод гэр хорооллын цэвэр, бохир усан хангамжийн тогтолцоог хөгжүүлэх;

Юуны түрүүнд ядуу өрхүүд цахилгаан эрчим хүчний тоолуур ашиглах таатай орчинг бүрдүүлэх, тоолуурыг засварлах, баталгаажуулах үйлчилгээг иргэдэд үзүүлэх тогтолцоог хөгжүүлэх;

Улаанбаатар хотын агаарын болон орчны бохирдлыг бууруулах бодлого, үйл ажиллагааг эрчим хүчний үнийн болон нийгмийн халамжийн үйлчилгээтэй уялдуулахад Казакстаны улсын өрхийн ахуйн хэрэглээний зардалд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн туршлагыг ашиглах боломжийг холбогдох байгууллагууд судлах;

## **Хавсралтууд**

## Асуулгын загвар

Ядуу өрхийн амьжиргаанд үзүүлэх ахуйн хэрэглээний үнийн  
НӨЛӨӨЛӨЛ

Судалгааны багийн гишүүд танай өрх болон хувь хүний нууцыг "Хувь хүний нууцын тухай" Монгол улсын хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хадгалах үүрэг хүлээнэ.

Асуултанд хариулах заавар: Та **Код** гэсэн нүдэнд өөрийн сонгосон тухайн хариултын арын тоог нөхөж бичнэ. Нээлттэй асуултанд **бичгээр** хариулна уу.

Асуулга авагчийн нэр: \_\_\_\_\_ Он/ сар/ өдөр \_\_\_\_\_

Хянагчийн нэр: \_\_\_\_\_ Он/ сар/ өдөр \_\_\_\_\_

Өгөгдөл оруулагчийн нэр: \_\_\_\_\_ Он/ сар/ өдөр \_\_\_\_\_

Асуулгын дугаар:  /Албан хэрэгцээнд/

1. Дүүрэг/Аймаг: \_\_\_\_\_ 2. Хороо: \_\_\_\_\_

3. Ам бүлийн тоо:

## Асуултанд хариулагчийн талаарх мэдээлэл

1. Нас:

2. Хүйс: Эрэгтэй - 1 Код:   
Эмэгтэй - 2

3. Боловсролын түвшин:  
Боловсролгүй - 1 Бүрэн дунд - 4 Код:   
Бага - 2 Тусгай дунд - 5  
Дунд - 3 Дээд - 6

4. Эрхэлж буй ажил алба: Код:   
Төрийн албан хаагч - 1 Улирлын чанартай ажил эрхлэгч - 5  
Хувийн хэвшилд - 2 Оюутан - 6  
Төрийн бус байгууллагад - 3 Тэтгэвэр, тэтгэмж авагч - 7  
Хувиараа хөдөлмөр эрхлэгч - 4 Эрхэлсэн тодорхой ажилгүй - 8  
/Хэрэв сүүлийн 6 сар буюу түүнээс дээш хугацаанд хөдөлмөр эрхлээгүй бол/

5. Өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай болох: Код:   
Өрхийн тэргүүн - 1  
Эхнэр, нөхөр - 2  
Хүү, охин - 3  
Эцэг, эх - 4  
Ах, эгч, дүү - 5  
Хадам эцэг, эх - 6  
Хүргэн, бэр - 7  
Өвөг эцэг, эмэг эх - 8  
Ач/зээ, гуч - 9  
Бусад төрөл, төрөгсөд - 10  
Хамаатан бус - 11  
Гэрийн үйлчлэгч, асрагч - 12  
Өөр бусад - 13

**А. Хэсэг: Өрхийн ам бүлийн байдал**

Орлогоо нэгтгэн, нэг сууцанд хамтран амьдарч, хоолож, хувцаслаж байгаа хүмүүсийг өрхийн гишүүд гэнэ. Өрхийн ам бүлийн тоонд 12 сараас дээш хугацаагаар гадагш явсан (хугацаат цэргийн албан хаагч, оюутан, асрамж сувиллын газар, хорих газарт байгаа) тухайн өрхийн гишүүдийг хамруулахгүй.

**1. Өрхийн гишүүдийн талаарх мэдээлэл**

Δ/Δ	Өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай вэ <i>/Зөвхөн тоог нь харгалзах мөрөнд бичнэ үү/</i> Өрхийн тэргүүн - 1 Эхнэр, нөхөр - 2 Хүү, охин - 3 Эцэг, эх - 4 Ах, эгч, дүү - 5 Хадам эцэг, эх - 6 Хүргэн, бэр - 7 Өвөг эцэг, эмэг эх - 8 Ач/зээ, гуч - 9 Бусад төрөл, төрөгсөд - 10 Хамаатан бус - 11 Гэрийн үйлчлэгч, асрагч - 12 Өөр бусад - 13	Нас		Хүйс	Боловсролын түвшин <i>/Суралцаж дүүргэсэн дээд төвшинг бичнэ үү/</i>  Боловсролгүй - 1 Бага - 2 Бүрэн бус дунд - 3 Бүрэн дунд - 4 Мэргэжлийн анхан шатны - 5 Дипломын дээд ба тусгай мэргэжлийн дунд - 6 Дээд/Бакалавр - 7	Гэрлэлтийн байдал <i>/15 ба түүнээс дээш насны гишүүдээс асууна/</i>  Огт гэр бүл болоогүй - 1 Батлуулсан гэр бүлтэй - 2 Батлуулаагүй гэр бүлтэй - 3 Тусгаарласан - 4 Цуцалсан - 5 Бэлбэсэн - 6	Хөдөлмөр эрхлэлтийн байдал <b>Ажилтай:</b> Төрийн болон төсөвт газарт - 1 Хувийн хэвшилд - 2 Бусад байгууллагад - 3 <b>Ажил эрхлээгүй:</b> ХЭА-нд бүртгэлтэй - 4 ХЭА-нд бүртгэлгүй - 5 Тэтгэвэр, тэтгэмж - 6 <b>Сурдаг:</b> ЕБС-д сурдаг - 7 Их, дээд сургуульд - 8 Цэцэрлэг, яслид - 9 Гэртээ байдаг - 10	ЭМД-д хамрагдсан эсэх  Тийм - 1 Үгүй - 2	Удаан хугацаанд өвчтэй байсан эсвэл группт орж байсан эсэх  Тийм - 1 Үгүй - 2
		Нас	сар						
A	A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	
1									
2									
3									
4									
5									
6									
7									
8									
9									
10									
11									
12									
13									
14									
15									

**Б. Хэсэг: Өрхийн амьжиргаа**

1. Та өрхийнхөө амьжиргааны түвшинг тодорхойлно уу.

- Чинээлэг өрх - 1 Код:
- Дундаж өрх - 2
- Дундаас доогуур өрх - 3
- Ядуу өрх - 4
- Нэн ядуу өрх - 5

2. Танай өрхийн зарлагын хамгийн өндөр хувийг ямар төрлийн зардал эзэлдэг вэ? /хамгийн их гэж үзсэн 2 төрлийг сонгоно уу/

- Хүнсний барааны зардал - 1 Код6.1:
- Хүнсний бус барааны зардал - 2 Код6.2:
- Тээвэр, холбооны зардал - 3
- Орон сууцны ахуйн хэрэглээний зардал - 4
- Боловсрол, сургалтын зардал - 5
- Эрүүл мэнд, эмнэлгийн зардал - 6
- Бусад төрлийн зардал /бичнэ үү/ - 7 \_\_\_\_\_

**В. Хэсэг: Өрхийн амьдарч буй орон байрны нөхцлийн талаар**

1. Танай өрхийн амьдарч буй орон байрны төрөл.

- Гэрт - 1 Код:
- Сууцны тусдаа байшинд /Галлагаатай байшин/ - 2
- Нийтийн сууцны байшин доторх сууцанд /Орон сууц/ - 3
- Бусад төрлийн /бичнэ үү/ - 4 \_\_\_\_\_

2. Хэрэв орон сууцанд амьдардаг бол өрөөний тоо:  ←  
/гал тогоо, ванны өрөө, коридорыг оруулахгүйгээр/

3. Таны амьдарч буй орон байрны өмчлөлийн хэлбэр:

- Улсын - 1 Код:
- Хувийн - 2
- Байгууллагын - 3
- Бусад \_\_\_\_\_

4. Таны амьдарч буй орон байрны эзэмшлийн хэлбэр:

- Өөрийн эзэмшлийн - 1 Код:
- Түрээсийн - 2
- Бусад \_\_\_\_\_

5. Энэ сууцандаа хэдэн жил амьдарч байна вэ?

6. Энэ сууцанд/хашаанд одоо хэдэн өрх амьдардаг вэ?

7. Орон байрны халаалт: Код:

- Төвлөрсөн системээр /дулааны шугам сүлжээнд холбогдсон/ - 1
- Төвлөрсөн бус системээр /уурын зуух/ - 2 } B-13
- Ердийн халаалтаар - 3

8. Хэрэв та **Ердийн халаалт** гэж хариулсан бол ямар түлш ашигладаг вэ? /хамгийн өргөн ашигладаг 2 төрлийг сонгоно уу/

- Түлшний мод - 1 Код 8.1:
- Нүүрс - 2 Код 8.2:
- Аргал, хөрзөн - 3
- Цахилгаан халаагуур - 4
- Бусад төрлийн /бичнэ үү/ - 5 \_\_\_\_\_



19. Өрхийн гишүүд хувцсаа ихэвчлэн ямар аргаар угаадаг вэ?

- Гэртээ гараар - 1 Код:   
 Гэртээ угаалгын машинаар - 2  
 Орон сууцанд амьдардаг хамаатан садангийндаа - 3  
 Хими цэвэрлэгээ, угаалгын газарт - 4  
 Бусад /бичнэ үү/ - 5 \_\_\_\_\_

20. Танайх бохир усны зориулалтын шугамтай юу?

- Тийм - 1 → B-22 Код:   
 Үгүй - 2

21. Хэрэв үгүй бол, бохир усаа хэрхэн зайлуулдаг вэ?

- Нүхэн цооногт - 1 Код:   
 Ил задгайгаар - 2

22. Танайх ямар төрлийн бие засах газартай вэ?

- Сууц дотроо: Тусдаа - 1 Код:   
Нийтийн - 2  
 Сууцнаас гадна: Жорлон - 3  
Ил задгай - 4

23. Танайх хатуу хог хаягдлаа хэрхэн зайлуулдаг вэ?

- Хоолойгоор /хогын бункер/ - 1 Код:   
 Төвлөрсөн цэгт - 2  
 Тодорхой цэг байхгүй гэрээсээ ачуулдаг - 3  
 Гуу жалганд хаядаг - 4  
 Бусад /бичнэ үү/ - 5 \_\_\_\_\_

24. Танай өрх цахилгаан эрчим хүч ашиглаж байна уу?

- Тийм - 1 → B-26 Код:   
 Үгүй - 2

25. Үгүй гэж хариулсан бол, цахилгаан эрчим хүч ашиглаж чадахгүй байгаа шалтгаан:

- Төвлөрсөн системд холбогдож чадаагүй -1 Код:   
 Эрчим хүч ашиглах техникийн нөхцөл бүрдээгүй - 2  
 Хэрэглээний хязгаарлалт хийгдсэний улмаас - 3  
 Бусад /бичнэ үү/ - 4 \_\_\_\_\_

26. Танай өрх хичнээн цахилгаан хэрэгсэл ашигладаг вэ?

27. Эрчим хүчийг ямар зорилгоор ихэвчлэн ашигладаг вэ? /хамгийн их гэж үзсэн 2-3-ийг сонгоно уу/

- Зөвхөн гэрэлтүүлэгт - 1 Код 2.1:   
 Халаалтанд - 2 Код 2.2:   
 Гал зүүх, гэр ахуйн цахилгаан хэрэгслийг ажиллуулахад - 3 Код 2.3:   
 Өрхийн жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд - 4  
 Бусад /бичнэ үү/ - 5 \_\_\_\_\_

Дараагийн хуудсанд шилжинэ үү.

**Г. Хэсэг: Өрхийн ахуйн хэрэглээний үнийн амьжиргаанд үзүүлэх нөлөөлөл****Ахуйн хэрэглээний цахилгаан эрчим хүч**

1. Цахилгаан эрчим хүчний төлбөр өрхийн амьжиргаанд нөлөөлдөг үү?

Маш их нөлөөлдөг - 1	Код:	<input type="text"/>
Нөлөөлдөг - 2		
Дунд зэрэг - 3		
Бараг нөлөөлдөггүй - 4	} Г-3	
Огт нөлөөлдөггүй - 5		

2. Нөлөөллийн шууд үр дагаварыг нэрлэнэ үү?

Эрчим хүчний хэрэглээг хязгаарлахад хүргэдэг - 1	Код:	<input type="text"/>
Төлбөрийн өр үүсдэг - 2		
Өөр бусад /бичнэ үү/ - 3		<input type="text"/>

3. Цахилгаан эрчим хүчний үнэ, төлбөр өрхийн гишүүдийн амьжиргаанд ямар нэг нөлөөлөл үзүүлдэг үү? (боловсрол, эрүүл мэнд гэх мэт)

Тийм - 1	Код:	<input type="text"/>
Үгүй - 2	→ Г-5	

4. Хэрэв тийм бол, хэрхэн нөлөөлсөн талаар тодорхой жишээ дурьдана уу.

---



---



---



---



---

5. Цахилгаан эрчим хүчний үнэ, тарифтай холбоотой санал бодлоо хэлнэ үү?

---



---



---



---

**Ахуйн хэрэглээний дулааны эрчим хүч, халаалт/түлш (мод, нүүрс)**

6. Таны халаалт дулаан, түлшинд зарцуулж буй төлбөр өрхийн амьжиргаанд нөлөөлдөг үү?

Маш их нөлөөлдөг - 1	Код:	<input type="text"/>
Нөлөөлдөг - 2		
Дунд зэрэг - 3		
Бараг нөлөөлдөггүй - 4	} Г-8	
Огт нөлөөлдөггүй - 5		

7. Нөлөөллийн шууд үр дагаварыг нэрлэнэ үү.

Түлш, дулааны хэрэглээгээ хязгаарладаг - 1	Код:	<input type="text"/>
Өр тавих - 2		
Өөр шатах боломжтой материал ашиглах - 3		
Өөр бусад /бичнэ үү/ - 4		<input type="text"/>

8. Халаалт дулаан/түлшний үнэ, төлбөр өрхийн гишүүдийн амьжиргаанд ямар нэг нөлөөлөл үзүүлдэг үү? (боловсрол, эрүүл мэнд гэх мэт)

Тийм - 1	Код:	<input type="text"/>
Үгүй - 2	→ Г-10	

9. Хэрэв тийм бол, хэрхэн нөлөөлсөн талаар тодорхой жишээ дурьдана уу.

---



---



---



---

10. Халаалт, дулаан/түлшний үнэ, тарифтай холбоотой санал бодлоо хэлнэ үү?

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

**Ахуйн хэрэглээний ус**

11. Хэрэглээний усны үнэ, төлбөр өрхийн амьжиргаанд нөлөөлдөг үү?

- Маш их нөлөөлдөг - 1 Код:   
 Нөлөөлдөг - 2  
 Дунд зэрэг - 3  
 Бараг нөлөөлдөггүй - 4 }  
 Огт нөлөөлдөггүй - 5 } **Г-13**

12. Нөлөөллийн шууд үр дагаварыг нэрлэнэ үү.

- Усны хэрэглээг багасгадаг - 1 Код:   
 Төлбөрийн өр үүсдэг - 3  
 Өөр бусад хэлбэрээр орлуулдаг /гол, булаг шандны ус/ - 2  
 Өөр бусад /бичнэ үү/ - 4 \_\_\_\_\_

13. Хэрэглээний усны үнэ, төлбөр өрхийн гишүүдийн амьжиргаанд ямар нэг нөлөөлөл үзүүлдэг үү? (боловсрол, эрүүл мэнд гэх мэт)

- Тийм - 1 Код:   
 Үгүй - 2 → **Г-15**

14. **Хэрэв тийм бол**, хэрхэн нөлөөлсөн талаар тодорхой жишээ дурьдана уу.

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

15. Хэрэглээний усны үнэ, тарифтай холбоотой санал бодлоо хэлнэ үү?

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

16. Ахуйн хэрэглээний үнэ, тарифын нөлөөллийг бууруулахад хэн чухал үүрэгтэй оролцох ёстой гэж та үздэг вэ?

- Засгийн газар - 1 Код:   
 Донор байгууллагууд - 2  
 Компани, корпорациуд - 3  
 Өрх өөрсдөө - 4  
 Бусад /бичнэ үү/ - 5 \_\_\_\_\_

**Д. Хэсэг: Иргэдийн санал бодол, ядуурлын талаарх ойлголт**

1. Та орон байрныхаа нөхцөл, цахилгаан дулааны эрчим хүч, халаалт, хэрэглээний усны чанар, хүртээмжинд үнэлгээ өгнө үү. /та мөр бүрийн багананд харгалзах зөвхөн нэг тоог дугуйлна уу./

	Үнэлгээ				
	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
1.1 Өрхийн орон байрны нөхцөл байдал	5	4	3	2	1
1.2 Цахилгаан эрчим хүчний чанар, хүртээмж	5	4	3	2	1
1.3 Халаалт дулааны чанар, хүртээмж	5	4	3	2	1
1.4 Хэрэглээний усны чанар, хүртээмж	5	4	3	2	1



2. Танай өрх ядуурлыг бууруулах чиглэлээр ямар нэг төсөл, хөтөлбөрт хамрагдаж байсан уу?

Тийм - 1  
 Үгүй - 2

Код:

3. **Тийм бол**, Ямар төсөл хөтөлбөрт хамрагдаж байсан бэ?

Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих хөтөлбөр - 1  
 Ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөр - 2  
 Хадгаламж зээлийн хөтөлбөр - 3  
 Ногоон хувьсгал - 4  
 Цагаан хувьсгал - 5  
 Малжуулах төсөл - 6  
 Хамрагдаж байгаагүй - 7  
 Бусад хөтөлбөр, төсөлд - 8

Код:

**Е. Хэсэг: Өрхийн орлого, зарлагын талаар**

Танай өрхийн орлогт эзлэх хэмжээг мөнгөн дүнгээр бичнэ үү.

Хэрэв аль нэг төрлийн орлого нь танай өрхөд байдаггүй бол алгасна уу.

**1. Өрхийн орлого:**

1. Цалингийн орлого
2. Тэтгэвэр, тэтгэмжийн орлого
3. Хувийн бизнесийн орлого
4. Арилжаа наймааны орлого
5. Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого
6. Аж ахуйн орлого /МАА, Газар тариалан/
7. Буцалтгүй тусламж, дэмжлэгийн орлого
8. Зээлийн хүү, түрээсийн орлого
9. Гадаадаас гуйвуулсан мөнгөн орлого
10. Бусад төрлийн орлого

Сүүлийн нэг сард	Сүүлийн нэг жилд	Давтамж

Дараагийн хуудсанд шилжинэ үү.

2. Өрхийн зарлага

2.1 Өрхийн хүнсний хэрэглээ, худалдан авалт

/Ам бүлийн тоотой нь харьцуулж зөвхөн өрхөд хэрэглэснийг нь бичнэ/

А	Нэр төрөл	Сүүлийн сарын нийт хэрэглээ (1=2+4+5)	Сүүлийн сарын хүнсний хэрэглээ, Үүнээс:				Жилийн дундажтай харьцуулахад /01 - 05 дахин их, бага; 06 - 1 дахин их, бага/
			Худалдаж авсан	Бүгд үнэ, төг	Өрхийн аж ахуйгаас хэрэглэсэн	Бусдаас үнэгүй авсан	
А	Б	1	2	3	4	5	6
<b>Мах, махан бүтээгдэхүүн</b>							
1	Хонины мах, кг						
2	Үхрийн мах, кг						
3	Ямааны мах, кг						
4	Адууны мах, кг						
5	Тэмээний мах, кг						
6	Бусад төрлийн, кг						
<b>Сүү, сүүн бүтээгдэхүүн</b>							
7	Сүү, л						
8	Тараг, л						
9	Цөцгийн тос, кг						
10	Бусад төрлийн, л						
<b>Гурил, гурилан бүтээгдэхүүн</b>							
11	Гурил, дээд зэрэг, кг						
12	Гурил, 1 зэрэг, кг						
13	Гурил, 2-р зэрэг, кг						
14	Гоймон, кг				XXX		
15	Талх, ш						
16	Шар будаа, кг				XXX		
17	Цагаан будаа, кг				XXX		
18	Бусад төрлийн, кг						
<b>Төмс, хүнсний ногоо</b>							
19	Төмс, кг						
20	Байцаа, кг						
21	Лууван, кг						
22	Манжин, кг						
23	Сонгино, кг						
24	Бусад төрлийн, кг						
<b>Жимс, жимсгэнэ</b>							
25	Жимс, кг						
<b>Чихэр</b>							
26	Элсэн чихэр, кг				XXX		
27	Бусад төрлийн, кг						
<b>Цай, кофе, ундаа</b>							
28	Ногоон цай, кг				XXX		
29	Ундаа, л						
30	Бусад төрлийн, л						
<b>Архи, тамхи</b>							
31	Архи, л						
32	Пиво, л				XXX		
33	Тамхи /20ш=1х/				XXX		
<b>Амтлагч</b>							
34	Давс, кг						
35	Ургамлын тос, л				XXX		
36	Бусад төрлийн						
<b>Бусад хэрэглээ</b>							
37	Ясли, цэцэрлэг, сургуулийн хоолны үнэ				XXX		
38	Бусад төрлийн				XXX		

## 2.2 Өрхийн хүнсний бус хэрэглээ, худалдан авалт

Хэрэв өрхийн гишүүн бус хүнд өгөхөөр авсан бол үнийн дүнгээр 38-р мөрөнд бичнэ үү.

А	Нэр төрөл	Сүүлийн сард худалдаж авсан		Сүүлийн 12 сард			
		Тоо,ш	Бүгд үнэ, төг	Худалдаж авсан		Бусдаас үнэгүй авсан	
				Тоо,ш	Бүгд үнэ, төг	Тоо,ш	Бүгд үнэ, төг
1	2	3	4	5	6		
<b>Хувцас, гутал</b>							
1	Бэлэн хувцас, гутал						
2	Гэр ахуй, соёлын бараа						
3	Бусад төрлийн бараа бүтээгдэхүүн						
<b>Соёл, гоо сайхан, ахуйн үйлчилгээ (удаа)</b>							
4	Үсчний үйлчилгээ						
5	Гоо сайхны үйлчилгээ						
6	Халуун усны үйлчилгээ						
7	Бусад үйлчилгээ	xxx		xxx		xxx	
<b>Боловсрол</b>							
8	Сургалтын төлбөр, зардал						
9	Ном, сурах бичиг, бичгийн хэрэгсэл						
10	Сонин, хэвлэл, сэтгүүл						
11	Бусад төрлийн зардал	xxx		xxx		xxx	
<b>Эрүүл мэнд</b>							
12	Эм, тариа						
13	АЦХэрэглэл, хөвөн, бинт						
14	Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн						
15	Эмнэлгийн бусад үйлчилгээ	xxx		xxx		xxx	
<b>Тээвэр, холбооны үйлчилгээ</b>							
16	Автобус, такси, хот хооронд	XXX		XXX		XXX	
17	Телефон ашиглалт, ярианы хөлс	XXX		XXX		XXX	
18	Гар утасны төлбөр	XXX		XXX		XXX	
19	Радио	XXX		XXX		XXX	
20	Зурагт,кабелийн ТВ	XXX		XXX		XXX	
21	Бусад үйлчилгээний зардал	XXX		XXX		XXX	
<b>Орон сууц</b>							
22	Сахилгаан, эрчим хүч, квт						
23	Талбайн хөлс	XXX		XXX		XXX	
24	Халаалт	XXX		XXX		XXX	
25	Цэвэр ус (Ундны ус)	XXX		XXX		XXX	
26	Халуун ус	XXX		XXX		XXX	
27	Бохир ус	XXX		XXX		XXX	
28	Хог хаягдал	XXX		XXX		XXX	
29	Үйлчилгээ, лифт гэх мэт	XXX		XXX		XXX	
30	Түлшний мод, м <sup>2</sup>						
31	Нүүрс, тн						
32	Аргал хөрзөн	XXX		XXX		XXX	
33	Бусад зардал	XXX		XXX		XXX	
<b>Бусад зардал</b>							
34	Түрээсийн зардал	XXX		XXX		XXX	
35	Татвар, даатгалын зардал	XXX		XXX		XXX	
36	Зээлийн хүүгийн зардал	XXX		XXX		XXX	
38	БУСДАД ҮНЭГҮЙ ӨГСӨН ЗҮЙЛС	XXX		XXX		XXX	xxxxx

Судалгаанд оролцсонд тань баярлалаа.

Танд болон танай гэр бүлд сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

## Судалгааны багийн гишүүд

### Судалгааны багийн ахлагч:

**Б. Батхүү** Нийгмийн Хөгжлийн Төвийн зөвлөх

### Судалгааны арга зүй болон тайлан боловсруулсан

**Б. Батхүү** Нийгмийн Хөгжлийн Төвийн зөвлөх

**Р. Гантөмөр** Нийгмийн Хөгжлийн Төвийн зөвлөх

**О. Ууганбаяр** Нийгмийн Хөгжлийн Төвийн  
ажилтан

**А. Ундраа** Нийгмийн Хөгжлийн Төвийн  
ажилтан

### Судалгааны хэсэг

#### Судлаачид

**О. Ууганбаяр** Нийгмийн Хөгжлийн Төвийн  
ажилтан

**Р. Бадралмаа** Удирдлагын Академийн багш

#### Тоологч нар

**А. Ундраа** Нийгмийн Хөгжлийн Төвийн  
ажилтан

**Б. Энхтайван** Нийгмийн Хөгжлийн Төвийн  
ажилтан

**Б. Оюунбилэг** ШУТИС-ийн Хүмүүнлэгийн ухааны  
сургуулийн багш

**Н. Ариунтуяа** ШУТИС-ийн Хүмүүнлэгийн ухааны  
сургуулийн багш

## Ном зүй

### Ном зохиол, бодлогын баримт бичиг

1. АНУ-ийн ОУХА. Монгол улсын эрчим хүчний салбарын тогтвортой хөгжлийн стратегид [2003-2010] оруулах хувь нэмэр, УБ 2002.
2. Азийн Хөгжлийн Банк. Аймгуудын төв, хотуудын суурь үйлчилгээг сайжруулах нь, Монгол улс 2003.
3. МУЗГ. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг, Монгол улс 2003.
4. МУЗГ. Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр, УБ 2001.
5. МУЗГ, НХХЯ. Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг, УБ 2003.
6. Ядуурлыг Бууруулах Хөтөлбөрийн Газар, Ядуурлыг Бууруулах Үндэсний хөтөлбөр 1994-2000, УБ 2001.
7. Alex Anas, Kyu Sik lee. 1996. The Benefits of Alternative Power Tariffs for Nigeria and Indonesia, the World Bank.
8. Antony G. Bigio. 1998. Social Funds and Reaching the Poor: Experiences and Future Directions, the World Bank.
9. Ben Rogaly, Thomas Fisher and Ed Mayo. 1999. Poverty in Britain: Social Exclusion and Microfinance, Oxfam GB and New Economics Foundation.
10. Carolyn Gochwenoit. 2003. Regulation of Heat and Electricity Produced in Combined-Heat and Power Plants, The World Bank.
11. Chanyong Park, Meesook Kim. 1998. Current Poverty Issues and Counter Policies in Korea, Korea: Orom Systems Co.
12. Julian A. Lampietti, Anke S. Meyer. 2003. Coping with the Cold: Heating Strategies for Eastern Europe and Central Asia's Urban Poor, the World Bank.
13. Judy L. Baker. 2000. Evaluating the impact of Development Projects on Poverty, The World Bank, USA: Library of Congress Cataloging-in-Publication Data.
14. Joseph K. Konde-Lule and David Okello, User Fees in Government Health Units in Uganda: Implementation, Impact, and Scope, USAID June 1998.
15. James H. Anderson, The Size, Origins and Character of Mongolia's Informal Sector during the Transition, World Bank Policy research working paper 1961, Washington may 1998.
16. G. Socratous. 2000. Water Pricing in Cyprus, University of Cyprus.

17. Nguyen Van Song, Nyugen Van Hahn. October 2001. Electricity Pricing for North Vietnam, Malaysia: Corpcom Sdn. Bhd.
18. Rick Rowden, Joanne Carter. 2000. User Fees on Primary Health and Education, Results Ed. Fund.
19. Soon Won Kwon. 1998. Combating Poverty: Korean Experience, Korea: UNDP Press Office.
20. The World Bank. Reducing Poverty Sustaining Growth: Case study summaries, Shanghai Conference, May 2004.
21. The World Bank and Energy Sector Management Assistance Programme /ESMAP/. Energy Services for the World's Poor, USA 2000.
22. The World Bank. Poverty Reduction Strategy Paper; Resource Book, USA 2000.
23. The World Bank. World Development Report 2000/2001: Attacking Poverty, USA 2001.
24. The World Bank and Regulatory Office for Network Services. Alleviation of Social Impacts of Energy Tariff Rationalization in Slovakia, September 2002.
25. Yogesh Atal. 1999. Poverty in Transition and Transition in Poverty, UNESCO.
26. UNDP. Human Development Report 2003, Millennium Development Goals: A compact among nations to end human poverty, New York Oxford. Oxford University Press 2003.

### **Судалгааны тайлан, хэвлэмэл материал**

27. Б. Батхүү. 2002. Хөдөлмөрийн зах зээл ба хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, Азийн Хөгжлийн Банк.
28. Б. Батхүү, С. Маннила. Монгол улсын нийгмийн салбарын зохион байгуулалт, менежмент, бодлогын зохицуулалт, Азийн Хөгжлийн Банк. 2002.
29. Дэлхийн Банк болон ҮСГ, Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгаа - 2000, УБ 2001.
30. Кит Гриффин. 2001. Монгол дахь ядуурлыг бууруулах стратеги, НҮБХХ.
31. Люиз Фокс. 2000. Шилжилтийн эдийн засаг дахь хамгаалалтын тор.
32. МУЗГ, Азийн Хөгжлийн Банк, НХХЯ. Нийгмийн халамжийн үйлчилгээний шинэ шалгуур үзүүлэлтийг боловсруулах ажлын тайлан, УБ 2003.
33. МУЗГ. НҮБХХ. Монголын хүний хөгжлийн илтгэл – 2003.
34. МУЗГ. НҮБХХ. Монголын хүний хөгжлийн илтгэл – 2000.

35. МУЗГ. НҮБХХ. Монголын хүний хөгжлийн илтгэл – 1997.
36. Нийгмийн Хөгжлийн Төв болон ЖАЙКА. Улаанбаатар хотын цахилгаан эрчим хүч хэрэглэгчид, УБ 2004.
37. Нийгмийн Хөгжлийн Төв. Монгол дахь хувьчлал ба ядуурал, тэгш бус байдлын хамаарал: Мал хувьчлал, судалгааны тайлан. УБ 2003.
38. Нийгмийн Хөгжлийн Төв. Монгол дахь хувьчлал ба ядуурал, тэгш бус байдлын хамаарал: Орон сууцны хувьчлал, судалгааны тайлан. УБ 2003.
39. НҮБХХ болон НХХЯ ХАССТ. Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн, УБ 2004.
40. НҮБХХ, Хүний Эрх Хөгжил төв. Улаанбаатар хотын ядуу иргэдийн нийгмийн хамгаалал, иргэний бүртгэлтийн асуудал, УБ 2004.
41. ҮСГ. Монгол улсын статистикийн эмхтгэл \*2003\*, УБ 2004.
42. ҮСГ. Монгол улсын статистикийн эмхтгэл \*2002\*, УБ 2003.
43. ҮСГ. Монгол улсын статистикийн эмхтгэл \*1999\*, УБ 2000.
44. ҮСГ. Өрхийн орлого, зарлага, Амьжиргааны түвшний түүвэр судалгааны үндсэн тайлан 2002 – 2003 он, УБ 2004.
45. ҮСГ. Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан, УБ 2004.
46. ҮСГ. Цаг ашиглалтын судалгаа, УБ 2002.
47. ҮСГ. Өрхийн орлого, зарлагын судалгаа, УБ 2002.
48. ҮСГ. Монгол улсын хүн ам орон сууцны улсын тооллого - 2000, Монгол улс 2000.
49. Р. Бадралмаа. 2000. Төлбөр тооцох ба цуглуулах системийн гарын авлага, УСАГ-ийн Хөгжлийн Институт.
50. Alta Canadian Geomatics Inc./HABICO. Volume1: Draft Ger Area Upgrading Plan, City of Ulaanbaatar and Canadian International Development Agency. September 2002.
51. Construction and Architecture Corporation and JICA, The Survey Report of the Study of the living environment of the Ger Area in Ulaanbaatar, UB 2002.
52. Caroline Harper. 1994. An Assessment of Vulnerable Groups in Mongolia: Strategies for Social Policy Planning, the World Bank Discussion Papers and The Save the Children Fund.

- 
53. DFID (Department for International Development). UK. September 2000. Halving world poverty by 2015: economic growth, equity and security.
  54. ESMAP. March 2002. Improved Space Heating Stoves for Ulaanbaatar, Mongolia.
  55. ESMAP. October 2001. Energy Efficiency in the Electricity and District Heating Sectors, Mongolia.
  56. Intercontinental Consultants and Technocrats PVT. Ltd. India in association with Pacific Consultants International /Japan/ and Halcrow China Ltd. China and Khot Services Co. Ltd. Mongolia, Social Impact Assessment, January 2004. Ulaanbaatar.
  57. Leo Thomas, Urban Poverty and Development Interventions, INTRAC, UK November 1994.
  58. Michael Reynolds. April 2000. Mongolia Sustainable Livelihoods Project, United Kingdom.
  59. Michael F. Furrster. 1994. Measurement of Low incomes and Poverty in a Perspective of International Comparisons, Paris.
  60. NCC and UNICEF and the Save the Children–UK, Pre-Urban Areas of Ulaanbaatar and other Cities, UB 2002.
  61. Philip J. Glaessner, Kye Woo Lee et al. 1994. Poverty Alleviation and Social Investment Funds: Latin American Experience, the World Bank Discussion Papers.
  62. Soniya Carvalho, Howard White. 1994. Indicators for Monitoring Poverty Reduction, the World Bank Discussion Papers.
  63. The World Bank. March 1992. Electricity Pricing: Conventional Views and New Concepts. Industry and Energy Department, PRE. Working Paper.
  64. USAID, A Regional Review of Social Safety Net Approaches In Support of Energy Sector Reform, October 2003. Mongolia.
  65. UCI and Energy Resources International. March 1995. Institutional and Tariff Study of Central Energy Systems. ADB, Mongolia T.T.No: 2035 MON.
  66. Worcester Regional Research Bureau in partnership with MORE. June 19, 2003. The Use and Abuse of User Fees and Charges.
  67. Walter Schroeder, June 2002. DBRS Methodology in Rating Utilities. CFA.